



САНХҮҮГИЙН  
ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО

# САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТОЙМ 2017







САНХҮҮГИЙН  
ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО

# САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТОЙМ 2017





# ӨМНӨХ ҮГ

Банкнаас бусад санхүүгийн зах зээлийн тогтвортой байдал, өсөлтийг ханган, эдийн засгийн хөгжлийг дэмжих нь Санхүүгийн зохицуулах хорооны 2017 оны тэргүүн зорилт байлаа. Уг зорилтоо хангахын тулд санхүүгийн зах зээлд оролцогчдыг чадавхжуулж, тэдгээрийн эрсдэл даах чадварыг сайжруулах, мөн хэрэглэгчдэд хүрэх санхүүгийн эх үүсвэр, бүтээгдэхүүн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлогыг тууштай авч хэрэгжүүллээ.

Энэ онд үнэт цаасны зах зээлийн үнэлгээ 2.4 их наяд төгрөг болж түүхэндээ хамгийн өндөр түвшинд хүрлээ. Олон нийтэд шинээр санал болгосон үнэт цаас бүр амжилттай арилжаалагдаж, тус бүрийн анхны захиалга 200–300 хувиар давж биелсэн нь хөрөнгийн зах зээлийн эрэлт, энэ зах зээлд оролцох хөрөнгө оруулагчдын сонирхол өндөр байгааг илтгэн харуулав. Даатгалын салбарын нийт хөрөнгө 2016 оныхоос 17.4, нөөц сангийн хуримтлал 26.9, цэвэр ашиг 15.7 хувиар өслөө. Даатгуулагчдаас цуглуулсан хураамжийн орлого 26.1 хувиар нэмэгдсэн бол тэдэнд буцааж олгосон нөхөн төлбөрийн хэмжээ 31.9 хувиар өссөн байна. Банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгө 969.2 тэрбум төгрөг болж, зах зээл дэх зээлийн бүтээгдэхүүний нийлүүлэлт сайжрав. Үйлчилгээний хүртээмж нэмэгдэж, зээлийн бүтээгдэхүүний үнэ болох хүүгийн түвшин буурлаа. Хадгаламж, зээлийн хоршоодын нийт хөрөнгө сүүлийн 10 гаруй жилд анх удаагаа 30–аас дээш хувиар өсөж, 2016 оныхоос 35.4 хувиар нэмэгдэн, чанаргүй зээлийн хэмжээ өнгөрсөн оныхоос 1.2 пунктээр буураад байна.

Мэдээллийн технологийн үсрэнгүй хөгжил дэвшил эдийн засаг, нийгмийн бүхий л салбарт шинэ шинэ боломж бололцоог нээж буй энэ цаг үед санхүүгийн зах зээлийг улам хөгжүүлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, хүртээмж, нэр төрөл, арга хэлбэрийг нэмэгдүүлэх, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ, эрх ашигт нийцэх байдлыг сайжруулах бодлогыг түлхүү баримтлах нь зүйтэй гэж үзэж байна.

Хороо өнгөрсөн онд батлагдсан “Санхүүгийн салбарыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр–2025” болон дунд хугацааны стратегийн зорилтынхоо хүрээнд санхүүгийн салбарыг эрчимтэй хөгжүүлж, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг нэмэгдүүлэх, улмаар банк, хөрөнгийн зах зээл, даатгал, бичил санхүүгийн салбарууд жигд хөгжсөн олон тулгуурт санхүүгийн салбарыг бий болгон хөгжүүлэх зорилгоо цаашид тууштай хэрэгжүүлж ажиллахаа онцлон, эрхэм Танд банкнаас бусад санхүүгийн зах зээлийн 2017 оны тоймыг толилуулж байна.

Өөдрөг сайхан бүхэн үргэлжлэн дэлгэрэх болтугай.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ

ХОРООНЫ ДАРГА

 С.ДАВААСҮРЭН



Эдийн засгийн байнгын хороо СЗХ-ны үйл ажиллагаатай танилцаж зэрэг үнэлгээ өгөв.



Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимд ажлаа танилцуулсан анхны төрийн байгууллага болов.



Япон улсын санхүүгийн үйлчилгээний агентлаг “Хамтын ажиллагааг өргөжүүлэх санамж бичиг” байгуулав.

Монголбанктай харилцан ойлголцлын санамж бичиг байгууллаа.



ББСБ-уудын ХНХ-ийн хэмжээг газар зүйн байршлаас хамааран ялгавартай тогтоолоо.





Implemented by  
**giz**

GIZ, GLAC, A2II нартай хамтарсан хүртээмжтэй даатгалыг хөгжүүлэх төсөлд СЗХ сонгогдлоо.



Олон улсын хөрөнгө оруулалтын банктай 200 мянган долларын техник туслалцааны “Харилцан ойлголцлын санамж бичиг” байгууллаа.

ICURN гишүүн байгууллага болов.



Олон улсын байгууллагуудтай хамтран төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхээр боллоо.



СЗХ-ны дарга С.Даваасүрэн Олон улсын санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг/AFI/-ийн Захирлуудын зөвлөлийн гишүүнээр сонгогдов.



# АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ

ОН ЦАГИЙН ХЭЛХЭЭ

ЖАГСААЛТ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

I. ХУРААНГУЙ ТОЙМ 2017 .....	16
1.1 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ .....	16
1.2 ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ .....	17
1.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА .....	18
1.4 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО .....	19
II. САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ .....	22
2.1 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ .....	22
2.1.1 ХУВЬЦААНЫ ЗАХ ЗЭЭЛ .....	23
2.1.2. БОНДЫН ЗАХ ЗЭЭЛ .....	26
2.1.3 ХАА–Н ГАРАЛТАЙ БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ .....	27
2.2 ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ .....	28
2.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА .....	32
2.4 ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН .....	36
2.5 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО .....	37
III. ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ .....	44
3.1 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ .....	44
3.1.1 ХАА–Н ГАРАЛТАЙ БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ .....	48
3.2 ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ .....	48
3.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА .....	50
3.4 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО .....	52



IV. БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ .....	58
4.1 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ .....	58
4.1.1 ХУВЬЦААНЫ ЗАХ ЗЭЭЛ .....	58
4.1.2 БОНДЫН ЗАХ ЗЭЭЛ .....	59
4.1.3 ХАА–Н ГАРАЛТАЙ БАРАА, ТҮҮХИЙН ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ .....	60
4.2 ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ .....	61
4.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА .....	64
4.4 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО .....	66
V. АШИГТ АЖИЛЛАГАА .....	74
5.1 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ .....	74
5.1.1 ХАА–Н ГАРАЛТАЙ БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ .....	76
5.2 ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ .....	77
5.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА .....	79
5.4 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО .....	82
VI. ТОГТВОРТОЙ БАЙДАЛ .....	86
6.1 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ .....	86
6.2 ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ .....	87
6.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА .....	90
6.4 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО .....	93
VII. БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН .....	98
7.1 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ .....	98
7.2 ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ .....	100
7.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА .....	102
7.4 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО .....	103
VIII. ХАВСРАЛТ .....	105

## ЗУРАГНУУД

Зураг 1.	ҮЦК–уудын тоо .....	23
Зураг 2.	Хөрөнгийн зах зээлийн бүтэц.....	23
Зураг 3.	ЗЗҮ болон хөрвөх чадвар.....	24
Зураг 4.	ТОП–20 индекс .....	25
Зураг 5.	MSE–ALL индекс.....	25
Зураг 6.	ЗГҮЦ–ны арилжаа .....	26
Зураг 7.	ЗГҮЦ–ны арилжаа /тэрбум төгрөг/ .....	26
Зураг 8.	ХАА–н биржийн арилжаа .....	27
Зураг 9.	МАРІХ индекс .....	28
Зураг 10.	Даатгалын зах зээлийн бүтэц .....	28
Зураг 11.	Ердийн даатгалын компаниудын хураамжийн орлогын зах зээлд эзлэх хувь .....	29
Зураг 12.	Даатгалын гүнзгийрэлтийн түвшин .....	30
Зураг 13.	Даатгалын салбарын нийт хөрөнгө.....	30
Зураг 15.	Хураамжийн орлого.....	31
Зураг 14.	Даатгалын компанийн хөрөнгийн өсөлтийн тархалт .....	31
Зураг 16.	Нөхөн төлбөр, давхар даатгалын хураамж.....	32
Зураг 17.	Нөөц сангийн хэмжээ, өсөлт .....	32
Зураг 18.	ББСБ–уудын тоо .....	33
Зураг 19.	Нийт хөрөнгийн өсөлт.....	33
Зураг 20.	ББСБ–уудын тоо, салбарын нийт хөрөнгөд эзлэх хувиар .....	33
Зураг 21.	Нийт зээлийн өсөлт .....	34
Зураг 22.	Зээлийн төрөл /валютаар/.....	34
Зураг 23.	Зээлийн төрөл /чанараар/ .....	34
Зураг 24.	Олгосон болон төлөгдсөн зээл /зориулалтаар/ .....	35
Зураг 25.	Зээлийн хүү.....	35
Зураг 26.	Олгосон батлан даалтын тоо.....	36
Зураг 27.	Олгосон батлан даалтын хэмжээ /тэрбум төгрөг/ .....	37
Зураг 28.	ХЗХ–дын тоо, аймгаар.....	38
Зураг 29.	ХЗХ–дын тоо болон гишүүдийн тоо.....	38
Зураг 30.	Нийт хөрөнгө ба хадгаламж /тэрбум төгрөг/ .....	39
Зураг 31.	Хөрөнгийн хэмжээнд эзлэх хувь /хөрөнгийн бүлгээр/ .....	39
Зураг 32.	ҮЦК–уудын байршлын тархалт .....	44
Зураг 33.	ЗЗҮ өндөр 10 компани /салбараар/.....	45
Зураг 34.	ЗЗҮ өндөр 10 ХК–ийн хувьцааны төвлөрөл .....	45



Зураг 35.	Шинээр нээгдсэн данс .....	47
Зураг 36.	Хөдөө орон нутгууд дахь брокеруудын байршил.....	48
Зураг 37.	Даатгалын нягтрал /төгрөг/.....	48
Зураг 38.	Даатгалын компани, зуучлагч, хохирол үнэлэгч компаниудын салбар, төлөөлөгчийн газрын байршил .....	49
Зураг 39.	Даатгалын компани, зуучлагч, хохирол үнэлэгч компаниудын салбар, төлөөлөгчийн газрын байршил /дүүргээр/ .....	49
Зураг 40.	ББСБ–уудын тархалт /газар зүйн байршлаар/.....	50
Зураг 41.	ББСБ–уудын тархалт /дүүргээр/.....	50
Зураг 42.	ББСБ–уудын хүртээмж /бүсээр/ .....	51
Зураг 43.	ББСБ–уудын хүртээмж /дүүргээр/.....	51
Зураг 44.	Зээлийн үйлчилгээний хүртээмж, байршлаар /мянган төгрөг/.....	52
Зураг 45.	ББСБ–уудын харилцагчид /хүйсээр/ .....	52
Зураг 46.	ББСБ–уудын харилцагчид /насны бүлгээр/ .....	52
Зураг 47.	Монгол Улсын 18–64 насны эдийн засгийн идэвхтэй хүн амын тоонд нийт гишүүдийн эзлэх хувь .....	53
Зураг 48.	18–64 насны эдийн засгийн идэвхтэй хүн амын тоонд нийт гишүүдийн эзлэх хувь /бүсээр/.....	54
Зураг 49.	Хадгаламжийн хэмжээ эзлэх хувь /бүлгээр/.....	54
Зураг 50.	Нэг гишүүнд ногдох хадгаламжийн хэмжээ, байршлаар /сая төгрөг/ .....	55
Зураг 51.	Нийт арилжааны бүтэц /үнийн дүнгээр/ .....	58
Зураг 52.	Нийт арилжааны бүтэц /хэмжээгээр/.....	58
Зураг 53.	Хувьцааны гүйлгээний дүн /тэрбум төгрөг/.....	59
Зураг 54.	Хөрөнгө оруулагчдын хувьцааны зах зээлийн арилжаанд эзлэх хувь .....	59
Зураг 55.	Хөрөнгө оруулагчдын ЗГҮЦ–ны зах зээлийн арилжаанд эзлэх хувь .....	60
Зураг 56.	Хөрөнгө оруулагчдын компанийн бондын арилжаанд эзлэх хувь.....	60
Зураг 57.	ХАА–н гаралтай бараа, түүхий эдийн арилжаа /тэрбум төгрөг/ .....	60
Зураг 58.	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал, хураамж, нөхөн төлбөр /тэрбум төгрөг/.....	61
Зураг 59.	Зуучилсан даатгалын нийт хураамжийн орлого /бүтээгдэхүүнээр/ .....	62
Зураг 60.	Зуучлалын шимтгэлийн орлого /бүтээгдэхүүнээр/ .....	62
Зураг 61.	Даатгалын хохирол үнэлгээний орлого /бүтээгдэхүүнээр/.....	63
Зураг 62.	Даатгалын төлөөлөгчийн хураамжийн орлого /бүтээгдэхүүнээр/.....	63
Зураг 63.	ББСБ–уудын тоо /үйлчилгээний төрлөөр/.....	64
Зураг 64.	Үйл ажиллагааны орлого /төрлөөр/.....	65
Зураг 65.	Хүүгийн бус орлого .....	65

Зураг 66.	Хүүгийн орлогын бүтэц /хувиар/ .....	67
Зураг 67.	Хүүгийн зардлын бүтэц /хувиар/ .....	67
Зураг 68.	Тайлангийн үзүүлэлт /тэрбум төгрөг/ .....	74
Зураг 69.	Орлогын бүтэц .....	74
Зураг 70.	Зардлын бүтэц .....	75
Зураг 71.	ҮЦК–уудын нийт хөрөнгийн болон өөрийн хөрөнгийн өгөөж .....	75
Зураг 72.	Тайлангийн үзүүлэлтүүд /тэрбум төгрөг/ .....	76
Зураг 73.	Цэвэр ашиг .....	77
Зураг 74.	Голлох харьцаанууд .....	78
Зураг 75.	Нийт хөрөнгийн болон өөрийн хөрөнгийн өгөөж .....	78
Зураг 76.	ББСБ–уудын орлого, зарлага, ашгийн динамик /тэрбум төгрөг/ .....	79
Зураг 77.	Нийт хөрөнгийн болон өөрийн хөрөнгийн өгөөж .....	79
Зураг 78.	ББСБ–уудын тоо, өөрийн хөрөнгийн өгөөжийн ангиллаар .....	80
Зураг 79.	ББСБ–уудын тоо, нийт хөрөнгийн өгөөжийн ангиллаар .....	80
Зураг 80.	ББСБ–уудын хөрөнгийн өгөөж /хувь нийлүүлсэн хөрөнгөөр/ .....	80
Зураг 81.	Зээлийн үйлчилгээнээс олох орлого /тэрбум төгрөг/ .....	81
Зураг 82.	Зардал, орлогын харьцаа .....	81
Зураг 83.	ХЗХ–дын орлого ба зарлага /тэрбум төгрөг/ .....	82
Зураг 84.	Ашигт ажиллагааны өсөлт .....	82
Зураг 85.	Нийт хөрөнгийн болон өөрийн хөрөнгийн өгөөж .....	83
Зураг 86.	Индексүүдийн 5 жилийн гулсах корреляци хамаарал .....	86
Зураг 87.	ТОП 20, Nikkie 225, FTSE 100 индексүүдийн сарын өгөөжийн 6 сарын гулсах дундаж .....	87
Зураг 88.	Индексүүдийн 24 сарын дундаж хэлбэлзлэл .....	87
Зураг 89.	Давхар даатгалын хураамж ба ам.долларын ханш .....	89
Зураг 89.	Даатгалын нийт хөрөнгө оруулалт ба хадгаламжийн жигнэсэн дундаж хүү .....	90
Зураг 90.	Хөрөнгийн хүрэлцээт байдлын харьцаа .....	91
Зураг 91.	Зээлийн эрсдэлийн сангийн харьцаа .....	91
Зураг 92.	Чанаргүй зээлийн хувь .....	91
Зураг 93.	Хөрвөх чадварын харьцаа .....	92
Зураг 94.	Дистанс дистресс харьцаа .....	92
Зураг 95.	Нийт зээл ба чанаргүй зээл /тэрбум төгрөг/ .....	93
Зураг 96.	Чанаргүй зээлийн чанарын үзүүлэлт /эзлэх хувиар/ .....	93
Зураг 97.	Нийт хөрөнгө болон зээлийн эрсдэлд орох үзүүлэлт .....	94
Зураг 98.	Хөрвөх чадварын харьцаа .....	94

## ХҮСНЭГТҮҮД

Хүснэгт 1. Зохицуулалттай этгээдийн тоо .....	22
Хүснэгт 2. ХЗХ–дын статистик үзүүлэлт .....	37
Хүснэгт 3. ХЗХ–дын актив ба пассивын ерөнхий үзүүлэлт /тэрбум төгрөг/ .....	40
Хүснэгт 4. ЗЗҮ өндөр 10 компани /тэрбум төгрөг/ .....	45
Хүснэгт 5. ҮЦТХТ–д бүртгэлтэй хувьцаа /мянган ширхэг/ .....	46
Хүснэгт 6. Хаалттай ХК–ийн нэрс .....	46
Хүснэгт 7. ҮЦТХТ–д бүртгэлтэй бонд /мянган ширхэг/ .....	47
Хүснэгт 8. ХЗХ–дын нийт тоо /байршлаар/ .....	53
Хүснэгт 9. Үнэт цаас гаргагчийн өмчийн бүтэц .....	58
Хүснэгт 10. Нийт орлого /тэрбум төгрөг/ .....	76

## ШИГТГЭЭНҮҮД

Шигтгээ 1. Олон улсад өрнөсөн онцлох үйл явдал .....	25
Шигтгээ 2. Монгол Улсын бондын арилжаа .....	27
Шигтгээ 3. Олон улсын даатгалын зах зээлийн өнөөгийн байдал .....	29
Шигтгээ 4. Олон улс дахь бичил санхүүгийн салбарын тоон үзүүлэлт .....	35
Шигтгээ 5. Олон улсын хадгаламж, зээлийн хоршоодын зах зээл .....	53
Шигтгээ 6. KILMO SALAMA (аюулгүй хөдөө аж ахуй) – Индексэд суурилсан хөдөө аж ахуйн даатгал .....	64
Шигтгээ 7. ФИНТЕК & РЭГТЕК .....	66
Шигтгээ 8. MEFIN 2017 оны жилийн тайлангаас .....	90

## ХАВСРАЛТУУД

Хавсралт 1. Хөрөнгийн зах зээл статистик үзүүлэлт /тэрбум төгрөг/ .....	105
Хавсралт 2. Даатгалын зах зээлийн статистик үзүүлэлтүүд /тэрбум төгрөг/ .....	106
Хавсралт 3. ББСБ–ын салбарын статистик үзүүлэлт /тэрбум төгрөг/ .....	108
Хавсралт 4. ХЗХ–дын салбарын статистик үзүүлэлт /тэрбум төгрөг/ .....	109

# ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

---


ААН	Аж ахуй нэгж
АЖДХ	Албан Журмын Даатгагчдын Холбоо
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АТТ	Арилжааны Төлбөр Тооцоо
АХБ	Азийн Хөгжлийн Банк
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
БНАСАУ	Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БХХО	Богино хугацаат хөрөнгө оруулалт
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗГҮЦ	Засгийн Газрын үнэт цаас
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ЗЗҮ	Зах зээлийн үнэлгээ
ЖДБ	Жижиг, дунд бизнес
МББСБХ	Монголын Банк Бус Санхүүгийн Байгууллагуудын Холбоо
МДХ	Монголын Даатгагчдын Холбоо
МДЗХ	Монголын Даатгалын Зуучлагчдын Холбоо
МИК	Монголын Ипотекийн Корпораци
МҮЦАЭХ	Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо
МҮЦБ	Монголын Үнэт Цаасны Бирж
МХБ	Монголын Хөрөнгийн Бирж



МХЗХҮХ	Монголын Хадгаламж, Зээлийн Хоршоодын Үндэсний Холбоо
МХҮХ	Монголын Хохирол Үнэлэгчдийн Холбоо
НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
ОУВС	Олон Улсын Валютын Сан
СЗХ	Санхүүгийн Зохицуулах Хороо
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
УИХ	Улсын Их Хурал
ҮЦК	Үнэт цаасны компани
ҮЦТХТ	Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв
ФАТФ	Санхүүгийн Хориг Арга Хэмжээ Авах Олон Улсын Байгууллага
ХАА	Хөдөө аж ахуй
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХЗХ	Хадгаламж, зээлийн хоршоо
ХНХ	Хувь нийлүүлсэн хөрөнгө
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
A2II	Даатгалын Санаачилгыг Нэвтрүүлэх Олон Улсын Байгууллага
AFI	Санхүүгийн Хүртээмжийн Нийгэмлэг
ICURN	Олон Улсын Хадгаламж Зээлийн Хоршооны Зохицуулагчдын Хурал
OECD	Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллага
МАРІХ	Монголын Хөдөө Аж Ахуйн Барааны Үнийн Индекс
MEFIN	Азийн Орнуудын Мэдлэг, Туршлага Солилцох Сүлжээ








# ХУРААНГУЙ ТОЙМ 2017



# ХУРААНГУЙ ТОЙМ 2017

Монгол Улсын эдийн засаг 2017 онд сэргэж, бодит ДНБ-ий өсөлт 5.1 хувьд хүрэв. Оны нэрлэсэн үнээр ДНБ-ий өсөлтийн 35 хувийг уул уурхайн салбар, 19 хувийг боловсруулах үйлдвэр голчлон бүрдүүлсэн байна. Харин өнгөрсөн онд иргэдийн худалдан авах чадвар муудсантай холбоотойгоор импорт бууралттай гарч, гадаад худалдааны нийт эргэлт 12 хувиар буурч байсан бол тайлант онд олон улс дахь түүхий эдийн үнийн өсөлтийн эерэг таатай нөлөөнд манай орны экспорт 26 хувиар өсөж, улмаар гадаад худалдааны нийт эргэлт 27 хувийн өсөлтийг үзүүлээ. Түүнчлэн инфляцийн түвшин зорилтот түвшнээс доогуур буюу 6.9 хувьд хүрч, 2011 оноос хойш тасралтгүй буурч байсан гадаадын шууд хөрөнгө оруулалтын дүн эргэн өсөж 1.4 тэрбум ам.долларт хүрсэн билээ.

Макро эдийн засгийн энэхүү таатай нөхцөл байдал болон зохицуулагч байгууллагаас хэрэгжүүлж буй бодлого шийдвэрийн үр дүнд санхүүгийн зах зээл сэргэж байна. Тэр дундаа хөрөнгийн зах зээл хамгийн өндөр өсөлтийг үзүүлж, өнгөрсөн онд 1.4 их наяд байсан зах зээлийн үнэлгээ тайлант онд 65.5 хувиар өсөж 2.44 их наяд төгрөг болж, ДНБ-ий 9 хувьтай тэнцлээ. Үнэт цаасны зах зээлийн хөгжлийн үндсэн үзүүлэлтүүд болох зах зээлийн үнэлгээ, хувьцааны арилжааны хэмжээ 2017 онд өмнөх оны мөн үетэй харьцуулахад өндөр өсөлттэй байгаа нь зах зээлд оролцогчдын хөрөнгийн зах зээлд итгэх итгэл нэмэгдэн, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын идэвх сэргэсэнтэй холбоотой юм. Харин даатгалын компани, ББСБ болон ХЗХ-дын нийт хөрөнгийн хэмжээ 23.3 хувиар өсөж, 1.37 их наяд төгрөгт хүрсэн байна. ХЗХ-дын салбарын хөгжлийн үзүүлэлтүүд сүүлийн 10 жилд тохиож байгаагүй өндөр өсөлтийг үзүүлж, салбарын нийт актив 35 хувиар өссөн бол ББСБ-ын салбар 23 хувь, даатгалын зах зээл 17 хувиар тус тус өслөө. Ийнхүү ДНБ-д эзлэх банкнаас бусад санхүүгийн зах зээлийн хэмжээ тайлант онд 14 хувь болж, 2016 оны түвшнээс 3.2 пунктээр нэмэгдсэн байна.



## 1.1 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Санхүүгийн зохицуулах хорооны үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой нийт 300 хувьцаат компани бүртгэлтэй байгаа бөгөөд 2017 оны жилийн эцсийн байдлаар 52 үнэт цаасны компани Хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант оны эцэст Монгол Улсын үнэт цаасны зах зээлийн нийт үнэлгээ 2,440.2 тэрбум төгрөгт хүрсэн нь түүхэн дэх хамгийн өндөр түвшин байв. ЗЗҮ өнгөрсөн онтой харьцуулахад 65.5 хувиар өсөж, ДНБ-ий 9.0 хувьтай тэнцсэн бөгөөд нийт зах зээлийн үнэлгээний 79.5 хувийг 10 компани бүрдүүлжээ. Түүнчлэн ТОП-20 индекс өмнөх оны мөн үеийнхээс 66.5 хувиар, MSE-ALL индекс 33.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

2017 онд “Монголын хөрөнгийн бирж” ХК болон “Монголын үнэт цаасны бирж” ХХК-аар дамжуулан нийт 860.8 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэнээс МХБ-ийн 249 удаагийн арилжаагаар 134 компанийн 106.1 сая ширхэг хувьцааг 76.4 тэрбум төгрөгөөр, МҮЦБ-ээр 1 компанийн 27,998,358 ширхэг хувьцааг 1.7 тэрбум төгрөгөөр арилжаалсан байна. ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаагаар 6.7 сая ширхэг үнэт цаасыг 630.2 тэрбум төгрөгөөр арилжиж, харин ЗГҮЦ-ны

хоёрдогч зах зээлийн арилжаагаар нийт 1.4 сая ширхэг үнэт цаасыг 142.3 тэрбум төгрөгөөр арилжжээ.

Тайлант хугацаанд Хорооны 2017 оны 75 дугаар тогтоолоор “МИК Актив арван хоёр” ХХК-ийн 2,722,916 ширхэг, 170 дугаар тогтоолоор “МИК Актив арван гурав” ХХК-ийн 1,902,864 ширхэг, 239 дүгээр тогтоолоор “МИК Актив арван дөрөв” ХХК-ийн 1,453,414 ширхэг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг тус тус бүртгэсэн.



## 1.2 ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

Тухайн зах зээлийн хэмжээг илэрхийлэх гол үзүүлэлтүүдийн нэг болох нийт хөрөнгийн хэмжээ даатгалын салбарын хувьд тайлант жилд 17.4 хувиар өсөж 244.7 тэрбум төгрөгт хүрсэн ба нийт хөрөнгийн 79.1 хувийг ердийн даатгалын компаниуд, 17.7 хувийг давхар даатгалын компани, 3.2 хувийг урт хугацааны даатгалын компани тус тус бүрдүүлэв.

Харин нийт хураамжийн орлого 2016 оны жилийн эцэст 0.2 хувийн өсөлттэй байсан бол тайлант жилд 26.1 хувийн өсөлт үзүүлж 144.3 тэрбум төгрөг болов. Энэхүү өсөлтөд ердийн даатгалын хураамжийн орлогын өсөлт хамгийн их нөлөөг үзүүлж 26.4 хувиар, давхар даатгалын компанийн хураамжийн орлого 18.9 хувиар, харин урт хугацааны даатгалын компанийн хураамжийн орлого 3.0 хувиар тус тус өсөв. Хураамжийн орлогын төвлөрүүлэлтийг авч үзвэл даатгалын зуучлагчид 42.7 тэрбум төгрөг буюу 29.6 хувийг, даатгалын төлөөлөгчид 35.6 тэрбум төгрөг буюу 24.7 хувийг бүрдүүлсэн байна.

Даатгалын компаниудын нийт нөхөн төлбөрийн зардал тайлант жилд 45.2 тэрбум төгрөгт хүрч, нийт хураамжийн орлогын 31.3 хувийг эзэлж байна. Үүнээс ердийн даатгалын компаниудын нөхөн төлбөр 98.0 хувийг бүрдүүлж байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нөхөн төлбөрийн зардал 31.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Даатгалын компаниуд өөрийн хүлээж авсан эрсдэлээ шилжүүлэх зорилгоор өөр нэгэн даатгалын компаниас давхар даатгалын үйлчилгээг авдаг. Манай орны хувьд дийлэнх даатгалын компаниуд гадны давхар даатгалын компанид эрсдэлээ даатгадаг ба тайлант жилд нийт 46.6 тэрбум төгрөгийн давхар даатгалын хураамжийг шилжүүлээд байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 25.2 хувиар өссөн үзүүлэлт бөгөөд нийт хураамжийн орлоготой харьцуулахад 32.3 хувь байгаа юм.

Өнгөрсөн онд даатгалын салбарын татварын дараах цэвэр ашгийн өсөлт 64.3 хувь байсан бол тайлант жилд 15.7 хувийн өсөлтийг үзүүлж, нийт цэвэр ашгийн хэмжээ 13.2 тэрбум төгрөгт хүрэв. Өөрийн хөрөнгийн өгөөж 7.8 хувь, нийт хөрөнгийн өгөөж 3.6 хувь байна.



### 1.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

2017 оны байдлаар санхүүгийн зах зээлд нийт 534 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа ба дийлэнх нь буюу 90.3 хувь нь зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна.

Салбарын нийт хөрөнгийн хэмжээ 23.1 хувиар өсөж 969.2 тэрбум төгрөгт хүрсэн нь ДНБ-ий 3.6 хувьтай тэнцүү байна. Тайлант үеийн хөрөнгийн өсөлтийн 84.6 хувийг хувь нийлүүлсэн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна. Харин нийт зээлийн хэмжээ өмнөх оноос 33.4 хувиар өсөж 638 тэрбум төгрөгт хүрсэн ба хөрөнгийн өсөлтөөс 1.4 дахин өндөр өсөлтийг үзүүлсэн байна. Өөрөөр хэлбэл ББСБ-ууд хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлсний дүнд салбарын хөрөнгийн чадавх сайжирч, улмаар зах зээлд олгож буй зээлийн нийлүүлэлт өсөж байна. Салбарын зээлийн нийлүүлэлт нэмэгдсэнээр банкнаас бусад санхүүгийн үйлчилгээний хүртээмж нэмэгдэж, зээлийн бүтээгдэхүүний үнэ болох хүүгийн түвшин буурч буй зэрэг эерэг өөрчлөлтүүд ажиглагдаж байгаа ба өмнөх онд 4 хувь байсан зээлийн жигнэсэн дундаж хүү 3.4 хувь болж буурлаа.

Нийт зээлийн үлдэгдлийн 81 хувийг иргэдэд олгосон зээл, 19 хувийг хуулийн этгээдэд олгосон зээл бүрдүүлж байна. Нийт зээлийн үлдэгдлийн 82.6 хувийг хугацаандаа байгаа зээл, 4.7 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 12.7 хувийг чанаргүй зээл бүрдүүлэв.

2017 оны байдлаар ББСБ-уудын ашиг өмнөх оноос 13 хувиар өсөж 66.8 тэрбум төгрөгт хүрсэн. Нийт ББСБ-уудын 83.1 хувь нь 77.8 тэрбум төгрөгийн ашигтай, 13.3 хувь нь 11 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан бол үлдсэн 3.6 хувь нь тайлант онд үйл ажиллагаа явуулаагүй байна. Нийт хөрөнгийн өгөөж 7.6 хувь, өөрийн хөрөнгийн өгөөж 10.0 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 0.8 болон 1.8 пунктээр тус тус буурлаа. Өгөөжийн бууралтад хөрөнгийн өсөлт нөлөөлсөн.



## 1.4 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

2017 оны байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос хадгаламж, зээлийн хоршооны тусгай зөвшөөрлийн эрхтэй үйл ажиллагаа явуулж буй 290 хоршоо байна. ХЗХ–дын 55,624 гишүүдийн 57.5 хувь нь эмэгтэй, 42.5 хувь нь эрэгтэй гишүүд байна.

Тайлант улиралд нийт хөрөнгийн хэмжээ 153.1 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 35.4 хувийн өсөлтийг үзүүлж, сүүлийн 10 жилд анх удаа 30–аас дээш хувиар өслөө. Нийт хөрөнгийн өсөлтийн 79.5 хувийг хадгаламжийн өсөлт тайлбарлаж байгаа бөгөөд нийт хадгаламжийн хэмжээ өнгөрсөн онуудтай харьцуулахад хамгийн өндөр буюу 47.2 хувийн өсөлтийг үзүүлэв. Нийт ХЗХ–дын 89.3 хувь буюу 259 ХЗХ нь нийт 99.3 тэрбум төгрөгийн хадгаламж төвлөрүүлсэн бол үлдсэн 11.3 хувь буюу 31 ХЗХ нь огт хадгаламж татаагүй байна.

2017 онд салбарын нийт цэвэр ашиг 5.5 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн онтой харьцуулахад 44.0 хувиар өссөн нь 2012 оноос хойш хамгийн өндөр өсөлтийг үзүүллээ. Цэвэр ашгийн энэхүү өндөр өсөлтөд ХЗХ–дын нийт орлогын өсөлт голчлон нөлөөлсөн бөгөөд нийт орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 29.9 хувиар өсөж сүүлийн 10 жилийн хугацаан дахь хамгийн өндөр хувьд хүрчээ.

Тайлант онд салбарын хувьд 3.1 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сан байгуулж нийт 102.1 тэрбум төгрөгийн цэвэр зээлтэй байна. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь өнгөрсөн оны мөн үеэс 1.2 пунктээр буурч 4.2 хувьд хүрч нийт чанаргүй зээлийн хэмжээ 4.5 тэрбум төгрөгт хүрлээ. Салбарын нийт зээл өнгөрсөн онтой харьцуулахад 26.1 хувиар буюу 21.7 тэрбум төгрөгөөр өсөж 105.2 тэрбум төгрөгт хүрсэн нь сүүлийн 9 жилийн хугацаанд хамгийн өндөр өсөлтийг үзүүлэв.





# САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ

# САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ

## 2.1 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Зохицуулалттай этгээд: Тайлант хугацаанд 52 компани Хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд үнэт цаасны арилжаа эрхлэх 2, үнэт цаасны төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх 1, төвлөрсөн хадгаламжийн 1, кастодиан банкны үйлчилгээ үзүүлэх 3, хөрөнгө оруулалтын менежментийн 17 компани үйл

ажиллагаа явуулж байгаа бол хөдөө аж ахуйн биржийн арилжаа, зуучлалын чиглэлээр арилжаа эрхлэх 1, бараа, түүхий эдийн арилжааны зуучлалын үйл ажиллагаа эрхлэх 16 этгээд байна. Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж буй зохицуулалттай этгээдүүдийг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 1. Зохицуулалттай этгээдийн тоо

№	Зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэгч	Оролцогчдын тоо
1	Үнэт цаасны арилжаа эрхлэх	2
2	Үнэт цаасны төлбөр тооцооны	1
3	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн	1
4	Хөрөнгө оруулалтын менежментийн	17
5	Кастодиан банк	3
Мэргэжлийн оролцогчид		52
6	Брокер	50
7	Дилер	47
8	Андеррайтер	22
9	Хөрөнгө оруулалтын зөвлөх	14
10	Хөрөнгө оруулалтын сан (хувийн)	9
Нийт		85
11	Хөдөө аж ахуйн түүхий эдийн арилжаа эрхлэх	1
12	Хөдөө аж ахуйн түүхий эдийн брокер	16
13	Аудитын компани	49
14	Үнэлгээний компани	21
15	Хуулийн компани	21


Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2016 оны жилийн эцэстэй харьцуулахад ҮЦК-уудын тоо 10-аар буурсан бөгөөд энэ нь ҮЦК-уудад тавих хяналт шалгалтыг нэмэгдүүлж, хууль тогтоомж, гэрээгээр хүлээсэн үүрэг,

зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангадаггүй компаниудын тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, мөн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох арга хэмжээ авсантай холбоотой юм.



Зураг 1. ҮЦК-уудын тоо




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хөрөнгийн зах зээлийн бүтэц: Монгол Улсын хөрөнгийн зах зээл нь дотроо хувьцааны болон бонд (өрийн бичиг)-ын зах зээл гэж үндсэндээ 2 хуваагддаг. Түүнчлэн арилжаалагдаж буй бүтээгдэхүүний шинэ хуучин эсэхээс хамаарч хөрөнгийн зах зээл нь анхдагч болон хоёрдогч гэж ангилагддаг. Анхдагч хөрөнгийн зах зээлд

Засгийн газар эсвэл компанийн бонд болон хувьцаагаа анх удаа шинээр санал болгож, улмаар "босгосон" мөнгөөрөө үнэт цаас гаргасан төслөө санхүүжүүлдэг. Харин хоёрдогч зах зээлд хөрөнгө оруулагчид өмнө нь худалдан авсан үнэт цаасаа хоорондоо арилждаг.

Зураг 2. Хөрөнгийн зах зээлийн бүтэц



Дэлхийн банкнаас аливаа улсын хөрөнгийн зах зээлийн багтаамжийг хэмжихдээ хувьцааны зах зээлийг зах зээлийн үнэлгээний ДНБ-д эзлэх хувь, хөрвөх чадвар, хувьцааны гүйлгээний ДНБ-д эзлэх хувь гэсэн 3 үзүүлэлтээр, харин бондын зах зээлийн хувьд ам.доллаар илэрхийлэгдэх дотоодын бондын зах зээлийн хэмжээ, гадаад валютын бондын ДНБ-д эзлэх хувь, бүртгэлтэй бондын үнэлгээ болон бондын гүйлгээний дүн гэсэн үзүүлэлтүүдээр илэрхийлэн авч үздэг байна.

Дээрх үзүүлэлтүүдээс хувьцааны зах зээлийн хувьд ЗЗҮ-ний ДНБ-д эзлэх хувь, хөрвөх чадвар, мөн нэмэлтээр ЗЗҮ болон хувьцааны индексийг, харин бондын зах зээлийн хувьд бондын гүйлгээний дүн гэсэн үзүүлэлтүүдийг тус тус тооцон 2017 оны жилийн эцсийн байдлаар гаргав.

### 2.1.1 Хувьцааны зах зээл

Зах зээлийн үнэлгээ: ЗЗҮ гэдэг нь тухайн хугацаанд зах зээлд бүртгэлтэй нийт компанийн

тухайн өдрийн хаалтын ханшаар илэрхийлэгдэж буй нийт үнэлгээний дүн юм. Жишээ нь: “А” компани 10 сая ширхэг хувьцаатай, өнөөдрийн нэгж хувьцааны хаалтын ханш 5000 төгрөг гэж үзвэл тус компанийн өнөөдрийн зах зээлийн үнэлгээ 50 тэрбум төгрөг байх юм. Энэ аргаар бүх компаниудын үнэлгээг гаргаж нийлбэр дүнг тооцоход тухайн биржийн зах зээлийн үнэлгээ гардаг.


2017 оны жилийн эцсийн байдлаар үнэт цаасны зах зээлийн үнэлгээ 2,440.2 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 966.1 тэрбум төгрөг буюу 65.5 хувиар өссөн үзүүлэлт юм.

Тайлант хугацаанд “Монголын хөрөнгийн бирж” ХК-аар дамжуулан “Ай түүлс” ХК, болон анхны хувийн бирж болох “Монголын үнэт цаасны бирж” ХХК-аар дамжуулан “Анд Энерги” ХК анхдагч зах

зээлд нийтэд санал болгон хувьцаа гаргасан. Мөн 2017 оны 11 дүгээр сарын 24-ны өдөр Хорооноос “АПУ” ХК-д “Эвэргрийн Инвестментс” ХХК-ийг нэгтгэхийг зөвшөөрснөөр “АПУ” ХК нь “МХБ” ХК-д бүртгэлтэй хамгийн том компани болж, үндэсний томоохон компаниуд цаашид нэгдэн нийлэх, ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт татах туршлагыг зах зээлд бий болгож, нийт зах зээлийн үнэлгээ өсөхөд чухал нөлөө үзүүлээ.

**Хөрвөх чадвар:** Хөрвөх чадвар гэдэг нь хувьцаа хэр хэмжээгээр гар дамжин эргэлдэж байгааг илэрхийлдэг бөгөөд зах зээлд арилжигдсан нийт хувьцааны гүйлгээний дүнг ЗЗҮ-нд харьцуулснаар тухайн хувьцааны зах зээлийн хөрвөх чадвар хэмжигддэг. Тайлант хугацаанд нийт 78.1 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа хийгдэж хөрвөх чадвар 3.2 хувь болов. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.1 пунктээр буурсан үзүүлэлт юм.

Зураг 3. ЗЗҮ болон хөрвөх чадвар



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


**ЗЗҮ/ДНБ-ий харьцаа:** ЗЗҮ-г эдийн засгийн өсөлтийн нэг хэмжигдэхүүн болох ДНБ-д харьцуулснаар тухайн зах зээл өндрөөр үнэлэгдэж байна уу эсвэл доогуур үнэлэгдэж байна уу гэдгийг тодорхойлдог. Тайлант онд ЗЗҮ-г 2017 оны жилийн эцсийн үйлдвэрлэлийн аргаар тооцсон нэрлэсэн ДНБ-ий хэмжээтэй харьцуулахад 9 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 2.8 пунктээр өссөн үзүүлэлт юм.

**Хувьцааны индекс:** Олон улсад хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдлыг тайлбарладаг бас нэгэн үзүүлэлт нь хувьцааны индекс байдаг. Тухайлбал Нью-Йоркийн хөрөнгийн бирж болон Насдакийн хөрөнгийн бирж дээр арилжаалагддаг томоохон 500 компанийн зах зээлийн үнэлгээнд суурилан

тооцдог Стандарт энд Пүүрс 500 (Standard and Poor's 500 буюу S&P 500) индекс нь Америкийн хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдлыг илэрхийлэгч нэгэн үзүүлэлт болдог. Манай орны хувьд “Монголын хөрөнгийн бирж” ХК-аас хоёр төрлийн индекс тооцдог. Хамгийн өндөр үнэлгээтэй 20 компанийн зах зээлийн үнэлгээнд суурилан тооцдог ТОП-20 индекс, нөгөө нь биржид бүртгэлтэй бүх компанийн зах зээлийн үнэлгээнд суурилан тооцдог MSE-ALL индекс юм.

**ТОП-20:** Тайлант хугацаанд ТОП-20 индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8,280.9 нэгжээр буюу 66.5 хувиар өсөж 20,736.9 нэгж болсон бөгөөд индексийн дээд үзүүлэлт 24,520.35 нэгж, доод үзүүлэлт 11,972.1 нэгж, дундаж үзүүлэлт 15,511.89 нэгж байна.

Зураг 4. ТОП–20 индекс




Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ХК

MSE–ALL: Уг индексийг 2015 оны 02 дугаар сараас тооцож эхэлсэн байдаг. Тайлант хугацаанд MSE–ALL индексийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 285.1 нэгжээр буюу 33.1 хувиар

өсөж 1146.3 нэгжид хүрсэн бөгөөд индексийн дээд үзүүлэлт 1280.32 нэгж, доод үзүүлэлт 814.5 нэгж, дундаж үзүүлэлт 950.1 нэгж байна.

Зураг 5. MSE–ALL индекс



Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ХК

## ШИГТГЭЭ 1.

### ОЛОН УЛСАД ӨРНӨСӨН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

2017 онд дэлхийн хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдал хүлээлтээс тэс өөр байлаа. Эдийн засгийн таатай нөхцөл байдал болон АНУ–ын ерөнхийлөгч Дональд Трампын үзүүлсэн татварын хөнгөлөлтүүдтэй холбоогоор 2017 онд дэлхийн хөрөнгийн зээлийн MCSI индекс 22 хувь буюу 9 их наяд ам.доллараар өсөж түүхэн дээд цэг болох 514.3 нэгжид хүрсэн.

Дэлхийд хөрөнгийн зах зээлээрээ тэргүүлэгч орны нэг АНУ–ийн хувьд эдийн засгийн өсөлт хурдсах төлөвтэй байсан ч, хүлээлтээс доогуур үзүүлэлттэй байв. Инфляцын болон бондын хүүгийн түвшин өсөх хандлагатай байсан боловч инфляци тогтвортой түвшинд хадгалагдан, мөн 10 жилийн хугацаатай засгийн газрын бондын өгөөж жилийн эхэнд байсан түвшнээсээ доогуур байлаа. Гэсэн хэдий ч, АНУ–ын хувьцааны ханш тогтвортой өссөнөөр өнгөрсөн 9 дүгээр сард S&P 500 индекс анх удаа 2,500 нэгжид хүрсэн юм.

АНУ–аас бусад улс орнуудын хувьд, геополитикийн хурцадмал байдал, Европ дахь сонгуулийн маргаантай нөхцөл байдал, Брекситээс үүдэлтэй тодорхой бус байдал зэргээс үл хамааран хувьцааны зах зээл өндөр гүйцэтгэлтэй байв. Тэр дундаа хөгжиж буй орнуудын хувьцааны зах зээлийн үнэлгээ MCSI индекс өндөр өсөлттэй гарч, өнгөрсөн 6 жилийн хугацаанд хамгийн дээд түвшиндээ хүрсэн.


Түүнчлэн Лондонгийн хөрөнгийн биржийн FTSE 100 индекс өнгөрсөн хугацаанд хамгийн ихдээ 7697.6 нэгжид хүрч байсан бол 2017 онд уг индекс хоёр дахь шинэ дээд амжилтыг тогтоож 7687.8 нэгжид хүрч хаагдсан байна. Их Британийн индекс тэргүүлэх үзүүлэлттэй байгаа нь дэлхийн түүхий эдийн үнэ өсөж, үүнийг дагаад уул уурхайн хувьцааны үнэ өссөнтэй холбоотой юм. Үүний хажуугаар БНХАУ–ын эдийн засгийн өсөлт өндөр хүлээлттэй байсан нь Хятадын хувьцааны үнийн өсөлтөд эерэг нөлөөг үзүүлэн, улмаар уг индексийг 7.6 хувиар өсөхөд нөлөөлөв.

Олон улсын валютын сан, Дэлхийн банкнаас үнэт цаасны зах зээлийн хөгжлийг үнэт цаасны зах зээлийн үнэлгээ, хөрвөх чадвар, үнэт цаасны арилжааны ДНБ-д эзлэх хувь, зах зээлийн үнэлгээний ДНБ-д эзлэх хувь, хувьцааны индекс гэсэн үндсэн үзүүлэлтүүдээр илэрхийлж авч үздэг бөгөөд тухайн улсын хувьд дээрх үзүүлэлтүүд ямар түвшинд хүрснээс хамаарч гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын оролцоо нэмэгдэх, хөрөнгө оруулалтын урсгал бий болох, улмаар бүс нутгийн хэмжээнд өрсөлдөхүйц түвшинд байгаа эсэхийг тодорхойлдог.

Эх сурвалж: Putnam Investment

## 2.1.2. Бондын зах зээл

Зураг 6. ЗГҮЦ-ны арилжаа




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

**ЗГҮЦ-ны арилжаа:** Тайлант хугацаанд 44 удаагийн 12, 28, 39, 52 долоо хоног болон 2, 3 жилийн хугацаатай нийт 6.7 сая ширхэг үнэт цаасыг 630.2 тэрбум төгрөгөөр ЗГҮЦ-ны анхдагч зах зээлд, 1.4 сая ширхэг үнэт цаасыг 142.3 тэрбум төгрөгөөр ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлд тус тус арилжсан байна.

Нийт арилжааны гүйлгээний дүнг хувиар илэрхийлбэл ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаа 82 хувийг, ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаа 18 хувийг тус тус бүрдүүлж байна.

ЗГҮЦ-ны арилжааны гүйлгээний дүнг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 472.9 тэрбум төгрөгөөр буюу 2.5 дахин өссөн байна. Арилжааны гүйлгээний дүнг хугацааны цуваагаар харууллаа.

Зураг 7. ЗГҮЦ-ны арилжаа /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

**Компанийн бондын арилжаа:** 2017 оны 6 сард “Сүү” ХК нийтэд санал болгон Сүү бонд гаргасан бөгөөд анхдагч зах зээлийн арилжаагаар 60 мянган ширхэг “Сүү бонд”-ыг 6 тэрбум төгрөгөөр амжилттай арилжаалсан. 2017 оны 6 дугаар сарын

30-ны өдрөөс хоёрдогч зах зээлийн арилжаа нээгдсэн бөгөөд нийт 41.5 мянган ширхэг бондыг 4.2 тэрбум төгрөгөөр арилжсан байна.

## ШИГГГЭЭ 2.

### МОНГОЛ УЛСЫН БОНДЫН АРИЛЖАА

Монгол Улсад бондын арилжаа 1996 оны 10 дугаар сарын 25–нд Засгийн газрын бондын арилжаагаар эхэлсэн түүхтэй. Манай Засгийн газар 1996 онд төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор анх бонд гаргаж байсан бол 2011 онд Засгийн газрын бондын арилжаа 14 удаа явагдаж, “4000 төрийн албан хаагчдыг орон сууцны урт хугацаат зээлд хамруулах” хөтөлбөрийн санхүүжилтэд 65 тэрбум төгрөгийн бонд, “Ноос ноолуурын болон жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр”-ийн санхүүжилтэд 171.7 тэрбум төгрөгийн бонд арилжиж, нийт 236.7 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 2.4 сая ширхэг бондыг арилжаалсан байна.

Монголын хөрөнгийн биржийн бондын анхны арилжаа 2001 оны 6 дугаар сарын 8–нд явагдаж байсан. Өнгөрсөн хугацаанд нийт 12 компани 14 удаагийн бонд гаргаж, 18 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий бондыг анхдагч зах зээлд арилжаалсан байна. Анх 2001 онд Барилга корпорациас “Шинэ зуун” бондыг гарган арилжаалсан. Түүнээс хойш 2015 оныг хүртэл нийт 12 компани бонд гарган амжилттай арилжаалсан бөгөөд эдгээр бондыг гол төлөв барилгын салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниуд гаргасан байдаг. “Сүү бонд” нь 2015 оноос хойш гарч буй анхны компанийн бонд юм.

*Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж*

### 2.1.3 ХАА–н гаралтай бараа, түүхий эдийн зах зээл


**ХАА–н биржийн хөгжил:** Монгол Улсын Их Хурлаас 2011 онд баталсан Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ЗГ–ын 30 дугаар тогтоол, Төрийн өмчийн хорооны 45 дугаар тогтоол гарч “Хөдөө аж ахуйн бирж” ТӨХХК–ийг үүсгэн байгуулж төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд болон гүйцэтгэх удирдлагыг томилсон. ХАА–н бирж нь свот болон үүсмэл гэрээний арилжааг зохион байгуулах, төлбөр тооцоог гүйцэтгэх, биржийн арилжаанд оролцогчдыг сургах, мэргэшүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд хуулиар олгогдсон

чиг үүргээ хэрэгжүүлэхдээ шударга, ил тод, нээлттэй байх зарчмыг баримталдаг.

Хөдөө аж ахуйн бирж нь анх 2013 оны 4 дүгээр сарын 05–ны өдрөөс хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эд арилжаалж эхэлсэн ба үүнээс хойш 2017 оны жилийн эцсийн байдлаар нийт 2,424.4 тэрбум төгрөгийн 832 удаагийн арилжаа явуулжээ.

**ХАА–н биржийн арилжаа:** ХАА–н биржээр дамжин 2013 онд 403.7 тэрбум, 2014 онд 554.1 тэрбум, 2015 онд 431.7 тэрбум, 2016 онд 463 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн байна. 2017 онд 572.5 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 109 тэрбум буюу 23.5 хувиар өссөн үзүүлэлт юм.

*Зураг 8. ХАА–н биржийн арилжаа*




*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

**ХАА–н биржийн индекс:** MAPIX нь “Mongolian Agriculture Price Index” буюу “Монголын хөдөө аж ахуйн биржийн индекс” нэрийн товчлол бөгөөд биржийн индекс хэмээн ойлгож болно. Энэ нь сонгож багцалсан бүлэг барааны үнийг тусгай загвараар жигнэж тооцоолсон үнэ юм. Биржийн

индекс нь сонгосон бүлэг бараа эсвэл салбар дахь барааны үнийг ерөнхий багцаар харах боломж олгодог.

Тайлант хугацаанд MAPIX индексийн дээд үзүүлэлт 795,358.7 нэгж, доод үзүүлэлт 493,005.8 нэгж байсан.

Зураг 9. MAPIX индекс



Эх сурвалж: “Хөдөө аж ахуйн бирж” ХХК

## 2.2 ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

Даатгалын зах зээлийн бүтэц: Тайлант хугацаанд нийт 281 даатгалын компани, даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч, актуарч, аудитор, даатгалын компанид аудит хийх эрх

бүхий компани мөн 2893 даатгалын төлөөлөгч СЗХ-ноос олгосон тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрхийн үндсэн дээр үйл ажиллагаа явуулж байна

Зураг 10. Даатгалын зах зээлийн бүтэц



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Даатгалын зах зээлд өнөөгийн байдлаар ердийн даатгалын 15 компани, урт хугацааны даатгалын 1 компани, давхар даатгалын 1 компани үйл ажиллагаа явуулж байна. Харин мэргэжлийн оролцогчдын хувьд 42 даатгалын зуучлагч компани байгаагаас давхар даатгалын зуучлагч

9, мөн даатгалын зуучлалын үйлчилгээ үзүүлэгч 9 банк байна. Даатгалын хохирол үнэлэгч 29 компани, 2893 даатгалын төлөөлөгч тус тус СЗХ-ноос олгосон тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулж байна.


Даатгалын компаниуд болон мэргэжлийн оролцогчдын санхүү нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа стандартын дагуу хөтлөгдөж буй эсэхэд хяналт тавих, баталгаажуулах үүднээс аудитын компаниудад СЗХ–ноос эрх олгодог. Одоогоор 42 аудитын компани болон 130 аудиторт тус эрхийг олгоод байна.

2017 оны жилийн эцсийн байдлаар нэр бүхий нэг ердийн даатгалын компанийн нийт хураамжийн орлогод эзлэх хувь хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 1.9 пунктээр өсөж 20.0 хувьд хүрэн зах зээлд хамгийн өндөр хувийг эзэлсэн хэвээр байна. Түүний араас 2 даатгалын компани нийт

хураамжийн орлогын хэмжээгээрээ тус тус ердийн даатгалын зах зээлийн 16.0 хувь болон 17.6 хувийг эзэлж байна.

2016 оны жилийн эцэст дээр дурдсан зах зээлд эзлэх хувь хэмжээгээр хамгийн өндөр 3 даатгагчид ердийн даатгалын зах зээлийн хураамжийн орлогын 51.9 хувийг эзэлж байсан бол уг үзүүлэлт тайлант жилд 53.5 хувь болж 1.6 пунктээр өсчээ. Бусад ердийн даатгалын компаниудын хувьд зах зээлд эзлэх хураамжийн орлогын хэмжээ ойролцоо түвшинд буюу 0.4 хувиас 9.9 хувийн хооронд, дунджаар 3.9 хувь байна.

Зураг 11. Ердийн даатгалын компаниудын хураамжийн орлогын зах зээлд эзлэх хувь



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

### ШИГТГЭЭ 3.

#### ОЛОН УЛСЫН ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Ирэх 2018 он гэхэд дэлхийн даатгалын зах зээл 4.5%–аар өсөх хандлагатай байна. АНУ–ын эдийн засгийн ирээдүйн эерэг таамаглал болон шинээр хөгжиж буй зах зээлийн өсөлт нь Хятадын зах зээлийн өсөлт бууралт зэрэг сөрөг хүчин зүйлсийг нөхөхөөр хүлээгдэж байна. Харин урт хугацаандаа Азийн хөгжиж буй зах зээлүүдийн өсөлт нийт салбарын өсөлтийг хангах хамгийн том нөөц бололцоо болохоор байна.

Латин Америк болон Азийн олон оронд даатгалын гүнзгийрэлт сул байгаа нь даатгалын салбар цаашид өргөжин тэлж, хөгжих боломжтойг харуулж байна. Гэвч даатгалын хуримтлал ба орлогын өсөлтөд сөргөөр нөлөөлж болзошгүй гол эрсдэлийг:


- Хойд болон Төв Америк дахь идэвхтэй Атлантын далайн шуурганы үеэрх Харви, Ирма зэрэг хар салхинаас үүдэх алдагдал;
- Сүүлийн 16 улирлын туршид амьжиргааны түвшин багасах хандлага;
- Зах зээлд нөлөөлж болзошгүй зохицуулалтын хязгаарлалтууд нэмэгдэж байгаа явдал зэрэг хэмээн тодорхойлжээ.

Эх сурвалж: Global Insurance Markets Trend, OECD

Даатгалын гүнзгийрэлтийн түвшин: Даатгалын салбарын үндсэн үзүүлэлтүүд сүүлийн жилүүдэд өсөлттэй байгаа хэдий ч салбарын хөгжлийн гол хэмжүүр болох даатгалын гүнзгийрэлт буюу

ДНБ-д эзлэх хураамжийн орлогын хувь хэмжээ 0.58 хувь байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 0.05 пунктээр буурсан үзүүлэлт юм.

Зураг 12. Даатгалын гүнзгийрэлтийн түвшин




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Нийт хөрөнгө: Тайлант хугацаанд нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 17.4 хувиар өсөж 244.7 тэрбум төгрөгт хүрлээ. Давхар даатгалын компанийн нийт хөрөнгийн жилийн өсөлт бусад даатгалын төрөлтэй харьцуулахад хамгийн өндөр буюу 23.8 хувиар өсөж 43.4 тэрбум төгрөг болж, нийт хөрөнгийн 17.7 хувийг эзлэв.

Ердийн даатгалын компаниудын нийт хөрөнгө 16.7 хувиар өсөж 193.6 тэрбум төгрөг болсон нь салбарын нийт хөрөнгийн 79.1 хувийг, харин урт хугацааны даатгалын компанийн нийт хөрөнгийн хэмжээ 3.3 хувиар өсөж 7.8 тэрбум төгрөгт хүрч, нийт хөрөнгийн 3.2 хувийг эзлэв.

Зураг 13. Даатгалын салбарын нийт хөрөнгө



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


Нийт даатгалын компаниудын дундаж өсөлт 2016 оны жилийн эцэст 18.5 хувь байсан бол 2017 оны жилийн эцсийн байдлаар 15.5 хувь болж буурсан байна. 2016 онд дунджаас дээш хөрөнгийн

өсөлттэй компанийн тоо 7 байсан бол тайлант онд мөн 7 компани дунджаас дээш хөрөнгийн өсөлттэй байна.



ДААТГАЛЫН КОМПАНИУД	2016/2015	2017/2016
Монре даатгал	9.8%	4.5%
Ард даатгал	8.9%	22.9%
Бодь даатгал	11.7%	35.4%
Мөнх даатгал	-0.4%	12.3%
Миг даатгал	10.5%	40.1%
Соёмбо даатгал	5.2%	3.0%
Монгол даатгал	8.9%	9.2%
Тэнгэр даатгал	31.2%	15.8%
Номин даатгал	25.8%	10.6%
Улаанбаатар хотын даатгал	-0.7%	8.6%
Гэр даатгал	11.9%	11.2%
Ган зам даатгал	22.3%	5.1%
Практикал даатгал	23.7%	19.9%
Мандал даатгал	76.7%	24.0%
Хаан даатгал	35.7%	13.4%
Нэйшнл лайф даатгал	-1.5%	3.3%
Хөдөө аж ахуйн давхар даатгал	34.5%	23.8%
ДУНДАЖ	18.5%	15.5%

Зураг 14. Даатгалын компанийн хөрөнгийн өсөлтийн тархалт




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хураамжийн орлого: Даатгалын компаниуд энэ онд нийт 144.3 тэрбум төгрөгийн хураамжийн орлоготой ажиллав. Үүнээс ердийн даатгалын компаниуд 141.2 тэрбум буюу 97.8 хувийг, урт хугацааны даатгалын компани 1.3 тэрбум төгрөг буюу 0.9 хувийг, хөдөө аж ахуйн давхар даатгалын компани 1.9 тэрбум төгрөг буюу 1.3 хувийг тус тус бүрдүүлсэн байна. 2016 оны жилийн эцэст хураамжийн орлого өмнөх үеэс 0.2 хувийн өсөлттэй байсан бол 2017 оны жилийн эцэст 26.1

хувийн өсөлтийг үзүүлэв.

Хураамжийн орлогын төвлөрүүлэлтийг авч үзвэл даатгалын зуучлагчид 42.7 тэрбум төгрөг буюу 29.6 хувийг, даатгалын төлөөлөгчид 35.6 тэрбум төгрөг буюу 24.7 хувийг бүрдүүлсэн байна. Даатгалын зуучлагчийн хураамжийн орлогын 25.9 хувийг жолоочийн хариуцлагын албан журмын даатгал эзэлж байгаа бол төлөөлөгчийн хураамжийн орлогын 29.0 хувийг эзэлж байна.

Зураг 15. Хураамжийн орлого




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Нөхөн төлбөр, давхар даатгалын хураамж: Даатгалын компаниудын нийт нөхөн төлбөрийн зардал тайлант улиралд 45.2 тэрбум төгрөгт хүрч, нийт хураамжийн орлогын 31.3 хувийг эзлэв. Үүнээс ердийн даатгалын компаниудын нөхөн төлбөр 44.3 тэрбум төгрөг буюу 98.0 хувийг бүрдүүлж байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нөхөн төлбөрийн зардал 31.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Тайлант жилд нийт 46.6 тэрбум төгрөгийн давхар даатгалын хураамжийг шилжүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 25.2 хувиар өссөн үзүүлэлт бөгөөд нийт хураамжийн орлогын 32.3 хувийг эзэлж байна. Ердийн даатгалын компаниуд давхар даатгалд 45.8 тэрбум төгрөг, урт хугацааны даатгалын компани 0.02 тэрбум төгрөг, хөдөө аж ахуйн давхар даатгалын компани 0.8 тэрбум төгрөгийг тус тус давхар даатгалын хураамжид зарцуулжээ.

Зураг 16. Нөхөн төлбөр, давхар даатгалын хураамж




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Нөөц сан: Даатгалын салбарын орлогод тооцоогүй хураамжийн нөөц болон нөөц сангийн нийлбэр дүн буюу нийт нөөц сангийн хэмжээ тайлант жилд 118.1 тэрбум төгрөгт хүрсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 26.9 хувиар өссөн үзүүлэлт байлаа. Ердийн даатгалын компаниудын нийт нөөц сангийн

хэмжээ 23.7 хувиар өсөж 96.6 тэрбум төгрөг, урт хугацааны даатгалын компанийн нөөц сан 1.8 хувиар өсөж 1.6 тэрбум төгрөг, давхар даатгалын компанийн нөөц сан 48.3 хувиар өсөж 19.9 тэрбум төгрөг болов.

Зураг 17. Нөөц сангийн хэмжээ, өсөлт



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Нөөц сангийн хөрөнгийн 50 орчим хувь нь арилжааны банкуудад хадгаламж болон хадгаламжийн сертификат хэлбэрээр байршиж байна.


### 2.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

ББСБ-уудын тоо: 2017 оны байдлаар санхүүгийн зах зээл дээр 534 ББСБ нийт 10 төрлийн үйл ажиллагааг дагнан болон хавсран эрхэлж байна. Санхүүгийн зохицуулах хорооноос 2017 онд

нийт 31 ББСБ-д үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгож, 15 ББСБ-ын үйл ажиллагааг хүчингүй болгосон ба 2014 онд 50 орчим хувийн өсөлттэй байсан банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэгчдийн тооны өсөлт сүүлийн жилүүдэд харьцангуй саарч тайлант онд 3.1 хувь болж буурлаа.

2017 оноос эхлэн цахим мөнгөний харилцагчдын бүртгэлийг нэмж тооцож эхэлсэн ба ББСБ-ын салбарын нийт харилцагчдын тоо 1.47 саяд хүрлээ.

Зураг 18. ББСБ–уудын тоо




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ББСБ–уудын хөрөнгө: Тайлант онд ББСБ–уудын нийт хөрөнгийн хэмжээ 23.1 хувиар өсөж 969.2 тэрбум төгрөгт хүрсэн нь ДНБ–ий 3.6 хувьтай тэнцүү байна. Санхүүгийн зохицуулах хорооноос 2016 оны 10 дугаар сард ББСБ–уудын хувь


нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх шийдвэр гаргасан ба уг шийдвэрийн үр дүнд ББСБ–уудын хөрөнгийн чадавх сайжирч байна. Тухайлбал 2017 оны нийт хөрөнгийн өсөлтийн 84.6 хувийг хувь нийлүүлсэн хөрөнгийн өсөлт бүрдүүлсэн.

Зураг 19. Нийт хөрөнгийн өсөлт



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зураг 20. ББСБ–уудын тоо, салбарын нийт хөрөнгөд эзлэх хувиар




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Нийт салбарын хөрөнгийн 1–ээс бага хувийг эзэлж байгаа ББСБ–уудын тоо 520 байгаа бол хөрөнгийн хэмжээгээр хамгийн том ББСБ–ын нийт хөрөнгө салбарын хөрөнгийн 3.6 хувийг бүрдүүлж байна. Өөрөөр хэлбэл зах зээлд үйл ажиллагаа явуулж буй ББСБ–ууд хэмжээний хувьд хоорондоо харьцангуй ижил, зах зээлд давамгайл нөлөө үзүүлэх, бусдаасаа хэт том хэмжээтэй ББСБ байхгүй байна.

ББСБ–уудын зээл: Нийт зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 33.4 хувиар нэмэгдэн 638 тэрбум төгрөгт хүрсэн ба хөрөнгийн өсөлтөөс 1.4 дахин өндөр байна. Өөрөөр хэлбэл ББСБ–уудын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нэмэгдэж, салбарын хөрөнгийн чадавх сайжирсны үр дүнд зах зээлд олгож буй зээлийн хэмжээ өсөж байна.

Зураг 21. Нийт зээлийн өсөлт




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


Нийт зээлийн үлдэгдлийн 94.9 хувь нь төгрөгөөр олгосон зээл, 5.1 хувь нь валютаар олгосон зээл байна. Мөн нийт зээлийн үлдэгдлийн 82.6 хувь нь хэвийн зээл, 4.7 хувь нь хугацаа хэтэрсэн

зээл, 12.7 хувь нь чанаргүй зээл байна. Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 0.3 пунктээр өсөж, өмнөх улирлаас 1.6 пунктээр буурлаа.

Зураг 22. Зээлийн төрөл /валютаар/



Зураг 23. Зээлийн төрөл /чанараар/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зээлийн зориулалт: 2017 онд нийт 676.5 тэрбум төгрөгийн зээл олгогдож, 519 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдөж, нийт зээлийн үлдэгдэл 638 тэрбум төгрөгт хүрсэн. Нийт зээлийн үлдэгдлийн 81 хувийг иргэнд, 19 хувийг хувийн хэвшилд олгосон зээлийн үлдэгдэл эзэлж байна.

худалдааны салбар, 10.2 хувь нь барилгын салбар, 3.8 хувь нь уул уурхайн салбар, 3.3 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбаруудад тус тус олгогдсон байна. Нийт олгосон зээлийн эргэн төлөлтийг эдийн засгийн гол салбараар авч үзвэл 49.9 хувь нь хэрэглээний зээлээс, 25.6 хувь нь худалдааны салбараас, 11.7 хувь нь барилгын салбараас, 2.9 хувь нь уул уурхайн салбараас, 3.4 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбараас эргэн төлөгдсөн байна.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбаруудаар авч үзвэл шинээр олгосон зээлийн 50.6 хувь нь хэрэглээ, 24.5 хувь нь бөөний жижиглэн

Зураг 24. Олгосон болон төлөгдсөн зээл /зориулалтаар/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зээлийн хүү: Салбарын зээлийн нийлүүлэлт нэмэгдсэнээр банкнаас бусад санхүүгийн үйлчилгээний хүртээмж нэмэгдэж, зээлийн бүтээгдэхүүний үнэ болох хүүгийн түвшин буурч

буй зэрэг эерэг өөрчлөлтүүд ажиглагдаж байгаа ба тайлант онд ББСБ-ын жигнэсэн дундаж сарын хүү 4.0 хувиас 3.4 хувь болж буурлаа.

Зураг 25. Зээлийн хүү



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

#### ШИГТГЭЭ 4.

##### ОЛОН УЛС ДАХЬ БИЧИЛ САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТООН ҮЗҮҮЛЭЛТ

2016 оны байдлаар бичил санхүүгийн байгууллагуудын хэрэглэгчдийн тоо дэлхийн хэмжээнд 9.6 хувиар өсөж 132 саяд, нийт зээлийн хэмжээ 9.4 хувиар өсөж 102 тэрбум долларт хүрлээ.

Дэлхийн бичил санхүүгийн салбарын нийт зээлийн 76 хувийг бүрдүүлдэг топ 100 компанийн зээлийн хэмжээ 77.1 тэрбум доллар, хэрэглэгчдийн тоо 81.1 сая байна.

Өмнөд Азийн нийт хэрэглэгчдийн тоо 13.4 хувиар, нийт зээлийн хэмжээ 23.5 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа ба уг бүс нутаг дэлхийн нийт хэрэглэгчдийн 59 хувийг дангаараа бүрдүүлж байна. Латин Америк, Карибын орнуудын хувьд хэрэглэгчдийн тоо 8 хувиар, нийт зээлийн хэмжээ 9.2 хувиар өсжээ. Тус бүс нутгийн бичил санхүүгийн байгууллагууд сүүлийн жилүүдэд их хэмжээгээр нэгдэн нийлж байгаа ба уг үйл ажиллагаа Перу улсын бичил санхүүгийн салбарт эерэг өөрчлөлтийг авчирж байгаа бол Мексик улсын хувьд салбарын өсөлтийг удаашруулах нөлөө үзүүлж байна. Зүүн Европ, Төв Азийн бүс нутгийн хувьд нийт зээлийн хэмжээ 11.1 хувиар, зээлдэгчдийн тоо 2.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Африк тивийн бичил санхүүгийн салбарын нийт зээлийн хэмжээ 0.6 хувиар буурсан бол, зээлдэгчдийн тоо 2.3 хувиар өссөн үзүүлэлттэй байлаа. Кени, Танзани, Нигер улсууд бүс нутгийн хэмжээнд хамгийн их зээлтэй байгаа бол Уганда, Бенин, Нигер улсууд зээлдэгчдийн тоогоор тэргүүлж байна.

Дэлхийн хэмжээнд бичил санхүүгийн байгууллагуудын нийт зээлдэгчдийн 84 хувийг эмэгтэй зээлдэгчид эзэлж байгаа ба Зүүн Ази, номхон далайн бүсийн орнуудад нийт зээлдэгчдийн 94 хувь нь эмэгтэй, Өмнөд Ази 92 хувь, Латин Америк, Карибын орнуудад 60 гаруй хувь, Зүүн Европ, Төв Азид уг харьцаа 46 хувь байна.

2016 оны байдлаар бичил санхүүгийн салбарын нийт хэрэглэгчдийн 60 гаруй хувь нь хөдөө, орон нутгийн хэрэглэгчид байсан бол арилжааны банкуудын хувьд ердөө 26 хувь нь орон нутгийн хэрэглэгчид байгаа юм.

2016 оны байдлаар бичил санхүүгийн салбарын үзүүлэлтээр дэлхийд тэргүүлж буй улсууд:

№	Улс	Зээлдэгчдийн тоо, өсөлт	Нийт зээлийн хэмжээ, өсөлт (USD)
1	Энэтхэг	47.0 сая (+18.4%)	14.7 тэрбум (+24.4%)
2	Вьетнам	7.6 сая (0.0%)	7.4 тэрбум (+0.2%)
3	Бангладеш	25.2 сая (+5.1%)	6.9 тэрбум (+19.7%)
4	Перу	4.6 сая (+12.4%)	10.8 тэрбум (+16.3%)
5	Мексик	7.0 сая (+3.2%)	4.4 тэрбум (-6.4%)
6	Камбож	2.3 сая (-0.1%)	6.4 тэрбум (+20.7%)
7	Колумб	2.8 сая (+0.4%)	6.0 тэрбум (+12.5%)
8	Болив	1.3 сая (+2.4%)	7.4 тэрбум (+13.1%)
9	Бразил	3.2 сая (0.0%)	1.9 тэрбум (+11.8%)
10	Эквадор	1.3 сая (-10.0%)	5.1 тэрбум (-7.2%)

2016 онд үйл ажиллагаа явуулж буй нийт бичил санхүүгийн байгууллагуудын тал хувь нь 8.1 хувиас өндөр өөрийн хөрөнгийн өгөөжтэй ажилласан ба байгууллагуудын зээлийн үйлчилгээнээс олох ашиг дунджаар 26.5 хувьтай байна. Африк тивд зээлийн үйлчилгээнээс олох ашиг хамгийн өндөр буюу 34.3 хувь байсан бол Зүүн Ази хамгийн бага буюу 22.8 хувьтай байна.

Салбарын хэмжээнд зээлийн хугацаа дууссанаас хойш 30 хоногийн дотор эргүүлж төлөөгүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 4.7 байна. Дэлхийн хэмжээнд бичил санхүүгийн байгууллагуудын эх үүсвэрийн 57 хувийг хадгаламж, 23 хувийг өр төлбөр, 20 хувийг эздийн өмч бүрдүүлж байна.


Эх сурвалж: Бичил санхүүгийн салбарын тоон үзүүлэлтүүд 2016 он.

## 2.4 ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН

Олгосон батлан даалтын тоо: 2017 онд Зээлийн батлан даалтын сангаас олгосон батлан даалтын

тоо хэмжээ 61 болж өссөн байна. Энэ нь өмнөх оноос 25-аар өссөн үзүүлэлт юм.

Зураг 26. Олгосон батлан даалтын тоо




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Олгосон батлан даалтын дүн: Тайлант онд зээлийн батлан даалтын сангийн олгосон батлан даалтын хэмжээ хуримтлагдсан дүнгээр өмнөх оны мөн

үеэс 50 хувиар өсөж 12.0 тэрбум төгрөгт хүрлээ. Нийт батлан даалт гаргасан зээлийн хэмжээ 24.2 тэрбум төгрөг байна.

Зураг 27. Олгосон батлан даалтын хэмжээ /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Олгосон батлан даалтын хэмжээ байршлаар: 2017 онд гаргасан 37 батлан даалтын 3 нь төвийн бүс буюу Өмнөговь, Сэлэнгэ аймгуудад, 3 нь зүүн бүс

буюу Дорнод, Сүхбаатар аймгуудад, үлдсэн 31 нь Улаанбаатар хотод олгогдсон байна.

## 2.5 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

Монгол Улсын хэмжээнд 2017 оны байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос хадгаламж, зээлийн хоршооны тусгай зөвшөөрлийн эрхтэй 290 хоршоо үйл ажиллагаа явуулж байна. Өнгөрсөн онтой харьцуулахад нийт хоршоодын


тоо 3.6 хувиар нэмэгдэж, нийт гишүүдийн тоо 20 хувиар буюу 9,441–ээр нэмэгдэж 55,624–т хүрлээ. Хөдөө орон нутаг дахь салбар нэгжийн тоо 14–өөр өссөн нь нийт салбар нэгжийн тоо 175 хувиар өсөхөд шууд нөлөөлөв.

Хүснэгт 2. ХЗХ–дын статистик үзүүлэлт

№	Үзүүлэлтүүд	2016	2017	Өөрчлөлт	
		дүн	дүн	дүн	хувь
1	Нийт ХЗХ тоо	280	290	10	4%
	Үүнээс: Хөдөө орон нутагт	96	98	2	2%
2	Гишүүдийн тоо	46,183	55,624	9,441	20%
	Үүнээс: эмэгтэй	26,605	31,968	5,363	20%
	Хуулийн этгээд	588	421	(167)	-28%
4	Ажиллагсдын тоо	750	745	(5)	-1%
	Үүнээс эмэгтэй	542	541	(1)	0%
5	Салбар нэгжийн тоо	8	22	14	175%
	Үүнээс: Улаанбаатар хотод	7	7	-	0%
	Үүнээс: Хөдөө орон нутагт	1	15	14	14 дахин

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зураг 28: ХЗХ-дын тоо, аймгаар




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ХЗХ-дын тоо болон гишүүд: 2017 оны эцсийн байдлаар ХЗХ-дын тоо өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 3.6 хувиар буюу 10-аар өссөн ба үүнээс Улаанбаатар хотод 192 ХЗХ, хөдөө орон нутагт 98 ХЗХ тус тус үйл ажиллагаа явуулж байна.

Хадгаламж, зээлийн хоршоодын гишүүдийн тоо өнгөрсөн оноос 20.4 хувиар өсөж 55,624 болсноос 57.5 хувь нь эмэгтэй, 42.5 хувь нь эрэгтэй гишүүд байна. Нийт гишүүдийн дийлэнх буюу 61.7 хувь

нь нийслэл Улаанбаатар хотын ХЗХ-дод, үлдсэн 38.3 хувь нь аймаг, орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дод харьяалагдаж байна. Харин газарзүйн байршлаар авч үзвэл Баруун бүсийн ХЗХ-дын гишүүдийн тоо өмнөх оноос 15.2 хувиар өсөн 8,254-т хүрч нийт аймаг, орон нутгийн гишүүдийн 38.8 хувийг, Хангайн бүсийн хувьд гишүүдийн тоо өмнөх оноос 6.7 хувиар өсөж 6,599-т хүрснээр нийт аймаг, орон нутгийн гишүүдийн 31.0 хувийг эзэлж байна.

Зураг 29: ХЗХ-дын тоо болон гишүүдийн тоо




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо



Хөрөнгийн үзүүлэлт: Тайлант улиралд нийт хөрөнгийн хэмжээ 153.1 төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 35.4 хувийн өсөлтийг үзүүлж, 2008 оноос хойш анх удаа 30-аас дээш хувийн өсөлт үзүүллээ. Нийт хөрөнгийн өсөлтийн 79.5 хувийг хадгаламжийн өсөлт тайлбарлаж байгаа бөгөөд

нийт хадгаламжийн хэмжээ өнгөрсөн онуудтай харьцуулахад хамгийн өндөр буюу 47.2 хувийн өсөлтийг үзүүлэв. Хадгаламжийн 96.7 хувийг хугацаатай хадгаламж, 3.3 хувийг хугацаагүй хадгаламж эзэлсэн байна.

Зураг 30. Нийт хөрөнгө ба хадгаламж /тэрбум төгрөг/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Салбарын нийт хөрөнгийн 82.0 хувийг 500 сая төгрөгөөс дээш хөрөнгөтэй 30 ХЗХ эзэлж байгаа

бол үлдсэн 18.0 хувийг 500 саяас доош төгрөгийн хөрөнгөтэй 260 ХЗХ эзэлж байна.

Зураг 31. Хөрөнгийн хэмжээнд эзлэх хувь /хөрөнгийн бүлгээр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Тайлант онд ХЗХ-дын хувь нийлүүлсэн хөрөнгө өнгөрсөн жилээс 22.1 хувь буюу 2.6 тэрбум төгрөгөөр өсөж 14.9 тэрбум төгрөгт хүрсэн байна. Хоршоологчдын өмч өнгөрсөн жилээс 23.4 хувиар буюу 2.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 14.9 тэрбум

төгрөгт хүрсэн ба түүний бүрдэл болох нөөц сан 22 хувь, хуримтлагдсан ашиг 51 хувийг эзэлж байна. ХЗХ-дын нийт орлого, зарлага, ашиг мөн адил өндөр өсөлттэй байгаа бөгөөд илүү дэлгэрэнгүй ашигт ажиллагаа бүлгээс харна уу.

Хүснэгт 3. ХЗХ-дын актив ба пассивын ерөнхий үзүүлэлт /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2016	2017	Өөрчлөлт	
			Дүн	Хувь
Нийт хөрөнгө	113.1	153.1	40.0	35.4%
Нийт зээл	84.4	105.2	20.8	24.6%
Хэвийн зээл	74.6	95.7	21.1	28.3%
Хугацаа хэтэрсэн зээл	5.2	5.0	(0.2)	-3.1%
Чанаргүй зээл	4.6	4.5	(0.1)	-3.4%
Хэвийн бус зээл	1.2	1.1	(0.1)	-4.7%
Эргэлзээтэй зээл	1.9	1.6	(0.3)	-14.2%
Муу зээл	1.5	1.7	0.2	16.3%
Хадгаламж	68.2	99.3	31.1	45.8%
Хугацаагүй	3.2	3.3	0.1	2.9%
Хугацаатай	64.9	96.1	31.2	48.0%
Хувь нийлүүлсэн хөрөнгө	12.3	14.9	2.6	22.1%
Хоршоологчдын өмч	12.1	14.9	2.8	23.4%
Нийт орлого	24.7	31.8	7.1	28.8%
Нийт зарлага	20.9	26.3	5.4	26.0%
Нийт ашиг	3.8	5.5	1.7	44.0%

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо



delivered solid results in a challenge





## ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ


# ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

## 3.1 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Зохицуулалттай этгээдүүд: 52 ҮЦК болон тэдгээрийн салбар төлөөлөгч болох 16 ҮЦК, нийтдээ 68 ҮЦК-ийн газарзүйн байршлын тархалтыг харууллаа. Нийт ҮЦК-ийн салбаруудаас 15 нь хөдөө орон нутагт байршиж байгаа ба төвийн

бүсэд 4, говийн бүсэд 3, хангайн бүсэд 6, баруун бүсэд 2 байна. Харин үлдсэн 1 салбар болон 52 ҮЦК нь Улаанбаатар хотод үйл ажиллагаагаа явуулж байна.

Зураг 32. ҮЦК-уудын байршлын тархалт



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Дэлхийн банкнаас хүртээмжтэй байдлыг хэмжихдээ зах зээлийн үнэлгээ, арилжааны дүн, хувьцааны төвлөрөл, Херфиндаль–Хиршманы индекс (НИИ) зэрэг үзүүлэлтээр тус бүр эхний 10–т жагсаж буй компаниудыг тодорхойлдог. Харин бондын зах зээлийн хүртээмжтэй байдлыг бонд гаргагчийн тоо, бүртгэлтэй бондын тоо болон шинээр бүртгэгдсэн бондын тоо, мөн гадны этгээдийн дотоодын валютаар гаргасан бонд зэрэг үзүүлэлтээр тооцдог байна.

Дээрх үзүүлэлтүүдээс тайлант жилд хувьцааны зах зээлийн хувьд зах зээлийн үнэлгээгээрээ эхний 10–т жагсаж буй компаниуд, тэдгээрийн

хувьцааны төвлөрөл, мөн нэмэлтээр үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид хадгалагдаж буй үнэт цаас зэрэг үзүүлэлтүүдийг тооцон гаргасан бол бондын зах зээлийн хувьд үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэлтэй бондын мэдээллийг тооцон харууллаа.


Топ 10 ХК-ийн төвлөрөл (зах зээлийн үнэлгээгээр): 2017 оны жилийн эцсийн байдлаар зах зээлийн үнэлгээний 79.7 хувийг 10 компани бүрдүүлсэн бөгөөд эдгээр компаниудын ихэнх нь уул уурхай, аж үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа тул уул уурхайн салбарын өсөлт, бууралт нь дотоодын үнэт цаасны зах зээлийн үнэлгээнд шууд нөлөө үзүүлж байна.

Хүснэгт 4. 3ЗҮ өндөр 10 компани /тэрбум төгрөг/

№	Компанийн нэр	Зах зээлийн үнэлгээ	№	Компанийн нэр	Зах зээлийн үнэлгээ
1	АПУ	762.7	6	УБ-БҮК	59.2
2	Таван толгой	469.2	7	Монгол шуудан	55.1
3	МИК холдинг	216.4	8	Багануур	48.2
4	Говь	181.4	9	Гутал	30.7
5	Сүү	87.7	10	Талх чихэр	30.6

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зураг 33. 3ЗҮ өндөр 10 компани /салбараар/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Эдгээр зах зээлийн үнэлгээ өндөртэй 10 компанийг үйл ажиллагаа явуулж буй салбараар нь ангилан харуулав. Компаниудын 70 хувь нь

уул уурхай болон аж үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулж байна.

Хувьцааны төвлөрөл: Аливаа хувьцаат компанийн нийтэд арилжаалагдаж буй хувьцааны дийлэнх хувь нь цөөн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн гарт байхыг хувьцааны төвлөрөл гэнэ. Компанийн нийт гаргасан хувьцааны 5 хувиас дээш хувьцааг эзэмшдэг бол том хувьцаа эзэмшигч, 5 хувиас бага бол жижиг хувьцаа эзэмшигч болдог байна. 2017 оны жилийн эцсийн байдлаар 3ЗҮ-ээр эхний 10-г жагсаж буй компаниудын хүрээнд хувьцааны төвлөрлийг тооцож үзэхэд нийт хувьцаа эзэмшигчдийн 0.1 хувь болох том хувьцаа эзэмшигчид нийт гаргасан хувьцааны 93.8 хувийг эзэмшиж байгаа бол үлдсэн 99.9 хувь нь нийт хувьцааны 6.2 хувийг эзэмшиж байна.

Зураг 34. 3ЗҮ өндөр 10 ХК-ийн хувьцааны төвлөрөл



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хувьцааны төвлөрөлтэй байгаа нь гадны хөрөнгө оруулагчдад 2 талын үр дагаварыг бий болгодог. Нэгдүгээрт, нийт хувьцааны ихэнх хувь нь цөөн хувьцаа эзэмшигчдийн гарт төвлөрч байгаа нь бусад хөрөнгө оруулагчдад маш бага хувь

ногдуулдаг бөгөөд энэ нь хөрвөх чадварыг бууруулдаг бол хоёрдугаарт, бусад хөрөнгө оруулагчдад компанийн үйл ажиллагааг хянахад саад тотгорыг бий болгодог байна.

Бүртгэлтэй хувьцаа: “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-д 2017 оны жилийн эцсийн байдлаар нийт 320 ХК-ийн 1.4 их наяд төгрөгийн зах зээлийн үнэлгээ бүхий 27,691,202,478 ширхэг үнэт цаас хадгалагдаж байна. Үүнээс: Нээлттэй ХК-ийн бүртгэлд 313 ХК-

ийн 7,476,702,978 ширхэг хувьцаа, үүнээс төрийн өмчтэй 34 ХК-ийн 2,818,123,684 ширхэг хувьцаа, орон нутгийн өмчтэй 9 ХК-ийн 29,045,916 ширхэг хувьцаа хадгалагдаж байна. Хаалттай ХК-ийн бүртгэлд 6 ХК-ийн 5,214,499,500 ширхэг хувьцаа хадгалагдаж байна.

Хүснэгт 5. ҮЦТХТ-д бүртгэлтэй хувьцаа /мянган ширхэг/

Үзүүлэлт	2015 он	2016 он	2017 он
<b>1. Бүртгэлтэй хувьцаа</b>			
Төрийн мэдлийн бус хувьцаа	2,809,930	4,160,854	4,629,533
Төрийн мэдлийн хувьцаа	2,246,316	2,818,124	2,818,124
Орон нутгийн оролцоотой	29,046	29,046	29,046
Нийт	5,085,292	7,008,024	7,476,703
<b>2. Биржийн бус зах зээлд бүртгэлтэй үнэт цаас</b>			
Эрдэнэс Тавантолгой /Иргэн/	2,558,176	2,212,224	2,212,224
Эрдэнэс Тавантолгой /ААН/	5,139	5,203	7,065
Эрдэнэс Тавантолгой /Төр/	12,436,685	12,782,573	-
Эрдэнэс Тавантолгой / “Эрдэнэс Монгол” ХХК/	-	-	9,780,711
Эрдэнэс Тавантолгой /Арилжигдаагүй үлдэгдэл/	-	-	3,000,000
Нийт	15,000,000	150,000,000	15,000,000
Хаалттай ХК	172,753	174,958	5,214,500
Нийт	172,753	174,958	5,214,500

Эх сурвалж: “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 154 дүгээр тогтоолд заасны дагуу төвлөрсөн хадгаламжид бүртгэлтэй “Эрдэнэс Монгол” ХК-ийн нийт 15,000,000,000 ширхэг хувьцааны төрийн мэдлийн 9,780,711,099 ширхэг хувьцааг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн эзэмшилд шилжүүлж, 20 хувь буюу 3,000,000,000 ширхэг хувьцааг арилжигдаагүй үлдэгдлээр бүртгэсэн болно.

2014 онд СЗХ-ноос батлагдсан Хаалттай ХК-ийн хувьцааг бүртгэх, хадгалах, өмчлөх эрх шилжүүлэх үйл ажиллагааны журмын дагуу 7 хаалттай ХК-ийн 5,224,499,500 ширхэг хувьцаа бүртгэгдсэнээс 2017 оны жилийн эцсийн байдлаар 6 хаалттай ХК-ийн 5,214,499,500 ширхэг хувьцаа бүртгэлтэй байна. Үүнд:

Хүснэгт 6. Хаалттай ХК-ийн нэрс

№	Хаалттай ХК-ийн нэр	Хувьцааны тоо ширхэг
1	Хөдөө аж ахуйн давхар даатгал	150,000,000
2	Ард санхүүгийн нэгдэл	22,752,700
3	Апи ресурс	2,205,000
4	Монгол базальт	39,491,900
5	Стор альянс фонд	49,900
6	Монголын үнэт цаасны бирж	5,000,000,000

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо



Бүртгэлтэй бонд: Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид 2017 оны жилийн эцсийн байдлаар нийт 35 төрлийн 29,972,388 ширхэг компанийн бонд, 154 төрлийн 5,555,154 ширхэг Засгийн газрын бонд бүртгэлтэй байна. Үүнээс 30 төрлийн

29,679,424 ширхэг хөрөнгөөр баталгаажсан бонд, 70 төрлийн 1,988,140 ширхэг Засгийн газрын бонд нь биржийн бус зах зээл буюу хаалттай хэлбэрээр бүртгэгдсэн байна.

Хүснэгт 7. ҮЦТХТ–д бүртгэлтэй бонд /мянган ширхэг/


Үзүүлэлт	2015 он	2016 он	2017 он
1. Бүртгэлтэй үнэт цаас			
Засгийн газрын бонд	2,415	2,808	3,567
Компанийн бонд	283	233	293
Нийт	2,698	3,041	3,860
2. Биржийн бус зах зээлд бүртгэлтэй үнэт цаас			
Компанийн бонд	20,668	21,870	29,679
Засгийн газрын бонд	2,314	3,725	1,988
Нийт	22,982	25,595	31,667

Эх сурвалж: “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК

Данс эзэмшигчид: “Монголын хөрөнгийн бирж” ХК–д хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш төвлөрсөн хадгаламжид өссөн дүнгээр нийт 906,116 данс, 143,244 холболтын данс нээгдсэн. Нийт дансыг бүтцээр нь үзвэл, 901,248 дотоодын иргэн, 2,057 гадаадын иргэн, 2,624 дотоодын аж ахуйн нэгж, 187 гадаадын аж ахуйн нэгжийн данс тус тус байна.

Тайлант хугацаанд үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид нийт 19,544 данс шинээр нээгдсэнээс 19,334 нь дотоодын иргэн, 107 нь гадаадын иргэн, 94 нь дотоодын аж ахуйн нэгж, 9 гадаадын аж ахуйн нэгжийн данс тус тус эзэлж байна.

Зураг 35. Шинээр нээгдсэн данс




Эх сурвалж: “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК

### 3.1.1 ХАА–н гаралтай бараа, түүхий эдийн зах зээл

2017 оны байдлаар Хөдөө аж ахуйн биржийн гишүүн 16 брокерын компани Хорооноос тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаагаа явуулж байна. Тэдгээрээс 5 брокер хөдөө орон нутагт

байрладаг ба баруун бүсэд 3, зүүн бүсэд 1, төвийн бүсэд 1 брокер тус тус үйл ажиллагаагаа явуулж байна. Харин үлдсэн 11 брокер Улаанбаатар хотод төвлөрөн ажилладаг байна.

Зураг 36. Хөдөө орон нутгууд дахь брокеруудын байршил




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

### 3.2 ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

Даатгалын нягтралын үзүүлэлт буюу нэг хүнд ногдох хураамжийн орлогын харьцаа нь салбарын хүртээмж, эрэлтийг илэрхийлдэг. 2016 оны жилийн эцэст нэг хүнд ногдох даатгалын хураамжийн хэмжээ 36,700.1 төгрөг байсан

бол 2017 оны жилийн эцэст 7,865.8 төгрөгөөр буюу 21.4 хувиар өсөж 44,565.9 төгрөгт хүрчээ. Хураамжийн орлогын өсөлт хүн амын өсөлтөөс илүү байсан нь тус өсөлтөд нөлөөлөв.

Зураг 37. Даатгалын нягтрал /төгрөг/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Даатгалын нягтралыг ангиллаар авч үзвэл, нэг хүнд ногдох ердийн даатгалын хураамж 23.4 хувиар өсөж 44,157.3 төгрөг болсон бол урт хугацааны даатгалын хураамж 54.9 хувиар буурч 408.6 төгрөгт хүрсэн байна.

Даатгалын мэргэжлийн оролцогчдын салбар нэгж: Даатгалын үйлчилгээний хүртээмжийг илэрхийлэгч өөр нэгэн үзүүлэлт нь даатгалын байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын

тоо юм. Даатгалын компани, зуучлагч, хохирол үнэлэгч компаниудын 495 салбар, 18 төлөөлөгчийн газар Улаанбаатар хот, 21 аймаг болон БНХАУ, БНСУ-д үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр салбар, төлөөлөгчийн газрыг бүсээр ангилан харвал хангайн бүсэд хамгийн их буюу 89, төвийн бүсэд 62, баруун бүсэд 60, говийн бүсэд 58, зүүн бүсэд хамгийн бага буюу 47 салбар, төлөөлөгчийн нэгж тус тус үйл ажиллагаа явуулж байна.

Зураг 38. Даатгалын компани, зуучлагч, хохирол үнэлэгч компаниудын салбар, төлөөлөгчийн газрын байршил




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Тайлант хугацаанд Улаанбаатар хотын нийт дүүрэгт даатгалын компани, зуучлагч, хохирол үнэлэгч компанийн 195 салбар, төлөөлөгчийн

газар бүртгэгдэв. Нийт салбар нэгжийн 91 хувь нь төвийн 6 дүүрэгт төвлөрсөн байна.

Зураг 39. Даатгалын компани, зуучлагч, хохирол үнэлэгч компаниудын салбар, төлөөлөгчийн газрын байршил /дүүргээр/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

### 3.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

ББСБ–уудын тархалт: Улсын хэмжээнд нийт 534 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаагаас 86.9 хувь буюу 464 нь Улаанбаатар хотод үлдсэн 13.1


хувь буюу 70 нь хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж байна. Монгол Улсын 21 аймагт бүгдэд нь ББСБ–ууд үйл ажиллагаа явуулж байна.

Зураг 40. ББСБ–уудын тархалт /газар зүйн байршлаар/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зураг 41. ББСБ–уудын тархалт /дүүргээр/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 464 ББСБ–ын 31.9 хувь нь Чингэлтэй дүүрэгт, 34.1 хувь нь Сүхбаатар дүүрэгт, 14 хувь нь Баянгол дүүрэгт, 2.6 хувь нь Сонгинохайрхан дүүрэгт, 9.7 хувь нь Баянзүрх дүүрэгт, 6.7 хувь нь Хан-Уул дүүрэгт, 0.6 хувь нь Налайх дүүрэгт, 0.4 хувь нь Багануур дүүрэгт байрладаг бол одоогоор Багахангай дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг ББСБ харахан байхгүй байна.

ББСБ–уудын хүртээмж газар зүйн байршлаар: Монгол Улсын хэмжээнд 18–64 насны 100,000 иргэнд 37 ББСБ, 1000 ААН–д 9 ББСБ ногдож байна. Орон нутгийн хэмжээнд уг харьцаа 12,

4 байгаа ба 18–64 насны 100,000 иргэн, 1000 ААН–д ногдох ББСБ–ын тоогоор Төвийн бүс тэргүүлж байна.


Зураг 42. ББСБ-уудын хүртээмж /бүсээр/



Улаанбаатар хотын хэмжээнд 18–64 насны 100,000 хүнд ногдох ББСБ-ын тоо 68, 1000 ААН-д ногдох ББСБ-ын тоо 11 байна. Уг харьцаа

Сүхбаатар, Чингэлтэй дүүргүүдэд хамгийн өндөр дүнтэй байна.


Зураг 43. ББСБ-уудын хүртээмж /дүүргээр/



Зээлийн үйлчилгээний тархалт: Улсын хэмжээнд нийт 107 мянга орчим зээлдэгчид байгаа ба 18–64 насны хүн амын тоог зээлдэгчийн тоонд харьцуулсан харьцаа 18 байна. Өөрөөр хэлбэл улсын хэмжээнд 18–64 насны 18 хүн тутмын 1 нь ББСБ-аас зээл авсан байна. Харин орон нутагт уг харьцаа 183, Улаанбаатар хотын хэмжээнд 8 байна.

Түүнчлэн Монгол Улсын хэмжээнд ББСБ-аас зээл авсан нэг зээлдэгч дунджаар 5.9 сая төгрөгийн зээлтэй байгаа бол хөдөө орон нутагт нэг зээлдэгч дунджаар 3.3 сая төгрөгийн зээлтэй, Улаанбаатар хотын нэг зээлдэгч дунджаар 6.1 сая төгрөгийн зээлтэй байна.

Зураг 44. Зээлийн үйлчилгээний хүртээмж, байршлаар /мянган төгрөг/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ББСБ-уудын хүртээмж хүн амын үзүүлэлтээр: ББСБ-уудын хүртээмж хүйсийн хувьд харьцангуй тэнцвэртэй буюу нийт харилцагчдын 51.7 хувь нь эмэгтэй, 48.3 хувь нь эрэгтэй харилцагчид байна.


ББСБ-уудын нийт зээлдэгчдийн 46.8 хувь нь 18-

35 насны хүмүүс, 32 хувь нь 36-45 насны хүмүүс, 16.3 хувь нь 46-55 насны хүмүүс, 4.8 хувь нь 55-аас дээш насны хүмүүс байна. Зээлдэгчдийн насны бүлгээс харахад 18-45 насны хүмүүсийн зээл авах хандлага хамгийн өндөр буюу нийт зээлдэгчдийн 80 орчим хувийг бүрдүүлж байна.

Зураг 45. ББСБ-уудын харилцагчид /хүйсээр/



Зураг 46. ББСБ-уудын харилцагчид /насны бүлгээр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

### 3.4 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

Тайлант онд Монгол Улсын газар нутгийн хэмжээнд тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж байгаа нийт хоршоодын 192 нь нийслэл Улаанбаатар хотод, 98 нь хөдөө, орон нутаг бүртгэлтэй байна.

2017 оны нийт хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж буй хоршоодын 32.6 хувь нь баруун бүсэд,

13.3 хувь нь зүүн бүсэд, 28.6 хувь нь хангайн бүсэд, 16.3 хувь нь говийн бүсэд, үлдсэн 9.2 хувь нь төвийн бүсэд байна. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 192 ХЗХ-дын 92.8 хувь нь төвийн зургаан дүүрэгт, 7.8 хувь нь алслагдмал гурван дүүрэгт байна.

Хүснэгт 8. ХЗХ-дын нийт тоо /байршлаар/


Байршил	2016	2017	Өөрчлөлт	
	ХЗХ тоо	ХЗХ тоо	Дүн	Хувь
Баруун бүс	30	32	2.0	6.7%
Зүүн бүс	13	13	-	0.0%
Хангайн бүс	27	28	1.0	3.7%
Говийн бүс	16	16	-	0.0%
Төвийн бүс	10	9	(1.0)	-10.0%
Төвийн дүүрэг	169	177	8.0	4.7%
Алслагдмал дүүрэг	15	15	-	0.0%

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Сүүлийн 3 жилийн байдлаар хадгаламж, зээлийн хоршоодын гишүүдийг эдийн засгийн идэвхтэй 18–64 насны хүн амд харьцуулан тооцож хүртээмжийн үзүүлэлтийг байршлаар харуулвал

Монгол Улсын хэмжээнд 2015 онд 2.6 хувь байсан бол 2017 онд 1.4 пунктээр өсөж 4.0 хувь байна.

Зураг 47. Монгол Улсын 18–64 насны эдийн засгийн идэвхтэй хүн амын тоонд нийт гишүүдийн эзлэх хувь



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ШИГТГЭЭ 5:

ОЛОН УЛСЫН ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН ЗАХ ЗЭЭЛ


Дэлхийн хадгаламж, зээлийн хоршоодын холбооноос улс орнуудын статистик тайлан гаргадаг бөгөөд 2016 оны тайланд 6 тивийн нийт 109 улс орнуудын 68 мянган хоршоо үйл ажиллагаа явуулж байна. Тус тайлангийн хүртээмжийн үзүүлэлт болох хоршоодын гишүүдийн хүн амыг эдийн засгийн идэвхтэй хүн амд харьцуулсан хувиар дэлхийн нийт улс орны дундаж 13.6 хувьтай бол Ази тив 8 хувьтай байна.

Эх сурвалж: Дэлхийн хадгаламж, зээлийн хоршоодын холбоо

ХЗХ-дын гишүүдийг эдийн засгийн идэвхтэй 18–64 насны хүн амд харьцуулсан үзүүлэлтийг байршлаар харвал алслагдмал дүүрэгт хамгийн их буюу 4.6 хувьтай байгаа бол төвийн 6 дүүрэгт

4.0 хувьтай байна. Аймаг орон нутгийн хэмжээнд төвийн бүсэд хамгийн бага буюу 0.8 хувьтай байгаа бол баруун бүсэд 3.5 хувьтай байна.

Зураг 48. 18–64 насны эдийн засгийн идэвхтэй хүн амын тоонд нийт гишүүдийн эзлэх хувь /бүсээр/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хадгаламжийн үзүүлэлт: Нийт ХЗХ-дын 89.3 хувь буюу 259 ХЗХ нийт 99.3 тэрбум төгрөгийн хадгаламж төвлөрүүлсэн бол үлдсэн 11.3 хувь буюу 31 ХЗХ нь огт хадгаламж татаагүй байна. Хадгаламжийн хэмжээгээр нэг тэрбумаас дээш төгрөгийн хэмжээтэй 12 ХЗХ нь нийт 84.1 тэрбум

төгрөг буюу салбарын 84.6 хувийг, зуун саяас нэг тэрбум төгрөгийн хадгаламжийн хэмжээтэй 37 ХЗХ нь нийт 10.6 тэрбум төгрөг буюу салбарын 10.7 хувийг эзлэх ба үлдсэн 4.7 хувийг 210 ХЗХ эзэлж байна.

Зураг 49. Хадгаламжийн хэмжээ эзлэх хувь /бүлгээр/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2017 оны байдлаар хадгаламж, зээлийн хоршоодын нэг гишүүнд ногдох хадгаламжийн хэмжээгээр баруун бүсэд хамгийн ихдээ 1.2 сая төгрөг, дунджаар 0.1 сая төгрөгийн хадгаламж эзэмшиж байна. Хангайн бүсэд нэг хүнд ногдох хамгийн их хадгаламжийн хэмжээ 1.9 сая төгрөг,

дунджаар 0.3 сая төгрөг бөгөөд гишүүдийн хадгаламжийн хэмжээ харьцангуй зөрүүтэй харагдаж байна. Говийн бүсийн хувьд нэг хүнд ногдох хамгийн их хадгаламжийн хэмжээ бусад бүстэй харьцуулахад бага буюу 0.5 сая төгрөг байна.



Зураг 50. Нэг гишүүнд ногдох хадгаламжийн хэмжээ, байршлаар /сая төгрөг/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо





БҮТЭЭГДЭХҮҮН,  
ҮЙЛЧИЛГЭЭ


# БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

## 4.1 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ


2017 онд нийт 860.8 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий арилжаа хийгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 512.1 тэрбум төгрөгөөр буюу 147 хувиар өссөн үзүүлэлт юм. Нийт арилжааны үнийн дүнг бүтцээр нь авч үзвэл хувьцааны арилжаа 9.1 хувь, ЗГҮЦ–ны анхдагч зах зээлийн арилжаа 73.2 хувь, ЗГҮЦ–ны хоёрдогч зах зээлийн арилжаа 16.5 хувь, компанийн бондын

арилжаа 1.2 хувийг тус тус бүрдүүлсэн байна. Нийт 142.3 сая ширхэг үнэт цаас арилжаалсан бөгөөд арилжигдсан хэмжээний бүтцээр авч үзвэл 94.2 хувийг хувьцаа, 4.7 хувийг анхдагч зах зээл дээр арилжаалсан ЗГҮЦ, 1.0 хувийг хоёрдогч зах зээлд арилжаалсан ЗГҮЦ, 0.1 хувийг компанийн бонд бүрдүүлсэн байна.

Зураг 51. Нийт арилжааны бүтэц /үнийн дүнгээр/



Зураг 52. Нийт арилжааны бүтэц /хэмжээгээр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Нийт арилжааны үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад арилжигдсан үнэт цаасны тоо ширхэг 1.5 дахин, нийт үнийн дүн 2.5 дахин өссөн байна.

### 4.1.1 Хувьцааны зах зээл

Хувьцаат компанийн мэдээлэл: Тайлант хугацаанд СЗХ–ны үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлд нийт 300 компани бүртгэлтэй байна. Харин арилжаа эрхлэх байгууллагад 219, ҮЦТХТ–д 314 ХК тус тус бүртгэлтэй байна.

Хүснэгт 9. Үнэт цаас гаргагчийн өмчийн бүтэц


Үнэт цаас гаргагчийн өмчийн бүтэц	СЗХ	Арилжаа эрхлэх байгууллага	“ҮЦТХТ” ХХК
Төрийн өмчит	31	19	21
Төрийн өмчийн оролцоотой	19	12	22
Хувийн өмчит	250	188	271
Нийт	300	219	314

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хувьцааны арилжаа: Тайлант хугацаанд 135 компанийн 134.1 сая ширхэг хувьцааг 78.1 тэрбум төгрөгөөр арилжсан байна. Энэ нь өмнөх оны мөн

үеэс 29.1 тэрбум төгрөг буюу 59 хувиар өссөн үзүүлэлт юм.

Зураг 53. Хувьцааны гүйлгээний дүн /тэрбум төгрөг/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хөрөнгө оруулагчдын арилжаанд эзлэх хэмжээ: 2017 оны жилийн эцсийн байдлаар “Монголын хөрөнгийн бирж” ХК-аар дамжуулан 76.4 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдсэн байна. Хөрөнгө оруулагчдыг арилжааны дүнд эзлэх хэмжээгээр

ангиан авч үзвэл дотоодын иргэн 32.8 хувь буюу 25 тэрбум, дотоодын ААН 62.2 хувь буюу 47.5 тэрбум, гадаадын иргэн 2.5 хувь буюу 1.9 тэрбум, гадаадын ААН 2.5 хувь буюу 1.9 тэрбум төгрөгийн гүйлгээг тус тус бүрдүүлж байна.

Зураг 54. Хөрөнгө оруулагчдын хувьцааны зах зээлийн арилжаанд эзлэх хувь




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

### 4.1.2 Бондын зах зээл


2017 оны жилийн эцсийн байдлаар бондын анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаагаар өссөн дүнгээр нийт 782.7 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдсэн байна. Нийт дүнгийн 772.5 тэрбум төгрөгийг ЗГҮЦ-ны арилжаа, 10.2 тэрбум төгрөгийн арилжааг компанийн бонд бүрдүүлж байна.

Хөрөнгө оруулагчдын арилжаанд эзлэх хэмжээ: Хөрөнгө оруулагчдыг ЗГҮЦ-ны арилжааны дүнд эзлэх хэмжээгээр ангиан авч үзвэл нийт дүнгийн 17.8 хувийг дотоодын иргэн, 78.2 хувийг дотоодын ААН, 2.9 хувийг гадаадын иргэн, 1.1 хувийг гадаадын ААН бүрдүүлж байна.

Зураг 55. Хөрөнгө оруулагчдын ЗГҮЦ-ны зах зээлийн арилжаанд эзлэх хувь



Зураг 56. Хөрөнгө оруулагчдын компанийн бондын арилжаанд эзлэх хувь



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Харин компанийн бондын арилжааны нийт үнийн дүнгийн 49.7 хувийг дотоодын иргэн, 47.4 хувийг дотоодын ААН, 2.9 хувийг гадаадын иргэн бүрдүүлсэн байна.


гэж 5 ангилагддаг бол бодын хөөвөр нь сарлагийн, адууны, үхрийн гэсэн 3 ангилалд хуваагддаг.

### 4.1.3 ХАА–н гаралтай бараа, түүхийн эдийн зах зээл

ХАА–н гаралтай бараа, түүхий эдийн арилжаа: 2013 оны 4 дүгээр сард биржээр дамжин зөвхөн нэг төрлийн түүхий эд буюу ямааны ноолуур арилжаалагддаг байсан бол 2017 оны 4 дүгээр улирлын байдлаар бараа бүтээгдэхүүний төрөл нэмэгдэж 8 төрлийн хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эд арилжаалагддаг болсон. Үүнд: ямааны ноолуур, хонины ноос, тэмээний ноос, завод ноос, бодын хөөвөр, хүнсний буудай болон тосны ургамал зэрэг багтдаг. Завод ноос нь адууны, хонины, ямааны, сарлагийн, тэмээний

Тайлант онд Хөдөө аж ахуйн биржээр нийт 572.5 тэрбум төгрөгийн үнэ бүхий ямааны ноолуур, ямааны завод ноос, хонины ноос, тэмээний ноос, очёс, хонины завод ноос, сарлагийн хөөвөр зэрэг 7 төрлийн бүтээгдэхүүн арилжаалагдсан бөгөөд нийт арилжааг бүтцээр ангилан үзвэл 91.2 хувийг ямааны ноолуур, 4.3 хувийг ямааны завод ноос, 3.8 хувийг хонины ноос, үлдсэн 0.7 хувийг бусад бүтээгдэхүүнүүд тус тус эзэлж байна. Бүтээгдэхүүн тус бүрийг арилжигдсан хэмжээгээр нь өмнөх оны мөн үетэй харьцуулан авч үзэхэд ямааны ноолуур өмнөх оны мөн үеийнхээс 97.7 хувиар, хонины ноос 22 хувиар, тэмээний ноос 87.8 хувиар тус тус өссөн бол завод ноосноос ямааны завод ноос арилжаалагдаж 13 хувиар буурсан, харин хонины завод ноос болон бодын хөөвөр 2017 онд шинээр арилжаалагдаж эхэлсэн байна.

Зураг 57. ХАА–н гаралтай бараа, түүхий эдийн арилжаа /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2017 онд арилжигдсан хэмжээгээр ямааны ноолуур хамгийн их буюу 6,955.7 тонн, харин сарлагийн хөөвөр хамгийн бага буюу 0.1 тонн арилжаалагдсан байна.

Мөн 2017 оны 12 дугаар сарын 19-ний өдөр үүсмэл санхүүгийн хэрэгсэл болох форвард гэрээний арилжааг анх удаа Монголд зохион байгуулсан. Тус арилжаагаар нийт 11.5 тонн ноолуурыг 2018 оны 4 дүгээр сард худалдан авагчдад нийлүүлж, төлбөр тооцоо хийгдэх хэлцлүүд амжилттай хийгдсэн байна. Уг арилжаа явагдсанаар малчид болон хоршоодод зах зээлийн үнэ хэт унах эсхүл хөөрөгдөх эрсдэлээс сэргийлэх, түүхий эд боловсруулах үйлдвэрүүд түүхий эд нийлүүлэлтийн эрсдэл зэргээс сэргийлэх боломжийг олгож байна.

## 4.2 ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

Даатгалын зах зээл дээр ердийн, урт хугацааны болон давхар даатгалын нийт 24 хэлбэрийн даатгалын бүтээгдэхүүн арилжаалагдаж байна. Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалаас бусад бүх хэлбэрийн даатгал нь сайн дурын үндсэн дээр хийгдэж байна.


Тайлант хугацаанд даатгалын зах зээлийн хэмжээнд нийт 144.3 тэрбум төгрөгийн хураамжийг төвлөрүүлснээс ердийн даатгал 141.2 тэрбум төгрөг буюу нийт хураамжийн орлогын 97.8 хувь, урт хугацааны даатгал 1.3 тэрбум төгрөг буюу 0.9 хувь, хөдөө аж ахуйн давхар даатгал 1.9 тэрбум төгрөг буюу 1.3 хувийг бүрдүүлэв. Харин нийт нөхөн төлбөрийн зардалд ердийн даатгал 44.3 тэрбум төгрөг буюу 98.0 хувь, урт хугацааны даатгал 0.9 тэрбум төгрөг буюу 2.0 хувийг эзэлж байна.

Даатгалын нийт хураамжийн орлогын бүтцэд хөрөнгийн даатгал 25.4 хувь, жолоочийн хариуцлагын албан журмын даатгал 21.1 хувь, авто тээврийн хэрэгслийн даатгал 12.9 хувь, гэнэтийн осол эмчилгээний даатгал 12.4 хувь, хариуцлагын даатгал 7.5 хувь, агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал 5.0 хувь, барилга угсралтын даатгал 5.1 хувийг эзэлж байгаа бөгөөд 8.5 хувийг бусад ердийн даатгалын хэлбэрүүд, 0.9 хувийг урт хугацааны даатгал, 1.3 хувийг хөдөө аж ахуйн давхар даатгал тус тус эзэлж байна.

Даатгалын нийт нөхөн төлбөрийн бүтцэд жолоочийн хариуцлагын албан журмын даатгал 34.3 хувь, авто тээврийн хэрэгслийн даатгал 18.8 хувь, хөрөнгийн даатгал 15.3 хувь, гэнэтийн осол эмчилгээний даатгал 11.2 хувь, ачааны даатгал 4.7 хувь, санхүүгийн даатгал 5.4 хувийг эзэлж байгаа бөгөөд 8.2 хувийг бусад ердийн даатгалын хэлбэрүүд, 2.0 хувийг урт хугацааны даатгал тус тус эзэлж байна.

Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хураамжийн орлого 2016 оны жилийн эцэст өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 21.2 хувийн өсөлтийг үзүүлж байсан бол тайлант улиралд 9.5 хувийн жилийн өсөлттэй байлаа. Улмаар жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нийт хураамжийн орлого тайлант жилийн байдлаар 30.4 тэрбум төгрөг болж, нийт даатгалын хураамжийн орлогын 21.1 хувийг эзэлж байна. Харин нөхөн төлбөрийн хувьд өнгөрсөн онд 0.8 хувийн өсөлттэй байсан бол энэ оны жилийн эцэст 4.7 хувиар өсөж, 15.5 тэрбум төгрөгт хүрлээ. Салбарын нийт нөхөн төлбөрийн зардалд харьцуулахад 34.3 хувийг эзэлж байна.

Зураг 58. Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал, хураамж, нөхөн төлбөр /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Тус даатгалын бүтээгдэхүүний нөхөн төлбөр болон хураамжийн орлогын харьцаа 2014 оноос эхлэн харьцангуй тогтворжих төлөвтэй байгаа ба сүүлийн 4 жилийн дунджийг авч үзвэл 57.5 хувь байгаа юм. Харин тайлант жилд 50.9 хувьтай гарлаа.


**Даатгалын зуучлагчид:** 2014 оноос хойш зах зээлд дэх төвлөрөлт саарч, даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээний төрөлжилт бий болсноор даатгалын нэг бүтээгдэхүүний зах зээлд давамгайлах хандлага өөрчлөгдөх болсон.

Даатгалын зуучлагчдын хувьд жолоочийн хариуцлагын албан журмын даатгал, хөрөнгийн даатгал, зээлийн даатгал, авто тээврийн хэрэгслийн даатгалын бүтээгдэхүүн нь нийт зуучилсан хураамжийн орлого болон зуучлалын шимтгэлийн орлогын дийлэнх хэсгийг бүрдүүлж байна.

Харин 2015 оны хувьд бусад даатгалын бүтээгдэхүүний зах зээлд эзлэх хувь өндөр байсан ба үүний дийлэнх хэсгийг сайн дурын жолоочийн хариуцлагын даатгалын бүтээгдэхүүн бүрдүүлж байв. 2016 оноос жолоочийн хариуцлагын албан журмын даатгал, зээлийн даатгал, хөрөнгийн даатгалын эзлэх хувь өсөж байсан боловч 2017 оноос авто тээврийн хэрэгслийн даатгалын нийт орлогод эзлэх хувь өсөх хандлагатай байна.


Тайлант жилд даатгалын зуучлагчид нийт 21.3 их наяд төгрөгийн үнэлгээ бүхий даатгалын бүтээгдэхүүнийг зуучилж, зуучилсан даатгалын хураамжийн орлогын дүн 40.4 тэрбум төгрөгт хүрсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 32.1 хувиар өссөн үзүүлэлт байлаа. Харин даатгалын зуучлагчдын зуучлалын шимтгэлийн орлого өнгөрсөн оны мөн үед 5.1 тэрбум төгрөг байсан бол тайлант жилд өмнөх оны мөн үеэс 1.9 тэрбум төгрөг буюу 37.4 хувиар өсөж 7.0 тэрбум төгрөгт хүрэв.

Зураг 59. Зуучилсан даатгалын нийт хураамжийн орлого /бүтээгдэхүүнээр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зураг 60. Зуучлалын шимтгэлийн орлого /бүтээгдэхүүнээр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо




**Даатгалын хохирол үнэлэгч:** Тайлант жилд даатгалын хохирол үнэлэгч компаниуд нийт даатгалын тохиолдлын 24,310 хохирлыг 21.8 тэрбум төгрөгөөр үнэлэв. Нийт хохирол үнэлгээний орлого өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 0.1 тэрбум төгрөг буюу 17.5 хувиар өсөж, 0.8 тэрбум төгрөгт хүрэв. Энэхүү өсөлтийн 60.0 хувийг жолоочийн хариуцлагын албан журмын даатгал, 20.8 хувийг авто тээврийн хэрэгслийн

даатгал, 10.8 хувийг хөрөнгийн даатгалын хохирол үнэлгээний орлого бүрдүүлсэн.

Тайлант жилд даатгалын хохирол үнэлгээний орлогын бүтцийг авч үзвэл жолоочийн хариуцлагын албан журмын даатгал 60.0 хувь, авто тээврийн хэрэгслийн даатгал 20.8 хувь, хөрөнгийн даатгал 10.8 хувь, авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал 8.2 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 61. Даатгалын хохирол үнэлгээний орлого /бүтээгдэхүүнээр/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

**Даатгалын төлөөлөгчид:** Даатгалын төлөөлөгчид тайлант жилд 35.6 тэрбум төгрөгийн хураамжийн орлого төвлөрүүлсэн ба үүний 29.0 хувийг жолоочийн хариуцлагын албан журмын даатгал, 20.5 хувийг авто тээврийн хэрэгслийн даатгал,

20.3 хувийг хөрөнгийн даатгал, 11.1 хувийг гэнэтийн осол, эмчилгээний даатгал, 8.6 хувийг хариуцлагын даатгал, 2.5 хувийг агаарын хөлгийн даатгал, 8.0 хувийг бусад даатгалын бүтээгдэхүүнээс бүрдүүлсэн байна.

Зураг 62. Даатгалын төлөөлөгчийн хураамжийн орлого /бүтээгдэхүүнээр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

## ШИГТГЭЭ 6.

## KILMO SALAMA (АЮУЛГҮЙ ХӨДӨӨ АЖ АХУЙ) – ИНДЕКСЭД СУУРИЛСАН ХӨДӨӨ АЖ АХУЙН ДААТГАЛ

2008 онд Тогтвортой Хөдөө Аж Ахуйн Syngenta Сан (SFSA), Сафариком (Кени дэх хамгийн том үүрэн телефоны компани), UAP (Кени Улсын томоохон даатгалын компани), болон бусад байгууллагууд хамтран дэлхийн хамгийн анхны хөдөө аж ахуйд зориулсан бичил даатгалыг гар утасны сүлжээ ашиглан Кени улсад нэвтрүүлсэн.

Кени Улсын нийт хүн амын гуравны нэгийг ХАА–н ажилчид эзэлдэг ба нийт тариалангийн талбайн бараг тэн хагас нь амьжиргааны зориулалттай буюу фермерүүдийн амьжиргаа нь тэдний ургацаас бүрэн хамааралтай байдаг. Тиймээс ХАА–н ажилчдыг урьдчилан таамаглах боломжгүй цаг агаарын эрсдэл (ган гачиг, хэт их бороо, байгалийн гамшиг зэрэг)–ээс үүдэх санхүүгийн томоохон алдагдалаас хамгаалах гол хэрэгсэл нь уг даатгалын бүтээгдэхүүн юм.

Kilmo Salama даатгалын бүтээгдэхүүн нь индексэд суурилсан. Тариалалтын туршид нарны эрчим хүчээр ажилладаг цаг уурын станцууд хур тунадас болон бусад цаг уурын мэдээлэл (салхины хурд, температур)–ийг хэмжиж, өгөгдлийг төврүү 15 минут тутамд явуулдаг. Харин тариаланчид аль станц нь тариалангийн уур амьсгалыг хамгийн сайн төлөөлж болохыг сонгох эрхтэй байдаг. Хэрвээ хур тунадас хэтэрхий бага эсвэл хэтэрхий ихээр тогтоогдвол хур тунадасны индексийн хазайлт дээр үндэслэн нөхөн төлбөрийг тооцдог байна.


Эх сурвалж: World Farmers' Organisation

### 4.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

Бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл: Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд зааснаар Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй ББСБ–ууд зээл, төлбөрийн баталгаа гаргах, төлбөр тооцооны хэрэгсэл гаргах, цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, гадаад валютын арилжаа, итгэлцлийн үйлчилгээ, богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө оруулалт санхүүгийн

чиглэлээр мэдээлэл зөвлөгөө өгөх, факторингийн үйлчилгээ, үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үндсэн үйл ажиллагаа гэсэн үндсэн 10 үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгээр эрхэлж байна. Эдгээр үйл ажиллагаанаас зээлийн үйл ажиллагааг нийт 482 ББСБ, гадаад валютын арилжааг 145 ББСБ эрхэлж байгаа ба одоогоор санхүүгийн түрээсийн үйлчилгээ үзүүлдэг ББСБ зах зээл дээр байхгүй байна.

Зураг 63. ББСБ–уудын тоо /үйлчилгээний төрлөөр/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Бүтээгдэхүүн, үйлчилгээний орлого: Тайлант улиралд ББСБ-уудын нийт орлого 195.9 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд нийт орлогын 96.6 хувийг үндсэн үйл ажиллагааны орлого, 3.4 хувийг үндсэн бус үйл ажиллагааны орлого бүрдүүлсэн.

Үндсэн үйл ажиллагааны орлогын 82.7 хувь буюу 161.9 тэрбум төгрөгийг хүүгийн орлого, үлдсэн 13.9 хувь буюу 27.3 тэрбум төгрөгийг хүүгийн бус орлого бүрдүүлсэн.

Зураг 64. Үйл ажиллагааны орлого /төрлөөр/

- Үндсэн бус үйл ажиллагааны орлого
- Хүүгийн орлого
- Хүүгийн бус орлого




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хүүгийн бус орлогын 44.1 хувийг ханш болон үнэлгээний тэгшитгэлийн орлого, 13.0 хувийг гадаад валютын арилжааны орлого, 3.3 хувийг мөнгөн гуйвуулгын орлого, 0.6 хувийг санхүүгийн

зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого, 24.2 хувийг үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого, 14.4 хувийг бусад орлого бүрдүүлж байна.

Зураг 65. Хүүгийн бус орлого

- Гадаад валютын арилжааны орлого
- Ханш болон үнэлгээний тэгшитгэлийн орлого
- Мөнгөн гуйвуулгын орлого
- Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого
- Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого
- Бусад



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Дижитал санхүүгийн үйлчилгээ: Дижитал санхүүгийн үйлчилгээ нь гар утсан дээр суурилсан цахим мөнгөний загвар, дижитал төлбөрийн платформ зэрэг шинэлэг технологиор санхүүгийн үндсэн үйлчилгээг хүргэх боломжийг олгодог. Дижитал сувгууд нь хэрэглэгч болон үйлчилгээ үзүүлэгчдийн зардлыг бууруулж, алслагдсан буюу санхүүгийн үйлчилгээг тэр бүр авч чадахгүй байгаа хүн амд санхүүгийн үйлчилгээг түргэн шуурхай, бага зардлаар авах хаалгыг нээж өгдөг.

Технологид суурилсан дижитал санхүүгийн үйлчилгээ нь сүүлийн жилүүдэд дэлхийн санхүүгийн салбарыг хурдтайгаар өөрчилж байгаа бөгөөд энэхүү хөгжлийг даган ББСБ-ууд ч дижитал санхүүгийн үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэж эхлээд байна. 2017 оны 4 дүгээр улирлын байдлаар 2 ББСБ дижитал санхүүгийн үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэж байгаа ба ББСБ-ын нийт харилцагчдын 81.4% нь дижитал санхүүгийн үйлчилгээг хүртэж байгаа юм.

## ШИГТГЭЭ 7: ФИНТЕК &amp; РЭГТЕК

**Финтек:** Финтек нь технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээний салбар юм. Сүүлийн жилүүдэд эрчимтэй өсөж буй уг салбарт үйл ажиллагаа явуулж буй гарааны бизнесүүдийн тоо өдрөөс өдөрт нэмэгдэж, хөрөнгө оруулалтыг их хэмжээгээр татаж байна. Мөн уламжлалт санхүүгийн үйлчилгээг хүртэж чаддаггүй хэрэглэгчдийн хэрэгцээг хангах давуу талыг финтек олгодог. Одоогоор ухаалаг утсанд суурилсан санхүүгийн үйлчилгээ хамгийн түгээмэл ашиглагдаж байгаа ба ердөө аравхан жилийн дотор дэлхий даяар 2 тэрбум хүн банкны үйлчилгээг ухаалаг утсан дээрээс авдаг болсон. Манай орны хувьд ч ялгаагүй энэ төрлийн үйлчилгээ илүү өргөн ашиглагдаж байна.

Индонезийн бэлгэ тэмдэг болсон “Хувийн зээлийн финтек аппликейшн”:

Хэрэв таны цалин буугаагүй байхад яаралтай мөнгө хэрэгтэй болвол эсвэл эмнэлгийн төлбөрийг яаралтай төлөх хэрэгтэй тохиолдолд уламжлалт зээлийн өргөдөл гарган зээлээ хүлээхэд хэтэрхий урт хугацаа зарцуулна шүү дээ. Тиймээс Индонезид энэ асуудалруу чиглэсэн онлайн зээлийн үйлчилгээ эрхлэх санхүүгийн байгууллагууд олширч байна. Энэ үйлчилгээ нь онлайнар шаардлагатай мэдээллээ нөхөж бөглөөд оруулахад ямар ч барьцаа хөрөнгөгүйгээр таны хүссэн зээлийг хурдан, шуурхай дансруу тань шилжүүлдгээрээ давуу талтай. Шаардлагатай мэдээлэлд хөдөлмөр эрхлэлтийн байдал, гар утасны дугаар, олон нийтийн сүлжээний хувийн хаяг гэх мэт багтах бөгөөд эдгээр мэдээллээс зээлдэгчийн зээлээ хугацаандаа буцаан төлж чадах эсэхийг үнэлдэг байна.

Индонезид онлайн зээлийн үйлчилгээний эрэлт улам нэмэгдэж, зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээний аппликейшнууд хайлт болон хэрэглээгээрээ тэргүүлж байна. 2016 оны байдлаар Индонези Улсын хамгийн шилдэг 15 санхүүгийн аппликейшны 7 нь хувийн зээлийн аппликейшн байсан.

**Рэгтек:** Рэгтек бол санхүүгийн салбарын зохицуулалтыг шийдвэрлэхэд чиглэсэн технологийн нэг хэлбэр. Рэгтек гэсэн үг нь “зохицуулалт” болон “технологи” гэсэн нэр томъёоны нийлэмж бөгөөд мэдээллийн технологийг тайлагнал болон дүрэм журмыг дагаж мөрдөхөд хэрхэн ашиглаж болохыг тодорхойлдог. Нөгөөтэйгүүр Рэгтек нь компаниуд өөрсдийн эрсдэлийг илүү сайн ойлгож, удирдахад нь тусалдаг.

Финтек нь банк, санхүүгийн байгууллагуудад бүтээгдэхүүн үйлчилгээгээ хялбаршуулах, дижиталчлах боломжийг олгодог бол Рэгтек нь хууль, эрх зүйн салбарт хялбар, хурдан зохицож ажиллах боломжийг олгодог.

“Let’s Talk Payments”-ийн мэдээллэснээр АНУ-ын банкууд жилд 80 тэрбум долларыг хууль тогтоомжийг дагаж мөрдөх үйл ажиллагаанд болон эрсдэлийг удирдахад зарцуулдаг байна. Тэдний тооцоолсноор энэ тоо 2020 он гэхэд 119 тэрбум ам.доллар болно. Үүнээс гадна компаниуд жил бүр 160 тэрбум ам.долларыг дотоодын болон гадны шаардлагууд, хэм хэмжээ, дүрэм журмыг дагаж мөрдөөгүй, зөрчсөн тохиолдолд үүссэн торгуулийг барагдуулахад зарцуулдаг байна.

Рэгтекийн хүрээнд хэрэгжиж байгаа төслүүд нь компаниудад дээрх зардлаа бууруулах хямд, энгийн шийдлийг санал болгодог. Одоогоор энэ зах зээлд 6000 гаруй компани оролцож байгаа ба уг салбарт хийгдсэн хөрөнгө оруулалтын хэмжээ 2014 онд 82.2 сая ам.доллар байсан бол 2016 онд 334.8 сая доллар болж 4 дахин нэмэгджээ. Сүүлийн 5 жилийн хугацаанд Лондонгийн Рэгтек компаниудад 39 удаагийн хөрөнгө оруулалтын хэлэлцээр хийгдсэн бөгөөд энэ чиглэлдээ тэргүүлэх хотуудын нэг болоод байна. Хийгдсэн хөрөнгө оруулалтын хэлэлцээрийн дийлэнх хувь нь мөнгө угаалтын эсрэг чиглэсэн үйл ажиллагаатай компаниудад хийгдсэн байна.


*Эх сурвалж: Финтек Глобал*

## 4.4 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

ХЗХ-дын хүүгийн орлого өнгөрсөн онтой харьцуулахад 26.9 хувиар өсөж 30.2 тэрбум төгрөгт хүрч нийт хүүгийн орлогын 94 хувийг зээлийн хүүгийн орлого эзэлж байна. Хүүгийн орлогыг бүрдүүлэгч зээлийн нэмэгдүүлсэн хүүгийн орлого өнгөрсөн оноос 5.1 хувиар буурч 328.9 сая төгрөг, үнэт цаасны хүүгийн орлого 67 дахин нэмэгдэж 6.5 сая төгрөг болж өндөр өсөлт

үзүүлсэн бөгөөд тус орлогыг нэг хоршоо дангаар бүрдүүлсэн байна. Банк санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүүгийн орлого 14.9 хувиар өсөж 1.4 сая төгрөгт хүрсэн бол санхүүгийн түрээсийн орлого огт олоогүй байна. Хүүгийн цэвэр орлого өнгөрсөн оноос 24 хувиар өсөж тайлант онд 14 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Зураг 66. Хүүгийн орлогын бүтэц /хувиар/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ХЗХ-дын хүүгийн зардал өнгөрсөн онтой харьцуулахад 29.5 хувиар өсөж 16.2 тэрбум төгрөгт хүрч нийт хүүгийн зардлын 97.2 хувийг хадгаламжийн хүүгийн зардал эзэлж байна. Хүүгийн зардлын 2.3 хувийг эзэлж буй банк, санхүүгийн байгууллагад төлсөн хүүгийн зардал

2016 оноос 38.8 хувиар буурч 368.8 сая төгрөг бол санхүүгийн түрээсийн хүүгийн зардал 0.6 хувиар буурч 10.1 сая төгрөгт хүрчээ. Хүүгийн зардлын буцаалтын хувьд 15 дахин нэмэгдэж 29.4 сая төгрөгт хүрсэн байна.

Зураг 67. Хүүгийн зардлын бүтэц /хувиар/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо





# ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ



НИЙТ АРИЛЖААНЫ ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН

**860.8 ТЭРБУМ ТӨГРӨГ**

ҮҮНЭЭС:



**TOP 20** ИНДЕКС

2016 11605.7 нэгж

2017 22108.6 нэгж



ХААБ 2017.12.19-НИЙ ӨДӨР АНХНЫ  
**ҮҮСМЭЛ САНХҮҮГИЙН ХЭРЭГСЭЛ**  
АРИЛЖААЛЛАА.



ХУВИЙН БИРЖ АНХНЫ АРИЛЖААГАА ЭХЛҮҮЛСЭН.  
“АНД-ЭНЕРГИ” ХК  
**1.5 ТЭРБУМ ТӨГРӨГ**  
IPO 54 ХУВЬ ДАВЖ БИЕЛЛЭЭ.



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
“АЙ ТҮҮЛС” ХК  
**1.3 ТЭРБУМ ТӨГРӨГ**  
IPO 183 ХУВЬ ДАВЖ БИЕЛЛЭЭ.




2015 ОНООС ХОЙШ АНХ УДАА КОМПАНИЙН БОНД ГАРСАН.  
АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД **6 ТЭРБУМ** ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛД **4.2 ТЭРБУМ**



САЛБАРЫН НИЙТ ХӨРӨНГӨ


17.4% –ААР ӨСӨВ

САЛБАРЫН ХӨРӨНГӨ /тэрбум төгрөг/



■ Ердийн даатгал    ■ Урт хугацааны даатгал  
■ ХАА-н давхар даатгал


НИЙТ ХУРААМЖИЙН ОРЛОГО /тэрбум төгрөг/



Даатгалын салбарын нийт хураамжийн орлого

26.1% –аар өслөө

ДААТГАЛЫН НӨӨЦ САН /тэрбум төгрөг/




НИЙТ НӨХӨН ТӨЛБӨР

46.6

ТЭРБУМ ТӨГРӨГ



ХОХИРОЛ НӨХӨЛТИЙН ХАРЬЦАА




- Ердийн даатгалын компани 15
- Урт хугацааны даатгалын компани 1
- ХАА-н давхар даатгалын компани 1
- Даатгалын зуучлагч компани 42
- Даатгалын хохирол үнэлэгч компани 29
- Даатгалын төлөөлөгч 2893








# БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

## НИЙТ ХӨРӨНГӨ /тэрбум төгрөг/



## ББСБ-УУДЫН ХАРИЛЦАГЧИД







# ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО


2016

2017

113.1  
ТЭРБУМ ТӨГРӨГ

ХӨРӨНГИЙН ӨСӨЛТ  
**35.4%**

153.1  
ТЭРБУМ ТӨГРӨГ




5.5% 2016

ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН НИЙТ ЗЭЭЛД  
ЭЗЛЭХ ХУВЬ

4.7% 2017

НИЙТ ХАДГАЛАМЖ /тэрбум төгрөг/



АШГИЙН ӨСӨЛТ

19.3%  
2016


44.0%  
2017

Ашигт ажиллагаа нийт 5.5 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн онтой харьцуулахад 44.0 хувиар өссөн нь 2012 оноос хойшхи хамгийн өндөр үзүүлэлт юм.

УЛААНБААТАР ХОТОД **192** ХЗХ  
ХӨДӨӨ ОРОН НУТАГТ **98** ХЗХ



Хадгаламж, зээлийн хоршоодын тоо



57.5%



55,624  
НИЙТ ГИШҮҮД

42.5%







АШИГТ  
АЖИЛЛАГАА


# АШИГТ АЖИЛЛАГАА

## 5.1 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Тайлант хугацаанд хөрөнгийн зах зээлд зуучлалын үүрэг гүйцэтгэх 52 ҮЦК тусгай зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаа эрхэлж байна. 2017 оны жилийн эцсийн байдлаар ҮЦК-уудын цэвэр ашиг 1.06 тэрбум төгрөгт хүрсэн нь 2016 оны жилийн эцсийн байдлаас 4.2 хувиар, 2015

оныхоос 143.6 хувиар тус тус өссөн үзүүлэлт юм. Тайлант хугацаанд ҮЦК-уудын нийт актив 91.8 тэрбум байсан бөгөөд хөрөнгийн бүтцийн 79.2 хувийг эргэлтийн хөрөнгө, 20.8 хувийг эргэлтийн бус хөрөнгө бүрдүүлсэн байна.

Зураг 68. Тайлангийн үзүүлэлт /тэрбум төгрөг/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2017 оны жилийн эцсийн байдлаар ҮЦК-уудын орлого 9.4 тэрбум төгрөг байсан нь өмнөх оны мөн үеийн байдлаас 13.1 хувиар өссөн үзүүлэлт юм. Орлогын бүтцийг тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаанаас олсон орлогоор авч үзвэл

брокерийн үйл ажиллагаа 32.4 хувь, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа 19.3 хувь, андеррайтерийн үйл ажиллагаа 6.0 хувь, дилерийн үйл ажиллагаа 0.2 хувийг тус тус эзэлсэн байна.

Зураг 69. Орлогын бүтэц

- Брокерын үйл ажиллагааны орлого
- Дилерийн үйл ажиллагааны орлого
- Андеррайтерийн үйл ажиллагааны орлого
- Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагааны орлого
- Үнэт цаасны арилжааны цэвэр орлого
- Бусад орлого




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Тайлант онд ҮЦК-уудын нийт зардал 8.0 тэрбум төгрөг байсан нь өмнөх оны мөн үеэс 0.8 тэрбум төгрөгөөр буюу 12.4 хувиар өссөн үзүүлэлт юм. Уг өсөлтөд албан татвар, төлбөр, хураамжийн зардал 58.3 хувиар, санхүүгийн зардал 29.0 хувиар, түрээсийн зардал 10.7 хувиар тус тус өссөн нь

голлох нөлөөг үзүүлсэн байна. Мөн нийт зардлын бүтцийг авч үзвэл үндсэн үйл ажиллагааны зардлууд болох ажилчдын цалингийн зардал 32.2 хувь, албан татвар, төлбөр, хураамжийн татвар 16.7 хувь, санхүүгийн зардал 9.4 хувь, түрээсийн зардал 5.0 хувийг эзэлж байна.

Зураг 70. Зардлын бүтэц




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Тайлант онд ҮЦК-уудын нийт хөрөнгийн өгөөж /ROA/ 1.15 хувьтай байсан бөгөөд өнгөрөгч оноос 0.04 пунктээр өссөн байна. Харин өөрийн

хөрөнгийн өгөөж /ROE/ 2.05 хувьтай байсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.04 пунктээр өссөн үзүүлэлт юм.

Зураг 71. ҮЦК-уудын нийт хөрөнгийн болон өөрийн хөрөнгийн өгөөж



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Тайлант хугацаанд салбарын нэгтгэлд хамрагдсан нийт 52 ҮЦК-уудаас 29 үнэт цаасны компани алдагдалтай, 21 үнэт цаасны компани ашигтай ажилласан байна. Алдагдалтай ажилласан үнэт цаасны компаниудаас арилжаанд оролцоогүй

компаниуд шимтгэлийн орлого олоогүй тул түрээсийн болон ашиглалтын зардал зэрэг тогтмол шинжтэй үйл ажиллагааны зардлуудаас хамааран алдагдал хүлээсэн байна.

## Хүснэгт 10. Нийт орлого /тэрбум төгрөг/

№	Орлогын хураангуй тайлан	2016 он	2017 он	Өөрчлөлт
1	Үйл ажиллагааны орлого	5.5	6.6	20.0%
2	Ногдол ашгийн орлого	0.5	0.9	80.0%
3	Борлуулалт маркетингийн болон ерөнхий ба удирдлагын зардал	6.1	6.3	3.3%
4	Ажилчдын цалингийн зардал	2.8	2.6	(7.1%)
5	Албан татвар, төлбөр, хураамжийн зардал	0.9	1.3	44.4%
6	Санхүүгийн зардал	0.6	0.8	33.3%
7	Бусад зардал	0.08	0.1	25.0%
8	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.6	(0.02)	(103.0%)
9	Бусад ашиг (алдагдал)	(0.4)	(0.8)	100.0%
10	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	1.1	1.3	18.2%
11	Орлогын татварын зардал	0.1	0.3	200.0%
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	1.0	1.1	10.0%


Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Тайлант үед ҮЦК-уудын орлого 1.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байгаа нь үйл ажиллагааны орлого 20.0%-аар нэмэгдэж, ногдол ашгийн орлого 80.0 хувиар нэмэгдсэнтэй холбоотой юм. Мөн нийт зардал 0.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Уг өсөлтөд борлуулалт маркетингийн болон албан татвар, төлбөр, хураамжийн зардлууд өмнөх оны мөн үетэй харьцуулахад тус тус 3.3%, 44.4%-аар өссөн нь нөлөө үзүүлсэн байна.

### 5.1.1 ХАА-н гаралтай бараа, түүхий эдийн зах зээл

Тайлант улиралд хөдөө аж ахуйн бараа, түүхий эдийн зах зээлд зуучлалын үүрэг гүйцэтгэх нийт 16 брокерын компани Хорооноос тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд эдгээр компанийн нийт хөрөнгийн дүн 1.7 тэрбум төгрөгтэй тэнцэж байгаа бөгөөд энэ нь өмнөх оны мөн үеэс 0.5 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлт юм.

Зураг 72. Тайлангийн үзүүлэлтүүд /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагчдын нийт орлого 1.1 тэрбум төгрөг байсан бөгөөд 99.0 хувийг борлуулалтын орлого бүрдүүлсэн байна. Харин нийт зардал 0.4 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны түвшнээс 0.2 тэрбум буюу 33 хувиар буурсан үзүүлэлт юм. Нийт зардлыг бүтцээр нь харвал 56.4 хувийг ерөнхий ба удирдлагын зардал, 43.4 хувийг борлуулалт, маркетингийн зардал, 0.2 хувийг бусад зардлууд эзэлсэн байна.

Тайлант онд нийт хөрөнгийн өгөөж, өөрийн хөрөнгийн өгөөж болон ахиуц цэвэр ашгийн харьцаанууд тус тус -0.03%, -0.05%, -0.05% буюу сөрөг дүнтэй гарч өмнөх түвшнээс буурсан байна. Ашгийн хэмжээ 0.01 тэрбум төгрөгөөр буурч хасах дүнтэй гарсан нь уг бууралтад голлох нөлөө үзүүлсэн байна.

## 5.2 ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

**Цэвэр ашиг:** Тайлант жилд даатгалын компаниудын цэвэр ашиг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.8 тэрбум төгрөг буюу 15.7 хувиар өсөж, 13.2 тэрбум төгрөгт хүрэв. Ердийн даатгалын компаниудын татварын дараах цэвэр ашиг өмнөх оны мөн үеэс 2.9 хувиар өсөж 8.7 тэрбум төгрөг, давхар даатгалын компанийн татварын дараах цэвэр ашиг 55.6 хувиар өсөж 4.3 тэрбум төгрөгт хүрсэн бол урт хугацааны даатгалын компанийн татварын дараах цэвэр ашиг 1.4 хувиар буурч 0.2 тэрбум төгрөгт хүрчээ.

Зураг 73. Цэвэр ашиг



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

**Голлох харьцаанууд:** Хохирол нөхөлтийн харьцаа тайлант жилд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 7.1 пунктээр өссөн үзүүлэлттэй гарав. Энэ нь нийт нөхөн төлбөрийн зардал 31.9 хувиар, орлогод тооцсон хураамж 14.8 хувиар өссөнтэй, өөрөөр хэлбэл орлогод тооцсон хураамжийн өсөлт нөхөн төлбөрийн зардлын өсөлтөөс бага байсантай холбоотой юм.

Сүүлийн жилүүдэд даатгагчид үйл ажиллагааны зардлыг хамгийн оновчтой түвшинд хүргэхийг зорих болсон нь зардлын харьцааг сайжрахад түлхэц өгч байна. Даатгалын компаниудын зардлын харьцааг авч үзвэл 2015 онд 67.5 байгаа


бол хувьтай 2016, 2017 онуудад тогтмол 52.8 хувьтай байна.

Салбарын хэмжээнд зардлын хосолсон харьцааг авч үзвэл нөхөн төлбөр болон үйл ажиллагааны зардал нийт орлогод тооцсон хураамжийн орлогын 107.5 хувьтай тэнцэж байна. Зардлын хосолсон харьцаа 2016 онд 100.4 хувьтай байсан бол энэ онд 7.5 пунктээр өссөн байна.

Даатгалын салбарын цэвэр ахиуц ашгийн харьцаа тайлант хугацаанд буурсан үзүүлэлттэй байлаа. 2016 оны жилийн эцэст салбарын цэвэр ахиуц ашиг 10.0 хувьтай байсан бол тайлант жилд 9.1 хувь болж буурсан байна.

САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТОЙМ 2017

Зураг 74. Голлох харьцаанууд




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Ашигт ажиллагааны коэффициент: Салбарын өөрийн хөрөнгийн өгөөж 2010 оны жилийн эцэст хамгийн өндөр буюу 22.7 хувь байсан бол 2014 онд хамгийн бага буюу 3.3 хувьд хүрсэн байна. 2014 оноос хойш өөрийн хөрөнгийн өгөөжийн харьцаа өсөх хандлагатай байсан ч тайлант жилд өмнөх оны мөн үеэс 3.0 пунктээр буурч 7.8 хувьтай байна.

Нийт хөрөнгийн өгөөж болон өөрийн хөрөнгийн өгөөжийн графикайн чиглэлд ижил төлөв ажиглагдаж байна. 2014 онд нийт хөрөнгийн өгөөж хамгийн доод цэгтээ буюу 1.6 хувьд хүрсэн боловч сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай байгаа юм. Тайлант жилд нийт хөрөнгийн өгөөж өмнөх оны мөн үеэс 1.9 пунктээр буурч 3.6 хувьд хүрчээ.

Зураг 75. Нийт хөрөнгийн болон өөрийн хөрөнгийн өгөөж



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо




### 5.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

ББСБ-уудын ашиг, түүний өсөлт: 2017 оны байдлаар ББСБ-уудын нийт орлого өмнөх оноос 1.3 хувиар өсөж 195.9 тэрбум төгрөгт, нийт ашиг 13.0 хувиар өсөж 66.8 тэрбум төгрөгт хүрлээ.

Тайлант онд салбарын хэмжээнд нийт 534

ББСБ үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаагаас 444 ББСБ нийт 77.8 тэрбум төгрөгийн ашигтай, 71 ББСБ нийт 11 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан бол 19 ББСБ тайлант хугацаанд үйл ажиллагаа явуулаагүй байна.

Зураг 76. ББСБ-уудын орлого, зарлага, ашгийн динамик /тэрбум төгрөг/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Нийт болон өөрийн хөрөнгийн өгөөж: ББСБ-ын салбарын хэмжээнд нийт хөрөнгийн өгөөж 7.6 хувь, өөрийн хөрөнгийн өгөөж 10.0 хувьд хүрч

өмнөх оны мөн үеэс 0.8 пункт, 1.8 пунктээр тус тус буурлаа. Өгөөжийн бууралтад хөрөнгийн өсөлт голлон нөлөөлсөн.

Зураг 77. Нийт хөрөнгийн болон өөрийн хөрөнгийн өгөөж




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


Тайлант улиралд ашигтай ажилласан ББСБ-уудын нийт хөрөнгийн болон өөрийн хөрөнгийн өгөөжийг тооцоход 30.3 хувь нь 1 хувиас доош, 21.3 хувь нь 1-5 хувь, 16.5 хувь нь 5-10 хувь, 31.8 хувь нь 10 хувиас дээш

ажилласан бол 29.6 хувь нь 1 хувиас доош, 20.4 хувь нь 1-5 хувь, 15.5 хувь нь 5-10 хувь, 34.5 хувь нь 10 хувиас дээш өөрийн хөрөнгийн өгөөжтэй ажилласан байна.

Зураг 78. ББСБ-уудын тоо, өөрийн хөрөнгийн өгөөжийн ангиллаар



Зураг 79. ББСБ-уудын тоо, нийт хөрөнгийн өгөөжийн ангиллаар




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ББСБ-уудын нийт болон өөрийн хөрөнгийн өгөөжийг хувь нийлүүлсэн хөрөнгийн ангиллаар харахад 800 саяас доош ХНХ-тэй ББСБ-уудын тал хувь нь 3.6 хувиас бага нийт хөрөнгийн өгөөж, 3.9 хувиас бага өөрийн хөрөнгийн өгөөж, 800 саяас 1 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй ББСБ-уудын тал хувь нь 4.4 хувиас бага нийт хөрөнгийн

өгөөж, 4.7 хувиас бага өөрийн хөрөнгийн өгөөж, 1-2.5 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй ББСБ-уудын тал хувь нь 6.4 хувиас бага нийт хөрөнгийн өгөөж, 7.8 хувиас бага өөрийн хөрөнгийн өгөөж, 2.5 тэрбумаас дээш хөрөнгөтэй ББСБ-уудын тал хувь нь 8.1 хувиас бага нийт болон, өөрийн хөрөнгийн өгөөжтэй байна.

Зураг 80. ББСБ-уудын хөрөнгийн өгөөж /хувь нийлүүлсэн хөрөнгөөр/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зээлийн үйлчилгээний орлого: ББСБ-уудын зээлийн үйлчилгээний орлогын хэмжээ буурах хандлагатай байна. Тайлант онд ББСБ-уудын зээлийн үйлчилгээний орлогын хэмжээ 30.2 хувь байна. Энэ нь өнгөрсөн оноос 2 пунктээр буурсан

үзүүлэлт юм. Өөрөөр хэлбэл ББСБ-ууд 100 төгрөгийн зээлийн үйлчилгээнээс ойролцоогоор 30 төгрөгийг олж байна гэсэн үг юм. Зээлийн үйлчилгээнээс олох орлогын хэмжээ буурсанд зээлийн хүүгийн бууралт голчлон нөлөө үзүүлсэн.

Зураг 81. Зээлийн үйлчилгээнээс олох орлого /тэрбум төгрөг/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зардал, орлогын харьцаа: ББСБ-үүд нэг төгрөгийн орлого олохын тулд дунджаар хэдэн төгрөгийн зардал гаргаж буйг тооцдог харьцаа болох зардал, орлогын харьцаа тайлант онд 47.7 хувь гарсан буюу өмнөх оны мөн үеэс 6.2 пунктээр буурчээ. Өөрөөр хэлбэл ББСБ-үүд 100 төгрөгийн

орлого олохын тулд дунджаар 48 төгрөгийн зардал гаргаж байна гэсэн үг юм. Тайлант онд ББСБ-үүдын зээлийн хүү буурсан мөн зардал орлогын харьцааны бууралт нь ББСБ-үүдын үр ашигт байдал нэмэгдэж буйг харуулж байна.

Зураг 82. Зардал, орлогын харьцаа




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

## 5.4 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

Орлого, зарлага: Сүүлийн 10 жилийн хугацаанд салбарын нийт орлого, зарлага аажим өссөөр 2017 онд нийт ХЗХ–д 31.8 тэрбум төгрөгийн орлого, 26.3 тэрбум төгрөгийн зарлага, 5.5

тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна. Үйл ажиллагааны зардал нийт орлогын 25.1 хувийг эзлэх бөгөөд үүнээс хүний нөөцийн зардал хамгийн их буюу 16.4 хувийг эзэлсэн байна.

Зураг 83. ХЗХ–дын орлого ба зарлага /тэрбум төгрөг/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Цэвэр ашиг: 2017 онд салбарын ашигт ажиллагаа нийт 5.5 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн онтой харьцуулахад 44.0 хувиар өссөн нь сүүлийн 10 жилийн байдлаар харвал 2012 оноос хойшхи хамгийн өндөр үзүүлэлт юм. Цэвэр ашгийн өсөлтөд ХЗХ–дын нийт орлогын өсөлт голчлон

нөлөөлсөн бөгөөд нийт орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 28.8 хувиар өсөж сүүлийн 10 жилийн хугацаан дахь хамгийн өндөр хувьд хүрчээ. Зардлын хувьд мөн адил хамгийн өндөр өсөлт буюу өмнөх оноос 26.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 84. Ашигт ажиллагааны өсөлт




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Голлох харьцаанууд: ХЗХ–дын өөрийн хөрөнгийн өгөөж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.7 пунктээр өсөж 39.1 хувьд хүрлээ. Нийт хөрөнгийн өгөөж 2015 оноос аажим өсөж тайлант онд 3.7 хувьтай байна. Гишүүдэд олгож буй зээлийн хүүгийн орлого өмнөх оны мөн үеэс 26.9 хувь

буюу 6.4 тэрбум төгрөгөөр өсөж тайлант онд 30.2 тэрбум төгрөгт хүрсэн ба хүүгийн орлогыг нийт зээлд харьцуулахад 28.7 хувь байна. Харин цэвэр ахиуц ашгийн харьцаа тайлант онд 1.7 пунктээр өсөж 17.3 хувьд хүрчээ.

Зураг 85. Нийт хөрөнгийн болон өөрийн хөрөнгийн өгөөж



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо





# ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

# ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

## 6.1 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Хөрөнгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангахад зах зээлд оролцогчдын чанар болон дэд бүтцийн байгууллагуудын чадавхи, бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрөл, олон улсын стандартад хэр нийцэн ажиллаж байгаа эсэх зэрэг маш олон хүчин зүйлс нөлөөлдөг. Хөрөнгийн зах зээл хэр тогтвортой өсөн дэвжиж байгаагаас ирээдүйн зах зээлийн хөгжил шалтгаална.

Олон улсад хөрөнгийн зах зээлийн индексийн тооцоо, судалгааны чиглэлээр тэргүүлэгч Их Британийн FTSE Russell групп нь дэлхийн улс орнуудыг хөрөнгийн зах зээлийн хөгжлөөр хөгжсөн (developed), эрчимтэй хөгжиж буй (emerging), хоёрдогч эрчимтэй хөгжиж буй (secondary emerging) болон хөгжиж буй (frontier market) гэсэн 4 ангилалд хуваан авч үздэг.

2017 оны 9 дүгээр сарын байдлаар FTSE-ийн хөгжиж буй зах зээлийн ангилалд 29 улс орон багтаад байгаа бөгөөд Монгол Улсын хувьд 2012 онд төлбөр тооцооны T+3 горимд шилжих болсноор уг ангиллын ажиглалтын жагсаалтад ороод байжээ. Гэсэн хэдий ч 2015 онд Prefunding буюу арилжаанд оролцохын тулд мөнгөн хөрөнгийг 100% урьдчилан байршуулдаг системд эргэн орж мөн дэд бүтцийн хүрээнд үнэлэгдэхүйц шинэчлэлт хийхгүй байсаар 2017 оны 9 дүгээр сард уг ажиглалтын жагсаалтаас хасагдсан.


**Хувьцааны үнийн хэлбэлзэл:** Дэлхийн улс орнуудын санхүүгийн зах зээлийн хөгжлийг харьцуулахын тулд 2012 онд Дэлхийн банкнаас 4x4 матрицын аргыг ашиглан судалгаа хийсэн байдаг. Уг аргачлалд санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хэмжихдээ:

- Хувьцааны үнийн индексийн хэлбэлзэл
- Хувьцааны индексийн тархалтын Skewness
- Хувьцааны индексийн бусад улс орнуудын индекстэй хамааралтай байдлаар тус тус авч үзсэн байдаг.

Үүнээс хувьцааны индексийн бусад улс орнуудын индекстэй хамааралтай байдлыг тооцлоо. Монголын хөрөнгийн зах зээлийн ТОП-20 индексийн Nikkei 225 болон FTSE 100 индекстэй корреляци хамаарал 2014 оноос өмнө эерэг 70 хувийн хамааралтай байсан бол 2016 онд сөрөг 82 хувийн хамааралтай болж өөрчлөгдсөн бол Nikkei 225 болон FTSE 100 индексийн корреляци хамаарал эерэг 70 хувийн түвшиндээ байна.

2017 оны 4 дүгээр улирлын байдлаар ТОП-20 индексийн Nikkei 225 болон FTSE 100 индекстэй корреляци хамаарал тус тус сөрөг 7 болон эерэг 18 хувьтай байгаа бол Nikkei 225 болон FTSE 100 индексийн корреляци эерэг 68 хувийн түвшинд байна.

Зураг 86. Индексүүдийн 5 жилийн гулсах корреляци хамаарал




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо



Хөрөнгийн зах зээл өндөр хөгжсөн орнуудад зах зээлийн индекс өсөх нь хувьцааны ерөнхий үнэ өсөж зах зээл идэвхтэй байгааг харуулдаг. 2012 оноос 2016 он хүртэл хөрөнгийн зах зээлийг тэргүүлэгч орнуудын зах зээлийн идэвхжил нэмэгдэхэд манай орны хувьцааны зах зээл унах хандлагатай байсан нь сөрөг корреляци хамаарлыг харуулж байна. Сүүлийн 3 жил

гадаадын хөрөнгө оруулагчид эрчимтэй хөгжиж буй (emerging market) зах зээлтэй орнуудаас гарах болсон шалтгаан нь тэргүүлэгч орнуудын хөрөнгийн зах зээл идэвхжсэнтэй холбоотой байж болох юм. 2017 онд манай орны хөрөнгийн зах зээлийн идэвх хурдацтай нэмэгдсэн нь дээрх корреляци хамаарал эерэг болох хандлагыг харуулж байна.

Зураг 87. ТОП 20, Nikkei 225, FTSE 100 индексүүдийн сарын өгөөжийн 6 сарын гулсах дундаж




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хөрөнгийн зах зээлд оролцогчдын хувьд хөрөнгө оруулалтын өгөөжийн түвшин маш чухал байдаг. Дээрх зурагт ТОП-20, Nikkei 225, FTSE 100 индексүүдийн сарын өгөөжийн 6 сарын гулсах дунджийг харуулж байна. Тус зах зээлүүдийн эрсдлийг тооцож үзэхэд тус тус 6.35 хувь, 4.67

хувь, 2.44 хувь (сүүлийн 24 сарын дундаж өгөөжөөс хазайх стандарт хазайлт) хэлбэлзэлтэй байна. Сүүлийн 24 сарын хугацаанд ТОП-20 илүү хэлбэлзэлтэй байсан бол FTSE 100-ийн хэлбэлзэл харьцангуй бага байсан байна.

Зураг 88. Индексүүдийн 24 сарын дундаж хэлбэлзэл



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

## 6.2 ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

2008–2009 онд банкны салбар хямарч, ихээхэн алдагдалд орсноор санхүүгийн салбарыг хямралруу хөтөлсөн. Засгийн газрууд санхүүгийн

тогтвортой байдлыг хадгалж үлдэх зорилгоор хямралаас гаргах арга хэмжээнд гол анхаарлаа төвлөрүүлэх болов.

Хэдий хямрал банкны салбараас үүсэлтэй байсан боловч банкнаас бусад санхүүгийн байгууллагууд санхүүгийн хямралыг даамжруулахад чухал оролцоотой байсан юм. Санхүүгийн хямралаас хойш бодлого боловсруулагчид банкнаас бусад санхүүгийн байгууллагуудын системийн эрсдэлд үзүүлсэн нөлөөлөл, учир шалтгааныг тодруулахыг хичээх болсон. Тус хямралаас үүдэлтэй Европын холбооны орнуудад тулгарсан үндсэн дөрвөн эрсдэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

Нэгдүгээрт, банкнаас бусад санхүүгийн байгууллагууд нь бүтээгдэхүүнтэй холбоотой, ялангуяа хөрөнгөөр баталгаажсан үнэт цаастай холбогдох эрсдэлд голчлон өртдөг. 2008 оны санхүүгийн хямралаар бид үүнийг тодорхой харсан бөгөөд маш олон банкууд болон банкнаас бусад санхүүгийн байгууллагууд эрсдэлтэй хөрөнгө эзэмших болсон. Санхүүгийн хямралын өмнөхөн эдгээр үл хөдлөх хөрөнгө нь санхүүгийн тогтвортой байдалд нөлөөлөх бодит эрсдэл болон нүүрлэж байв. Манай улсын хувьд мөн энэхүү эрсдэл банкнаас бусад санхүүгийн байгууллагуудад нүүрлэх боломжтой тул зээл олгогч санхүүгийн байгууллагуудыг хөрөнгөжүүлж, чадавхжуулах, зах зээлд оролцогчдыг мэргэшүүлэх нэн шаардлагатай байгаа бөгөөд энэ нь улмаар ирээдүйд үүсч болох эрсдэлээс хамгаалах юм.

Хоёрдугаарт, зарим банкнаас бусад санхүүгийн байгууллагууд банкууд болон бусад банк бус санхүүгийн байгууллагуудтай хэт холбоо хамааралтай байдаг нь өөр нэгэн эрсдэл болж байна. Нэг санхүүгийн байгууллагын хямрал бусад санхүүгийн байгууллагуудад дамжин, оролцогч талуудын эрсдэл (counterparty risk)–ийг бий болгон, улмаар санхүүгийн систем бүхлээрээ хямрах нөхцөлийг бүрдүүлдэг.

Гуравдугаарт, зарим банкнаас бусад санхүүгийн байгууллагуудын хэт өргөжилт. Банк, ББСБ, Даатгал, ХЗХ, брокер, дилерийн үйл ажиллагааг цогцоор нь эрхэлж буй санхүүгийн группууд бий болох болсон. Улмаар санхүүгийн нэг салбарт үүссэн хямрал бусад салбартаа дамжих шууд нөхцөлийг бүрдүүлж байгаа юм. Түүнчлэн хямралд өртсөн томоохон байгууллага бусад санхүүгийн байгууллагуудтай холбогдон, эрсдэл

үүсгэх нөлөөтэй тул зах зээлд оролцогчдын тодорхой бус байдал бий болдог. Цаашлаад үл итгэлцэл үүсч, олон санхүүгийн байгууллагуудыг оролцогч талуудын эрсдэлд хүргэж, санхүүгийн системд бүхлээр нь нөлөөлдөг.

Дөрөвдүгээрт, банкнаас бусад санхүүгийн байгууллагууд бүхлээрээ хямралд өртсөнөөр бусад санхүүгийн байгууллагаас авсан өр зээл төлөгдөх боломжгүй болдог. Энэ нь дараах 2 сөрөг үр дагаварыг бий болгоно. Нэгд хөрөнгийн үнэлгээг бууруулах шууд нөлөөтэй. Хоёрт, мэргэжлийн оролцогчид ААА зэрэглэлийн биш хөрөнгөд хөрөнгө оруулалт хийхгүй бөгөөд зөвхөн өндөр зэрэглэлийн хөрөнгө эзэмшигч үйлчлүүлэгчидрүү хандсан үйлчилгээг санал болгодог. Улмаар доогуур зэрэглэлийн хөрөнгийн үнэлгээ буурна. Эргээд энэ нь тус хөрөнгийг эзэмшиж буй санхүүгийн байгууллагуудын балансад нөлөөлдөг.

#### Монгол Улсын даатгалын салбар

Даатгалын зах зээлийн санхүүгийн тогтвортой байдалд нийгэм эдийн засаг, улс төр, зохицуулалт, байгууллагын дотоод үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт болон үйл ажиллагааны онцлогоос хамаарсан эрсдэлүүд нөлөө үзүүлдэг. Санхүүгийн зохицуулах хорооноос 2017 оны хоёрдугаар улиралд хийсэн судалгаанаас үзэхэд даатгалын компаниудад тулгарч буй гол эрсдэлүүдэд нэгдүгээрт даатгалын эрсдэл, хоёрдугаарт зах зээлийн эрсдэлийг онцлон тодорхойлжээ.


Даатгалын эрсдэлийг амьдралын болон амьдралын бус гэж ангилан үзэж болно. Амьдралын даатгал нь даатгуулагчийн амь насаа алдах, хөдөлмөрийн чадвараа алдах болон эрүүл мэндтэй холбогдох урт хугацаанд үүсч болох эрсдэлийг даатгадаг бол амьдралын бус даатгал буюу ердийн даатгалын эрсдэлд тухайн даатгалын гэрээнд тусгагдсан даатгалын бүтээгдэхүүнтэй холбогдох бүхий л эрсдэлийг ойлгож болно. Даатгалын компаниудын хувьд даатгалын эрсдэлийг судлах болон үнэлэхэд бусад эрсдэлтэй харьцуулахад хамгийн өндөр буюу нийт хүн цагийн 42.1 хувийг зарцуулдаг гэсэн хариултыг өгсөн ба нийт даатгалын компаниудын 31.3 хувь нь эрсдэлийн үнэлгээний

загвартай гэжээ.

Харин зах зээлийн эрсдэлийн хувьд хүүгийн хэлбэлзэл, хөрөнгийн зах зээлийн үнэлгээ, үл хөдлөх хөрөнгийн үнийн индекс, валютын ханш гэх мэт макро хүчин зүйлс багтана. Монгол Улсын даатгалын зах зээлийн хамгийн том тулгамдаж буй асуудал нь валютын ханштай холбогдох эрсдэл юм. Даатгалын компаниудын дийлэнх нь давхар даатгалаа гадны даатгалын компанид даатгуулдаг бөгөөд сүүлийн 6 жилд жил бүр дунджаар 34 тэрбум төгрөгийг гадаад валют хэлбэрээр шилжүүлсэн нь даатгалын

нийт хураамжийн орлогын 33 хувийг эзэлж байна. Харин 2017 оны жилийн эцсийн байдлаар энэхүү дүн нь 46 тэрбум төгрөг болж өссөн нь нийт хураамжийн орлогын 32.3 хувийг эзэллээ. Даатгалын салбар өргөжихийн хэрээр тус салбар дахь гадаад валютын гадагшлах урсгал нэмэгдэж байгаа нь салбарын тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлэх магадлал бий болгож байна. Түүнчлэн сүүлийн жилүүдэд төгрөгийн ам.доллартай харьцах ханш суларч байгаа нь даатгалын компаниудад томоохон дарамт үүсгэх болсон.

Зураг 89. Давхар даатгалын хураамж ба ам.долларын ханш




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Даатгалын салбар нь нийгэм, эдийн засагт учрах хүлээгдээгүй эрсдэлийг бууруулж, санхүүгийн тогтвортой байдлыг хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг хэдий ч, тус салбарын өөрийн тогтворгүй байдал, системийн эрсдэлийн түвшин нь эргээд санхүүгийн тогтвортой байдалд томоохон нөлөө үзүүлдэг. Иймд манай орны хувьд үндэсний давхар даатгалын компанийг бий болгох шаардлага үүсч байгаа бөгөөд энэ нь цаашлаад гадаад валютын гадагшлах урсгалыг сааруулах, төгрөгийн тогтвортой байдлыг дэмжихэд чухал нөлөөтэй юм.

Түүнчлэн тайлант улиралд даатгалын компаниудын балансын хөрөнгийн 61.7 хувийг хөрөнгө оруулалтын дүн эзэлсэн ба үүний 91.8 хувийг хадгаламж, хадгаламжийн сертификат хэлбэрээр хийсэн хөрөнгө оруулалт бүрдүүлж

байгаа юм. Хадгаламж, хадгаламжийн сертификат болон үнэт цаасаарх хөрөнгө оруулалтаас даатгалын компаниуд 2016 онд нийт 17.4 тэрбум төгрөгийн хүүгийн орлого олсон нь даатгалын орлогын дүнгийн 37.7 хувийг эзэлжээ. Үүнийг задлан үзвэл ердийн даатгалын компаниудын хувьд хүүгийн орлого нь нийт даатгалын орлогын 30.2 хувь, урт хугацааны даатгалын компанийн 70 хувь, давхар даатгалын компанийн 98.3 хувийг бүрдүүлсэн байна. Эндээс дүгнэхэд ялангуяа урт хугацааны болон давхар даатгалын компанийн хувьд орлогын дийлэнх хувь нь хүүгийн түвшнээс, өөрөөр хэлбэл хөрөнгө оруулалтын хүүгийн орлогоос хамааралтай болох нь харагдаж байна. Гэвч манай улсын хувьд хүүгийн хэлбэлзэл харьцангуй тогтвортой байгаа тул энэ талын эрсдэл тулгамдах магадлал тун бага юм.

Зураг 89. Даатгалын нийт хөрөнгө оруулалт ба хадгаламжийн жигнэсэн дундаж хүү



## ШИГТГЭЭ 8.

## MEFIN 2017 ОНЫ ЖИЛИЙН ТАЙЛАНГААС

2017 онд манай улс Хамтын даатгалын салбарт мэдлэг, туршлагаа харилцан солилцож хамтран ажиллах MEFIN байгууллагын гишүүн орон болсноор энэ оны 9 дүгээр сард Улаанбаатар хотод MEFIN-ын 3 дугаар чуулга уулзалт мөн төрийн болон хувийн хэвшлийн 3 дугаар хэлэлцүүлэгийг СЗХ нь REPI Asia болон A2ii-тай хамтран амжилттай зохион байгууллаа. Энэ хэлэлцүүлгийн гол зорилтууд нь:

- MEFIN-ийн гишүүн орнууд болон Азийн бусад улс орнуудын жижиг, дунд үйлдвэрүүдийн хамтын даатгалын хөгжил дэвшилд мэдлэг, чадвараа харилцан солилцох;
- Жижиг, дунд үйлдвэрүүд болон хөдөө аж ахуй, уур амьсгалын өөрчлөлт, болон уул уурхайн салбартай холбоотой аж ахуй нэгжүүдэд зориулсан хамтын даатгалын бизнесийн загвар, бодлого зохицуулалтын талаар туршлага судлах;
- MEFIN-ийн гишүүн орнуудын жижиг дунд үйлдвэрүүдэд зориулсан даатгалд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн арга замуудыг хэлэлцэх боломжийг бий болгох байв.

Эх сурвалж: *The Mutual Exchange Forum on Inclusive Insurance*

## 6.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

AFI буюу “Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг”-ээс санхүүгийн хүртээмж болон санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлтүүдийг тодорхойлон цаашид гишүүн орнуудын дунд нийтлэг стандарт тогтоох, тоон мэдээллийн нэгдсэн сан үүсгэхээр ажиллаж байгаа бөгөөд санхүүгийн тогтвортой байдлыг тодорхойлох дараах 5 үзүүлэлтийг нэрлэжээ. Үүнд:


- Хөрөнгийн хүрэлцээтэй байдлын харьцаа
- Зээлийн эрсдэлийн сангийн харьцаа
- Чанаргүй зээлийн хувь
- Хөрвөх чадварын харьцаа
- Дистанс дистресс харьцаа

**Хөрөнгийн хүрэлцээт байдал:** Хөрөнгийн хүрэлцээт байдлын үзүүлэлтийг тооцохдоо өөрийн хөрөнгийг эрсдэлээр жигнэсэн нийт

активт харьцуулах замаар тооцдог бөгөөд 2017 оны байдлаар ББСБ-уудын хувьд уг харьцаа 156.2 хувьтай байна.

Хөрөнгийн хүрэлцээт байдлын харьцаа нь банк бус санхүүгийн байгууллагыг эрсдэлээс хамгаалах, үйл ажиллагааны тогтвортой байдлыг илэрхийлэх үзүүлэлт байдаг. Санхүүгийн зохицуулах хорооноос ББСБ-уудын өөрийн хөрөнгийг эрсдэлээр жигнэсэн нийт активт харьцуулсан харьцаа 30 хувиас доошгүй байна гэж заасан байдаг бөгөөд банк бус санхүүгийн салбарын хэмжээнд уг харьцааг ханган ажиллаж байгаа буюу өөрийн хөрөнгийн хэмжээ эрсдэлтэй хөрөнгийг бүрэн нөхөж чадахуйц байна. Тайлант онд уг харьцаа өссөн нь ББСБ-уудын өөрийн хөрөнгийн хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой.

Зураг 90. Хөрөнгийн хүрэлцээт байдлын харьцаа




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зээлийн эрсдэлийн сангийн харьцаа: ББСБ-ууд нь олгосон зээлийг хугацаа, чанар, эргэж төлөгдөх магадлалыг нь харгалзан ангилах замаар зээлийн эрсдэлийн санг тооцож байгуулдаг. Санхүүгийн зохицуулах хорооноос зээлийн эрсдэлийн санг байгуулах хувь хэмжээг зээлийн ангилал тус бүр дээр тогтоож өгсөн байдаг. Тухайн ББСБ байгуулвал зохих эрсдэлийн сангаа байгуулсан

эсэхээс нь хамааран ББСБ чанаргүй зээлээ нөхөх, эрсдэлээс хамгаалах чадвартай эсэхийг нь тодорхойлдог.

ББСБ-ын салбарын хувьд тайлант улиралд уг харьцаа 89.6 хувь гарсан буюу байгуулвал зохих эрсдэлийн санг бүрэн байгуулж чадаагүй буюу эрсдэлийг 90 хувиар нөхөх чадамжтайг харуулж байна.

Зураг 91. Зээлийн эрсдэлийн сангийн харьцаа




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Чанаргүй зээлийн хувь: Тайлант онд чанаргүй зээлийн хэмжээ 81.1 тэрбум төгрөгт хүрч чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 12.7 хувь болж

өслөө. Энэ нь өмнөх оны мөн үеэс 0.3 пунктээр өссөн үзүүлэлт юм.

Зураг 92. Чанаргүй зээлийн хувь




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

**Хөрвөх чадварын харьцаа:** Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийг, нийт хөрөнгөд харьцуулсан харьцаа буюу хөрвөх чадварын харьцаа тайлант улиралд 27.2 хувь байна. Өөрөөр хэлбэл ББСБ-уудын нийт хөрөнгийн 27.3 хувийг мөнгөн хөрөнгө бүрдүүлж байна. Хөрвөх чадварын харьцаа нь тухайн байгууллага богино хугацаат өр төлбөрөө төлөх чадвар хэр байгааг илэрхийлдэг.

Мөнгөн хөрөнгийн хэмжээ хэт их байх нь хөрөнгөө үр ашигтай зарцуулж, үндсэн үйл ажиллагаандаа ашиглаж чадахгүй байгааг харуулах бол, хэт бага байх нь тухайн байгууллага хөрвөх чадвар муутайг илэрхийлдэг. Тайлант улиралд мөнгөн хөрөнгийн нийт хөрөнгөд эзлэх хувь буурсан нь нийт хөрөнгийн өсөлтийн ихэнх хувийг зээлийн өсөлт бүрдүүлсэнтэй холбоотой.

Зураг 93. Хөрвөх чадварын харьцаа




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

**Дистанс дистресс харьцаа:** Уг харьцааг тооцохдоо эздийн өмчийн нийт хөрөнгөд эзлэх хувь дээр нийт хөрөнгийн өгөөжийг нэмж нийт хөрөнгийн өгөөжийн стандарт хазайлтад хуваан тооцдог. Энэ харьцаа нь тухайн байгууллагын ашигт ажиллагаанд гэнэтийн шок тохиолдоход түүнийг давах хангалттай нөөцтэй эсэхийг хэмждэг. Өөрөөр хэлбэл тухайн үеийн нийт хөрөнгөд эзлэх өөрийн хөрөнгө болон тухайн үеийн хөрөнгийн

өгөөж нь хөрөнгийн өгөөжийн хэлбэлзэлд харьцуулахад ямар байгааг тооцдог юм.

ББСБ-уудын хувьд уг харьцааг тооцохдоо хөрөнгийн өгөөжийн хэлбэлзлийг тухайн жилийн хөрөнгийн өгөөжийн стандарт хазайлтаар тооцсон. Тайлант онд дистанс дистресс харьцаа өссөнд өгөөжийн хэлбэлзлийн бууралт болон эздийн өмчийн нийт хөрөнгөд эзлэх хувь өссөн нь нөлөөлсөн.

Зураг 94. Дистанс дистресс харьцаа




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

## 6.4 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

Тайлант онд салбарын хувьд 3.1 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сан байгуулж нийт 102.1 тэрбум төгрөгийн цэвэр зээлтэй байна. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь өнгөрсөн оны мөн үеэс 1.3 пунктээр бууран 4.2 хувьд хүрч нийт чанаргүй зээлийн хэмжээ 4.5 тэрбум төгрөгт хүрлээ.

Салбарын нийт зээл өнгөрсөн онтой харьцуулахад 26.1 хувиар буюу 21.7 тэрбум төгрөгөөр өсөж 105.2 тэрбум төгрөгт хүрсэн нь сүүлийн 9 жилийн хугацаанд хамгийн өндөр өсөлтийг үзүүлэв.

Зураг 95. Нийт зээл ба чанаргүй зээл /тэрбум төгрөг/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Чанаргүй зээлийн ангилал дахь муу зээлийн эзлэх хувь 2011–ээс 2013 оныг хүртэл харьцангуй буурсан боловч түүнээс хойш тогтмол өссөөр

тайлант онд 39 хувьд хүрэв. Харин эргэлзээтэй ба хэвийн бус зээлийн нийт чанаргүй зээлд эзлэх хувь өнгөрсөн оноос буурсан байна.

Зураг 96. Чанаргүй зээлийн чанарын үзүүлэлт /эзлэх хувиар/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хэвийн зээл өнгөрсөн оноос 30 хувиар буюу 22 тэрбум төгрөгөөр өсөж 95.7 тэрбум төгрөгт хүрсэн байна. Нийт чанаргүй зээл өнгөрсөн оны тайлант үеэс 2%-аар буурч 4.5 тэрбум төгрөгт хүрчээ. Чанаргүй зээлийг бүрдүүлэгч хэвийн бус, эргэлзээтэй зээл өмнөх оноос буурсан бол муу зээл өнгөрсөн оноос 16 хувиар өсөж 1.7 тэрбум төгрөгт хүрчээ.

Өнгөрсөн 10 жилийн хугацаанд зээлийн эрсдэлийн сангийн нийт зээлд эзлэх хувь 2010 онд хамгийн дээд цэг буюу 7.8 хувьд хүрч байсан бол 2012 онд огцом буурч хамгийн бага буюу 1.4 хувьд хүрч байсан. Ийнхүү 2012–2014 онд тус харьцаа 1 хувийн орчимд хадгалагдаж байсан боловч 2016 он хүртэл өссөөр 3.5 хувьд хүрсэн. Харин тайлант онд 0.6 пунктээр буурч 2.9 хувь болов.

Зураг 97. Нийт хөрөнгө болон зээлийн эрсдэлд орох үзүүлэлт




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Байгууллагын хөрвөх чадварыг илэрхийлэх үзүүлэлтүүд болох мөнгөн хөрөнгө болон нийт хөрөнгийн харьцаа, богино хугацаат хөрөнгө оруулалтын зээл болон нийт хөрөнгийн харьцааг доор тооцон үзүүлээ. Эдгээр үзүүлэлтүүд нь хадгаламж эзэмшигч болон хөрөнгө оруулагч хөрөнгөө татах үед тухайн санхүүгийн байгууллага өөрийн хөрөнгөө мөнгөн хөрөнгөд хэр түргэн хөрвүүлэх боломжтойг харуулдаг. ХЗХ-ны хувьд

сүүлийн 5 жилийн хугацаанд нийт мөнгөн хөрөнгө нийт хөрөнгийн дунджаар 23 хувийг эзэлж байгаа ба тайлант оны хувьд 26 хувьтай байна. Харин богино хугацаат хөрөнгө оруулалт болон нийт зээлийн нийлбэрийг нийт хөрөнгөд харьцуулсан үзүүлэлт сүүлийн 5 жилийн хугацаанд дунджаар 73 хувьтай байгаа бол тайлант онд 69 хувьтай байлаа.

Зураг 98. Хөрвөх чадварын харьцаа



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо







A red pen is positioned diagonally across the page, resting on a document. The document features a grid pattern and some text, including the word 'Tues.' and the number '142.78'. The pen's tip is pointing towards the bottom right. The background is a mix of white and light gray, with the red pen providing a strong contrast.

# VII

БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН  
ОРЧИН

# БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН

## 7.1 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Бодлогын баримт бичиг боловсруулах, хэрэгжилтийг хангасан талаар

2017 онд хөрөнгийн зах зээлийн бодлого, зохицуулалтын чиглэлийн асуудлуудыг төрийн богино болон дунд хугацааны баримт бичгүүдэд тусгуулах ажиллагааг эрчимтэй хэрэгжүүлж, биелэлтийг хангаж ажиллалаа. Жишээлбэл, Төрийн богино хугацааны бодлогын баримт бичиг болох “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”-ийн биелэлтийг ханган ажиллаж, “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн эхний хагас жилийн хэрэгжилтийн биелэлтийг салбарын хүрээнд гаргаж, «Монгол Улсын эдийн засаг, нийгмийн 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл»-д хөрөнгийн зах зээлийн өнөөгийн байдал, 2018 оны хөгжлийн зорилтууд, 2019–2020 оны хөгжлийн төсөөлөл, тулгарч болзошгүй эрсдэл, 2018 онд хүрэх түвшин, үр дүнг тус тус бэлтгэж, хариуцах байгууллагуудад нь хүргүүлсэн.

Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2017 оны А–35/33/64 дүгээр хамтарсан тушаалаар баталсан “Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр»-ийг боловсруулах ажлыг хамтран хэрэгжүүлсэн. Тус хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн Газрын 2017 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 299 тоот тогтоолоор баталсан.

### Хууль, дүрэм журам

Шинээр боловсруулагдаж буй болон нэмэлт өөрчлөлт оруулж буй хуулийн төсөл, журмуудад санал өгч, хамтран ажилласан. Хууль зүйн яамнаас ирүүлсэн “Үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн ажиллагааг Улсын бүртгэлийн газарт шилжүүлэх тухай хуулийн төсөл”, Актив удирдлагын компанийн тухай хуулийн төсөл,

Хувийн тэтгэврийн нэмэлт даатгалын тухай хуулийн төсөл, Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар 2017 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн баригдсантай холбогдуулан тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг, Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яамнаас боловсруулсан «Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийг бүртгэх цахим мэдээллийн санг бүрдүүлэх, мэдээллийг боловсруулах, мэдээлэл өгөх, солилцох, барьцааны мэдэгдлийг бүртгэж дугаар олгох, нийтэд нээлттэй байх болон статистикийн зориулалттай мэдээллийн төрлийг тогтоох журам»-ын төсөл, боловсруулж Сангийн яаманд хүргүүлсэн.

Хорооны зүгээс Монгол Улсын хуулийн этгээд гадаад улсад үнэт цаас гаргах, хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компани гадаад улсын хөрөнгийн биржид үнэт цаасаа давхар бүртгүүлэх, хадгаламжийн бичиг гаргах ажиллагааг идэвхжүүлэх, зохицуулалтын бодлогоор дэмжих зорилгоор Монгол Улсын хадгаламжийн бичгийн суурь үнэт цаасны төрөл, тухайн суурь үнэт цаасны бүртгэл бүхий харьяалах үнэт цаасны зах зээл, улсын жагсаалт болон Монгол Улсад үнэт цаас гаргаж болох гадаадын үнэт цаас гаргагчдад тавих шалгуур, гадаад улсын хөрөнгийн биржийн жагсаалтыг Хорооны 2017 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан.

Ажлын албаны даргын 2017 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 162 тоот тушаалаар баталсан Үнэт цаасны давхар бүртгэлийн журмын төсөл боловсруулах ажлын хэсгээс “Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд Монгол Улсад үнэт цаас гаргах, Монгол Улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй компани гадаад улсад гаргах үнэт цаасыг бүртгэх түр журам»-ын төслийг боловсруулж,

Хорооны 2017 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан. Захиргааны ерөнхий хуулийн дагуу журмыг Хууль зүй, дотоод хэргийн яам хянаж, бүртгэх зохицуулалттай бөгөөд тус яамнаас ирүүлсэн өөрчлөлтийг оруулж, дахин хүргүүлсэн.

Захиргааны ерөнхий хууль 2016 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөх эхэлсэн билээ. Үүнтэй холбогдуулан, Монгол Улсын Хууль зүй, дотоодын хэргийн яамнаас Хорооны батлан гаргасан журам, заавар, аргачлалыг хянаж, холбогдох дүгнэлтийг гаргаж, ирүүлсэн. Энэ дагуу үнэт цаасны зах зээлийн хувьд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй журам, дүрэм, заавар, маягтуудыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэх, цаашид дагаж мөрдөгдөх шаардлагагүй болсон захиргааны хэм хэмжээ тогтоосон актуудыг цэгцлэх, шинэчлэх ажиллагаа хийгдэж байна. Одоогоор хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 56 журмын 33 журмыг нэгтгэж, 4 журам болгож багцлах, 20 журмыг шинэчлэн боловсруулах, 3 журмыг хүчингүй болгохоор төлөвлөж, журмын төслүүдийг боловсруулсан байдал байна. Эдгээр журмын төслүүдэд зах зээлд оролцогч байгууллагууд болох тус журмуудыг хэрэгжүүлж ажилладаг байгууллагуудаас саналыг авч тусгах, тэдгээрийн дунд хэлэлцүүлэг өрнүүлэх замаар шинэчлэн сайжруулж ажиллаж байна.

#### Зах зээлийн хөгжлийг дэмжих хүрээнд

Хорооны даргын 2017 оны 405 тоот тушаалаар “Монголын үнэт цаасны бирж” ХХК-ийн “Тооцооны үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын журам” болон “Дотоод мэдээлэл эзэмшигчдийн үйл ажиллагаанд хяналт тавих журам”-ыг батламжлах үйл ажиллагаа хийгдсэн.

Монгол банкны ерөнхийлөгч, Сангийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд болон Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2015 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн А/142/282/А-404/274 тоот хамтарсан тушаалаар батлагдсан «Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр»-ийн хүрээнд Хорооны Ажлын албаны даргын 2017 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 112 дугаар тушаалаар

ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд уг ажлын хэсэгт Хорооны төлөөлөл оролцсон. Түүнчлэн, тус ажлын хэсгийн төлөөлөл өргөтгөсөн ажлын хэсгийн хуралд тогтмол оролцож ажилласан бөгөөд олон нийтийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх хүрээнд боловсруулсан санхүүгийн зах зээлийн талаарх сургалтын материал, ном, брошур, цахим хуудас зэрэгт Хорооны зүгээс мэдээлэл боловсруулсан.

#### Гадаад, дотоод хамтын ажиллагаа

Засгийн газрын 2016 оны 208 дугаар тогтоолоор батлагдсан “Эдийн засгийг сэргээх хөтөлбөрийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө”-ний стратеги 1-ийн 1.1.5 дахь хэсгийн 6 дугаар заалтын хүрээнд Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 181/297 тоот хамтарсан тушаалаар хөрөнгийн биржээр дамжуулан хийгдэх үнэт цаасны арилжааны төлбөр тооцоог Т+3 хүртэлх горим болон ДВП зарчимд шилжүүлэх талаар санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдаж, ажлын хэсгийн гишүүдээр Сангийн яам, СЗХ, «АТТ» ХХК, «МХБ» ТӨХК, «ҮЦТХТ» ХХК-ийн төлөөллүүд ажиллаж байна. Энэ ажлын хэсгийн хүрээнд «АТТ» ХХК-ийн шинээр боловсруулагдах шаардлагатай журмуудыг боловсруулж, батлуулан СЗХ-нд батламжлуулахаар ирүүлээд байна. Мөн эдгээр журмын төслүүдэд Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкны төслийн зөвлөхүүдээс өгсөн саналыг судалж, цаашид Дэлхийн Банкны зөвлөхөөс санал авах замаар уг журмуудыг сайжруулахаар ажиллаж байна.

Монголбанк, Сангийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Санхүүгийн зохицуулах хороо хамтран Дэлхийн банкны техник туслалцааны дэмжлэгтэйгээр “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх дунд хугацааны хөтөлбөр”-ийн хүрээнд олон нийт болон холбогдох байгууллагуудад танилцуулах хэлэлцүүлгийг 2017 оны 3 дугаар сард Төрийн ордны “Иргэний танхим”-д зохион байгуулсан.

Санхүүгийн зохицуулах хорооноос Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт болон Монголын хуульчдын холбоотой хамтран үнэт

цаасны зах зээлд оролцогчдод үйлчилгээ үзүүлэх хуульч, аудиторуудад зориулсан сургалтыг 2017 онд нийт 3 удаа зохион байгуулсан бөгөөд сургалтын агуулга, хөтөлбөр, шалгалтын материал зэргийг шинэчилж, сургалтын зохион байгуулалтыг сайжруулж ажилласан. Сургалтад нийт 174 иргэн хамрагдсан байна.

Сангийн сайдын 2016 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 379 тоот тушаалаар байгуулагдсан “Эрдэнэс Таван толгой ХК-ийн 1072 ширхэг хувьцааны талаарх асуудлыг эдийн засгийн агуулгаар нь шийдвэрлэх” ажлын хэсэгт Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, “Эрдэнэс Монгол” ХК, “Эрдэнэс Таван толгой” ХК, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-уудын төлөөллүүд багтан ажиллаж байна. Ажлын хэсэг 2017 онд 1 удаа хуралдсан бөгөөд ажлын хэсгийн ахлагч өмнөх уулзалтуудаар хэлэлцэж, шийдвэрлэсэн асуудлуудыг багцлан, холбогдох газруудад өгсөн үүрэг даалгаврыг тодорхойлсон Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулснаа тус уулзалтаар танилцуулсан. Тус тогтоолын төсөлд ажлын хэсгийн гишүүдийн саналыг тусгасан бөгөөд Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 154 дүгээр тогтоол болон батлагдсан.

Япон Улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага /Жайка/-ын “Хөрөнгийн зах зээлийн чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийн багтай хамтран 2017 оны 5 дугаар сарын 12-ны өдөр “Үнэт цаасыг олон нийтэд санал болгох үйл ажиллагаа болон давхар бүртгэл” сэдэвт 3 дахь удаагийн семинар, 2017 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр “Япон улс хөрөнгө оруулагчийг хамгаалах санг хэрхэн байгуулсан талаарх туршлага, түүний хамрах хүрээ, зохицуулалтын талаарх семинар» – ыг зохион байгуулсан.

Япон Улсын Жайка байгууллагаас Хороотой хамтран хэрэгжүүлж буй «Хөрөнгийн зах зээлийн чадавхыг бэхжүүлэх» төслийн хүрээнд “Хөрөнгийн зах зээлийн сурах бичиг”-ийг боловсруулан хэвлэсэн юм. Энэхүү сурах бичиг нь Япон улс болон олон улсын стандартын дагуу боловсруулагдсан бөгөөд тус сурах бичиг хэвлэгдэн гарснаар хөрөнгө оруулагч, харилцагч,

аж ахуйн нэгжүүд санхүүгийн хэрэгсэл гаргахад шаардлагатай мэдээ, мэдээллээр хангагдах боломж бүрдэж, хөрөнгийн зах зээлд том хувь нэмэр үзүүлж чадна гэж үзэж байна.

Дэлхийн банк, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо хамтран 2017 оны 5 дугаар сарын 09-ний өдөр «Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн зарчмууд» сэдэвт сургалт зохион байгуулсан.

Люксембургийн санхүүгийн мэргэжлийн сургалтын «House of Training» байгууллагын зүгээс Санхүүгийн зохицуулах хороотой хамтран 2017 оны 6 дугаар сарын 05-ны өдрөөс 6 дугаар сарын 09-ний өдрүүдэд “Олон улс дахь хөрөнгө оруулалтын сангийн эрх зүйн зохицуулалт, биржээр арилжаалагддаг сан /ETF/” сэдэвт сургалт зохион байгуулсан.

Сангийн яам болон Европын сэргээн босголт, хөгжлийн банк хамтран “Монгол Улсын мөнгөний болон хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх стратеги” боловсруулах техник туслалцааны хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд тус төслийн зөвлөх баг болох Японы Хөрөнгийн бирж болон Номура судалгааны хүрээлэнгийн хамтарсан багаас урьдчилсан байдлаар хөрөнгийн зах зээлд тулгамдаж буй асуудал болон цаашид зах зээлийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөөг боловсруулахаар Хороо болон мэргэжлийн байгууллагуудтай уулзалт хийж, холбогдох тайлангийн төслийг танилцуулж, хамтран ажилласан.

## 7.2 ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

### Зах зээлийг чадавхжуулж, хүртээмжийг нэмэгдүүлэх

Даатгалын тухай, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай болон Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах төслүүдийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, санал гаргасан.

Орон сууцны ипотекийн зээлдэгчдийг хүртээмжтэй, оновчтой хэлбэрээр даатгалд хамруулах чиглэлээр судалгаа хийж, саналыг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн ээлжит хуралд танилцуулан холбогдох шийдвэрийг гаргуулсан.

“Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл” Үндэсний хэлэлцүүлэг, 2017 оны 6 дугаар сарын 08–ны өдөр “Хувийн тэтгэврийн нэмэлт даатгалын тухай хуулийн үзэл баримтлал болох хуулийн төсөл”-ийн хэлэлцүүлэгт оролцож санал солилцож, холбогдох саналаа хүргүүлсэн.

#### Зохистой зохицуулалтын тогтолцоог бий болгох

Даатгалын компанийн үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналт, шалгалт хэрэгжүүлэх журмыг боловсруулж туршилтаар хэрэгжүүлж эхлээд байна.

Даатгалын багц дүрмийг Захиргааны ерөнхий хуультай нийцүүлэн холбогдох төслийг Хорооны цахим хуудаст байршуулж олон нийт, даатгалын салбарт оролцогчдоос саналыг цахимаар болон албан бичгээр хүлээн авч, нэгтгэн, хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 03–ны өдрийн 299 дүгээр тогтоолоор “Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг баталсан.

“Жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа даатгагчаас жолоочийн даатгалын санд 2017 онд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг тогтоох тухай” Хорооны дарга, Сангийн сайдын 2017 оны 6 дугаар сарын 15–ны өдрийн 313/203 тоот хамтарсан тушаал батлагдсан.

#### Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтрах

МДХ, МДЗХ болон МХҮХ–тай хамтран даатгалын мэргэжлийн оролцогчдод зориулсан сургалтыг 6 удаа нийслэл болон орон нутагт зохион байгуулсан.

Даатгалын багц дүрмийн өөрчлөлтөд мэргэжлийн холбоодоор дамжуулан холбогдох саналыг авч 2017 оны 11 дүгээр сард хэлэлцүүлэг зохион байгуулж иргэд олон нийтээс санал авсан.

Хороо, Сангийн яам болон мэргэжлийн холбоодтой хамтран даатгалын тухай хууль, тогтоомжид өөрчлөлт оруулах тухай хэлэлцүүлгийг 2017 оны 2 дугаар сард хамтран зохион байгуулсан.

ХБНГУ–ын GIZ төслийн хүрээнд 2017 оны 11 дүгээр сараас эхэлсэн Хүртээмжтэй даатгал / inclusive insurance lab/ хөтөлбөрийн оролцогчоор Хорооны холбогдох төлөөлөл, МДХ болон МДЗХ–ны төлөөлөл оролцож байна.

ХБНГУ–ын GIZ төслийн хүрээнд Азийн орнуудад хүртээмжтэй даатгалыг хөгжүүлэх бүс нутгийн хөтөлбөрийн хүрээнд 2018 оны 1 дүгээр сард Филиппин улсад зохион байгуулагдсан төр, хувийн хэвшлийн хамтарсан 4 дэх уулзалтад Холбооны ерөнхийлөгчийг оролцуулсан.

Хороо, МДХ болон Монголын актуарчдын нийгэмлэгтэй хамтран Актуарын сургалтыг 2016 оны 6 дугаар сард хамтран зохион байгуулсан.

МХҮХ–оос 2018 оны 2 дугаар сард зохион байгуулсан даатгалын тухай хууль, тогтоомжид өөрчлөлт оруулах тухай хэлэлцүүлэгт СЗХ–оос оролцсон.

МХҮХ–оос 2018 оны 1 дүгээр сард Хүний амь насны үнэлгээтэй холбоотой асуудлаар хамтарсан хэлэлцүүлэг зохион байгуулах санал гаргасан бөгөөд, хүлээгдэж байна.

#### Иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх

Даатгалын сургалт явуулах, даатгалын мэргэжлийн эрх олгох сургалттай холбоотой харилцааг зохицуулсан журмыг шинэчлэн боловсруулсан.

Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох сургалтыг Монголын даатгагчдын холбоотой хамтран зохион байгуулж, тусгай зөвшөөрөл олгох шалгалтыг авч, дүгнэсэн.

Даатгалын байгууллага, иргэдээс ирүүлсэн 280 өргөдөл хүсэлтийг хүлээн авч, 210 өргөдөл хүсэлтийг бүрэн шийдвэрлэж, 21 өргөдөл, хүсэлтийг хянаж байна. 49 хүсэлтийг буцаасан.

#### Зохицуулалттай этгээдийг чадавхжуулах

Германы олон Улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)–ийн Азийн бичил даатгалын зах зээлийн зохицуулалтын тогтолцоог дэмжих хөтөлбөрийн «Бизнесийн загвар» ажлын хэсгийг

2017 оны 3 дугаар сараас эхлэн ахлаж байгаа ба 7 хоног бүрийн Лхагва гарагт скайп уулзалтыг зохион байгуулж байна.

Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогч, даатгуулагч болон мэргэжлийн холбоодын төлөөллийг оролцуулсан “Үндэсний баг”-ийг 8 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, багийн гишүүд хөтөлбөрт оролцогч Олон Улсын зөвлөхтэй 2017 оны 11 дүгээр сард анхны уулзалтыг зохион байгуулсан.

### 7.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

#### Бодлого, зохицуулалтын чиглэлээр

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийг УИХ-аас анх 2002 онд баталсан ба уг хуулийг шинэчлэн найруулж банк бус санхүүгийн байгууллагуудыг бие даасан, тогтвортой, өрсөлдөх чадвар, эрсдэлийг давах чадвартай мэргэжлийн санхүүгийн байгууллага болгох зорилготойгоор банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх илүү таатай нөхцөлийг бий болгох, үйл ажиллагааны цар хүрээг тэлсэн, дэвшилтэт технологийг ашигласан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжсэн харилцагч, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалсан хууль эрх зүйн орчинг бүрдүүлэхээр ажиллаж байна.

Санхүүгийн зохицуулах хорооноос банк бус санхүүгийн байгууллагуудыг чадавхжуулах, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх бодлого явуулсан билээ. Үүний үр дүнд 2017 оны дөрөвдүгээр улирлын байдлаар салбарын нийт актив 969.2 тэрбум төгрөгт хүрч, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 595.4 тэрбум төгрөгт хүрээд байна. Түүнчлэн банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн жигнэсэн дундаж хүү сүүлийн улирлуудад буусаар байгаа ба 2017 оны дөрөвдүгээр улиралд 3.37 хувь болж буурлаа.

Түүнчлэн “Зээлийн батлан даалтын сангийн журам”-ын төслийг боловсруулах ажлын хэсэг гарсны дагуу холбогдох газруудын саналыг авч холбогдох судалгааг хийсний үндсэн дээр журмын төслийг боловсруулаад байна. Мөн

гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг банк бус санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааг нарийвчлан судлах ажлыг эхлүүлж эрэлтийн болон зардлын судалгаа боловсруулж дээрх төрлийн үйл ажиллагаа дагнан эрхэлдэг банк бус санхүүгийн байгууллагуудаас судалгааг аваад байна. Үүнтэй холбоотойгоор гадаад валютын арилжаа эрхлэх хуулийн этгээдийн зохицуулалт хяналтын журмын төсөл, гадаад валютын арилжаа эрхлэх хуулийн этгээдийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журмуудын төслийг боловсрууллаа. Түүнчлэн 11 дүгээр сарын 23-ны өдөр Монголын банкны холбооноос зохион байгуулсан «ЖДБ-ын санхүүгийн хүртээмж форум»-д оролцож ЖДБ-уудын санхүүгийн хүртээмжийг ББСБ-уудаар дамжуулан зээлдүүлэх зээлийн болон өөр бусад аргаар нэмэгдүүлэх тухай судалж, саналаа илэрхийлэв.

#### Сургалт, семинар, хамтын ажиллагаа

Санхүүгийн зохицуулах хороо, Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо хамтран шинээр тусгай зөвшөөрөл авч буй банк бус санхүүгийн байгууллагуудын удирдлагуудад зориулсан “Банк бус санхүүгийн байгууллагуудын сертификатжуулах сургалт”-ыг 2017 оны 11 дүгээр сарын 15-наас 17-ны өдрүүдэд ээлжит удаагаа зохион байгуулж нийт 23 банк бус санхүүгийн байгууллагуудын удирдлагуудыг хамрууллаа. Уг сургалтаар банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны онцлог, хууль эрх зүйн орчин, хяналт зохицуулалт, банк бус санхүүгийн байгууллагын нягтлан бодох бүртгэл, тайлагнал, олон улс дахь бичил санхүүгийн салбарын хөгжил, өнөөгийн түвшин, банк бус санхүүгийн байгууллагын нийгмийн хариуцлага, харилцагчийн үйлчилгээ, үйлчилгээний байгууллагын стандарт зэрэг зайлшгүй шаардлагатай мэдлэг олгоход чиглэгдсэн мэдээллийг банк бус санхүүгийн байгууллагуудын удирдах албан тушаалтнуудад нэгдсэн байдлаар өгөх зорилготой.

Мөн 11 дүгээр сарын 15-ны өдөр БНСУ-ын Сөүл хотод Олон Улсын финтекийн семинар зохион байгуулагдсан ба үүнд ББСБ-ын газраас оролцож туршлага солилцлоо. Уг семинарт



зохицуулагч байгууллагуудын финтек буюу дэвшилтэт технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ, түүний зохицуулалт, зохицуулагч байгууллагуудад уг асуудлаар тулгарч буй хүндрэлүүд зэргүүдийг хэлэлцсэн ба Сингапур, Япон, Герман, Их Британи, БНХАУ, Тайланд, Индонези, БНСУ, Вьетнам, Тайван зэрэг технологи хөгжсөн орнууд, Дэлхийн банк, Үнэт цаасны хороод зэрэг олон Улсын төлөөлөл оролцсон.

Дархан–Уул аймгийн иргэд, зохицуулалттай этгээдүүд, тэдгээрийн салбар төлөөлөгчийн газрын ажилтнууд, хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагуудын удирдах ажилтнуудад Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааг танилцуулж, зохицуулалтын салбарын талаарх мэдээ, мэдээлэл, Монгол Улсын санхүүгийн зах зээлийн талаар холбогдох мэдээлэл, мэдлэгийг олгох чиглэлээр 2017 оны 11 дүгээр сарын 23, 24–ний өдрүүдэд Хороо, Хорооны Дархан–Уул аймаг дахь төлөөлөлтэй хамтран сургалт зохион байгуулсан ба сургагч багшаар ББСБ–ын газрын төлөөлөл танилцуулга хийлээ.

## 7.4 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2017 оны А–35/33/64 дүгээр хамтарсан тушаалаар баталсан “Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”–ийг боловсруулах ажлыг хамтран гүйцэтгэсэн. Тус хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн Газрын 2017 оны 10 дугаар сарын 03–ны өдрийн 299 тоот тогтоолоор баталсан. ХЗХ–ны салбарын талаар уг хөтөлбөрт орсон зорилтуудаас 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган ажиллахаар төлөвлөв.

Захиргааны ерөнхий хууль 2016 оны 7 дугаар сарын 01–ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан Монгол Улсын Хууль зүй, дотоодын хэргийн яамнаас Хорооны батлан гаргасан журам, заавар, аргачлалыг хянаж, холбогдох дүгнэлтийг гаргаж,

ирүүлсэн. Энэ дагуу салбарт хүчин төгөлдөр мөрдөгдөж буй журам, дүрэм, заавар, маягтуудыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэх, шинэчлэх ажиллагаа хийгдэж байна. Ажлын хэсэг журам, заавруудад холбогдох өөрчлөлтүүдийг хийж “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохицуулалтын журам”, “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт болон дагаж мөрдөх үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”, “Хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоонд тавигдах нөхцөл шаардлага”–ын төслийг Хорооны сайтад байршуулж, улмаар МХЗХҮХ болон ХЗХ–доос ирүүлсэн саналыг журмын төсөлд тусгав.

АХБ–ны техник туслалцааны хүрээнд ХЗХ–ны гишүүдийн хадгаламжийг хадгаламжийн даатгалд хамруулах, тогтворжилтын сангийн тогтолцоог бий болгох замын зураглал гаргах, шаардлагатай тоон мэдээллийг боловсруулах, зөвлөхөөс өгсөн зөвлөмж, тайланд санал хүргүүлэх, холбогдох байгууллагуудтай уулзалт зохион байгуулах, холбогдох судалгааны ажлуудыг гүйцэтгэв. Мөн 2017 оны 10 дугаар сард нийт ХЗХ–дыг хамруулсан форумыг зохион байгуулж салбарын талаарх олон улсын чиг хандлагын талаар, цаашдын хөгжлийн үе шатын талаар хэлэлцүүлэн танилцуулсан.

ХЗХ–ны гишүүдийн хадгаламжийг даатгалд хамруулах чиглэлээр одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа «Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль»–д нэмэлт өөрчлөлт оруулуулахаар санал боловсруулж, танилцуулга бэлтгэв.

Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог нэвтрүүлэх чиглэлээр «Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд зайнаас хяналт тавих журам»–ын төслийг боловсруулав.

Монголбанкны ерөнхийлөгч, Сангийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд болон Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2015 оны 10 дугаар сарын 07–ны өдрийн А/142/282/А–404/274 тоот хамтарсан тушаалаар батлагдсан «Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр»–ийн хүрээнд Хорооны Ажлын албаны даргын 2017 оны 6

дугаар сарын 23-ны өдрийн 112 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд уг ажлын ажлын хэсэгт Хорооны төлөөлөл оролцсон. 2017 оны 11 дүгээр сард Хороо Дархан-Уул аймгийн ЗДТГ-тай хамтран олон нийтэд чиглэсэн сургалт зохион байгуулсан бол 2017 оны 5-10 сард ХЗХ-дыг чадавхжуулах удирдлагуудад зориулсан сургалтыг бүсчлэн зохион байгуулж олон нийтийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийн хүрээнд боловсруулсан санхүүгийн зах зээлийн талаарх сургалтын материал, ном, брошур, цахим хуудас зэргийг сурталчлан таниулсан.

ХЗХ-дыг хямд эх үүсвэртэй бөөний зээлд хамруулах, хөдөө орон нутагт санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Бичил санхүүгийн хөгжлийн сангийн зээлд хамруулахаар Сан болон Хорооноос хамтарсан ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсэг хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй ХЗХ-дын судалгаа, бөөний зээлд тавигдах нөхцөл шаардлагын саналыг боловсруулаад байна. БСХСангаас бөөний зээлд зарцуулах санхүүжилтийн асуудал шийдвэрлэгдэх үед ХЗХ-дод зээл олгох бүрэн боломжтой болов. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд төсөл хөтөлбөрийг бичил санхүүгийн байгууллагаар дамжуулан хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, ХЗХ-дыг бөөний зээлд хамруулах, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг хүргүүлэв.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих бөөний зээлийг бичил санхүүгийн байгууллагаар дамжуулан олгохтой холбогдуулан Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг хүргүүлэв.

АХБ-наас хэрэгжиж байгаа төсөлтэй холбоотойгоор АХБ-ны Ази номхон далайн

орнуудыг хариуцсан санхүүгийн ахлах мэргэжилтэнтэй уулзалт зохион байгуулж, төслийг үргэлжлүүлэх шийдэлд хүрэв. Төслийн үргэлжлэл болох 2 дугаар хэсгийн саналыг боловсруулж, удирдлагуудад танилцуулан АХБ-нд хүргүүлэв. ФАТФ-аас гаргасан зөвлөмжийн дагуу хийгдсэн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны үр дүнг дүгнэх ажлын хүрээнд холбогдох тайлбаруудыг бэлтгэн хүргүүлсэн. НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс БНАСАУ-тай холбоотой хориг арга хэмжээний талаарх мэдээллийг нийт ХЗХ-нд хүргэв.

Хороо нь Олон улсын хадгаламж, зээлийн хоршооны зохицуулагчдын зөвлөлийн гишүүн болсон бөгөөд 2017 оны 7 дугаар сард Хорооны дэд дарга тэргүүтэй 5 хүний бүрэлдэхүүнтэй баг Канад улсын Ванкувер хотноо болсон Олон улсын хадгаламж, зээлийн хоршооны зохицуулагчдын зөвлөлийн хуралд /ICURN/-д оролцсон. Уг хурлаар хяналт шалгалтын зарчмууд, цахим аюулгүй байдал, хоршоодын засаглал, технологид суурилсан санхүүгийн арга хэрэгсэл, бэлэн мөнгөний гүйлгээг багасгах арга зам болон тус тусын бүс нутаг тус бүрт нутгийн хэмжээнд учирч буй тулгамдаж буйсан асуудал, мөн хоршоодын санхүүгийн салбарын хөгжилд үзүүлэх нөлөө болон санхүүгийн хүртээмж зэрэг олон чухал асуудлыг хэлэлцэж, арга туршлага солилцов.

## ХАВСРАЛТ

Хавсралт 1: Хөрөнгийн зах зээлийн статистик үзүүлэлт /тэрбум төгрөг/

Огноо	2012	2013	2014	2015	2016	2017
Зах зээлийн үнэлгээ	1,799.9	1,670.5	1,442.6	1,262.5	1,474.2	2,440.2
ЗЗҮ-ний ДНБ-д харьцуулсан хувь	10.7%	8.7%	6.5%	5.5%	6.2%	9.0%
Хөрвөх чадвар	8.0%	5.9%	1.7%	2.4%	3.3%	3.2%
Топ-20 индекс /жилийн дундаж/	16,839.1	15,874.0	14,833.0	12,279.0	11,605.7	22,108.6
Бүртгэлтэй компанийн тоо	328	323	304	299	302	300
Брокер, дилерын тоо	95	87	66	62	62	52
Хөдөө аж ахуйн биржийн арилжааны дүн	-	403.7	554.1	431.7	463	572.5
Анхдагч зах зээлийн арилжаа						
Хувьцаа	0.9	-	2	20.1	6.2	2.9
ЗГҮЦ	-	-	36.1	510.3	280.45	630.2
Компанийн бонд	-	-	-	0.5	-	6
Хоёрдогч зах зээлийн арилжаа						
Хувьцаа	143.8	97.6	22.2	10.4	42.9	75.2
ЗГҮЦ	0.001	1.01	-	5.12	19.1	142.3
Компанийн бонд	0.31	-	-	0.002	-	4.2

Хавсралт 2. Даатгалын зах зээлийн статистик үзүүлэлт /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016	2017
<b>Хөрөнгө (тэрбум төгрөг)</b>						
Нийт хөрөнгө	107.35	126.42	152.54	173.20	208.42	244.74
Ердийн даатгалын компаниудын нийт хөрөнгө	102.67	120.80	146.04	139.51	165.85	193.58
Урт хугацааны даатгалын компанийн нийт хөрөнгө	4.68	5.63	6.50	7.63	7.52	7.77
Давхар даатгалын компанийн нийт хөрөнгө				26.06	35.04	43.39
Нийт хөрөнгийн өсөлт	32.15%	17.77%	20.66%	13.55%	20.33%	17.43%
<b>Хураамжийн орлого (тэрбум төгрөг)</b>						
Хураамжийн нийт орлого	78.76	93.92	108.75	114.31	114.50	144.34
Ердийн даатгалын компаниудын хураамжийн нийт орлого	77.97	92.89	107.31	112.21	111.68	141.18
Урт хугацааны даатгалын компанийн хураамжийн нийт орлого	0.80	1.03	1.44	1.65	1.27	1.31
Давхар даатгалын компанийн хураамжийн нийт орлого				0.45	1.56	1.85
<b>Нөхөн төлбөр (тэрбум төгрөг)</b>						
Нийт нөхөн төлбөр	16.95	26.52	31.48	32.97	34.29	45.24
Ердийн даатгалын компаниудын нийт нөхөн төлбөр	16.75	26.27	30.86	32.02	33.40	44.33
Урт хугацааны даатгалын компанийн нийт нөхөн төлбөр	0.20	0.26	0.62	0.95	0.89	0.91
Давхар даатгалын компанийн нийт нөхөн төлбөр				0.00	0.005	0.00
<b>Нөөц сан (тэрбум төгрөг)</b>						
Нөөц сан	48.78	60.41	66.11	72.83	93.04	118.05
Ердийн даатгалын компаниудын нийт нөөц сан	48.22	59.48	64.81	63.77	78.10	96.60
Урт хугацааны даатгалын компанийн нийт нөөц сан	0.57	0.93	1.30	1.47	1.53	1.56
Давхар даатгалын компанийн нийт нөөц сан				7.59	13.41	19.90
<b>Давхар даатгалын хураамж (тэрбум төгрөг)</b>						
Давхар даатгалын хураамж	20.68	26.03	31.58	42.14	37.21	46.59
Ердийн даатгалын компаниудын давхар даатгалын хураамж	20.64	25.97	31.56	41.93	37.18	45.76
Урт хугацааны даатгалын компанийн давхар даатгалын хураамж	0.04	0.06	0.02	0.02	0.02	0.02
Давхар даатгалын компанийн давхар даатгалын хураамж				0.19	0.00	0.80

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016	2017
Цэвэр ашиг (тэрбум төгрөг)						
Цэвэр ашиг	6.04	4.74	2.08	6.95	11.41	13.20
Ердийн даатгалын компаниудын цэвэр ашиг	6.17	4.81	2.04	4.60	8.46	8.70
Урт хугацааны даатгалын компанийн цэвэр ашиг	-0.12	-0.08	0.04	0.24	0.18	0.18
Давхар даатгалын компанийн цэвэр ашиг				2.11	2.78	4.32
Цэвэр ашигийн өсөлт	-27.95%	-21.61%	-56.04%	233.77%	64.25%	15.66%
Мэргэжлийн оролцогчид (тоо, ширхэг)						
Ердийн даатгал	17	16	16	15	15	15
Урт хугацааны даатгал	1	1	1	1	1	1
Давхар даатгал				1	1	1
Даатгалын төлөөлөгч	2357	3187	3260	3340	3091	2893
Даатгалын зуучлагч	17	20	30	37	40	42
Хохирол үнэлэгч	9	14	20	27	31	29
Актуарч	18	15	15	15	15	21
Аудитор	43	69	84	124	126	130
Аудитын компани	16	22	30	40	42	42

Хавсралт 3. ББСБ-ын салбарын статистик үзүүлэлт /тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2012	2013	2014	2015	2016	2017
Нийт хөрөнгө	252.1	379.7	508.0	623.2	787.2	969.2
Эргэлтийн хөрөнгө	242.8	367.2	490.5	600.4	754.3	932.7
Мөнгөн хөрөнгө	66.7	113.1	156.0	174.2	243.1	264.1
Богино хугацаат хөрөнгө оруулалт	2.2	9.9	11.0	11.9	1.3	2.7
Нийт зээл	157.8	223.7	303.1	391.2	478.2	638.0
Хэвийн зээл	147.1	205.1	263.1	330.7	392.0	527.0
Хугацаа хэтэрсэн зээл	4.2	10.1	20.8	22.2	26.7	29.9
Чанаргүй зээл	6.5	8.5	19.2	38.3	59.5	81.1
Зээлийн эрсдэлийн сан	4.5	6.4	15.2	26.6	42.1	56.0
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө (цэврээр)	0.9	0.8	1.3	2.7	4.5	8.1
Эргэлтийн бус хөрөнгө	9.3	12.5	17.5	22.8	32.9	36.5
Нийт өр төлбөр	80.8	146.8	175.9	199.0	208.7	211.0
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	14.1	19.1	25.7	31.2	30.5	39.2
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	46.1	90.2	123.6	125.9	121.4	112.8
Төслийн зээлийн санхүүжилт	8.0	11.9	12.5	15.0	21.4	14.9
Эзэмшигчдийн өмч	171.3	232.9	332.1	424.2	578.5	758.2
Хоёрдогч өглөг	1.6	1.6	2.4	1.4	1.0	0.7
Хувьцаат капитал	139.2	182.3	258.2	308.5	440.5	595.4
Хуримтлагдсан ашиг	24.2	41.7	64.0	102.0	130.4	155.1
ББСБ-ын тоо	212	263	378	450	518	534
Үүнээс: УБ хот	188	232	338	400	458	464
Хөдөө, орон нутаг	24	31	40	50	60	70
Харилцагчдын тоо	594,151	663,098	636,341	449,131	592,461	1,471,099
Нийт орлого	70.5	106.6	132.9	156.1	193.4	195.9
Хүүгийн орлого	45.7	66.1	89.9	119.8	135.6	161.9
Хүүгийн бус орлого	23.3	39.3	41.7	33.4	54.4	27.3
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	1.1	1.1	1.3	3.0	3.5	6.7
Нийт зардал	51.9	76.8	96.5	109.7	134.4	129.1
Хүүгийн зардал	6.5	9.6	12.9	14.9	15.4	14.2
Хүүгийн бус зардал	39.5	58.8	66.7	71.3	88.9	79.3
Болзошгүй эрсдэлийн зардал	2.3	3.4	11.4	16.4	21.2	24.4
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	1.0	1.2	1.0	0.9	1.9	2.2
Цэвэр ашиг	18.6	29.8	36.4	46.4	59.0	66.8

Хавсралт 4. ХЗХ-дын салбарын статистик үзүүлэлт /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016	2017
Нийт хөрөнгө	67.7	73.8	80.5	97.7	113.1	153.1
Мөнгөн хөрөнгө	15.9	20.6	15.0	18.2	24.2	40.0
Нийт зээл	48.3	49.4	61.5	75.3	83.5	105.2
Хэвийн зээл	46.0	46.6	57.8	69.0	73.7	95.7
Хугацаа хэтэрсэн зээл	1.3	1.2	2.1	2.9	5.2	5.0
Чанаргүй зээл	1.1	1.5	1.6	3.5	4.5	4.5
Эргэлтийн бус хөрөнгө	1.6	2.1	2.3	2.5	2.5	3.6
Өр төлбөр	51.3	54.8	60.8	76.1	88.6	123.2
Хадгаламж	47.1	50.7	55.0	59.3	67.5	99.3
Богино хугацаат зээл	1.0	0.4	0.7	4.3	3.0	3.9
Урт хугацаат өр төлбөр	0.5	0.5	3.7	11.2	12.5	12.8
Бусад богино хугацаат өр төлбөр	2.7	3.2	3.7	4.3	5.0	7.1
Өөрийн хөрөнгө	16.4	19.0	19.7	21.6	24.5	30.0
Гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	9.4	9.8	10.0	10.6	11.7	14.9
Хоршоологчдын өмч	6.9	8.7	9.2	10.6	12.2	14.9
Хуримтлагдсан орлого /алдагдал/	0.0	5.5	5.2	5.5	6.5	7.6
Нийт орлого	16.6	17.6	18.9	21.8	24.5	31.8
Хүүгийн орлого	15.4	16.9	18.4	21.0	23.8	30.2
Үйл ажиллагааны бусад орлого	0.7	0.3	0.3	0.3	0.4	0.7
Үйл ажиллагааны бус орлого	0.4	0.4	0.3	0.4	0.5	1.0
Нийт зарлага	12.7	13.5	15.0	18.5	20.6	26.3
Хүүгийн зардал	8.3	8.9	9.8	11.0	12.5	16.2
Болзошгүй эрсдэлийн сангийн зардал	0.3	0.6	0.5	1.4	1.4	1.4
Үйл ажиллагааны зардал	3.0	3.4	4.2	5.6	6.5	8.0
Үйл ажиллагааны бус зардал	0.6	0.1	0.1	0.1	0.1	0.2
Нийт ашиг	3.8	4.1	4.0	3.2	3.9	5.5
ХЗХ-дын тоо	148	141	159	253	280	290
ХЗХ-дын тооны өсөлт	-8.6%	-4.7%	12.8%	59.1%	10.7%	3.6%
УБ дахь ХЗХ-дын тоо	64	57	77	166	184	192
Орон нутаг дахь ХЗХ-дын тоо	84	84	82	87	96	98
Гишүүдийн тоо	26,004	27,245	30,698	39,146	46,183	55,624
Гишүүдийн тооны өсөлт	-3.3%	4.8%	12.7%	27.5%	18.0%	20.4%



Цахим хуудас

[www.frc.mn](http://www.frc.mn)



Холбоо барих

51-264444



САНХҮҮГИЙН  
ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО

# МЭДЭЭЭЛЛИЙН СУРВАЛЖ

СТАТИСТИК МЭДЭЭЛЛҮҮД АВАХЫГ ХҮСВЭЛ



[WWW.FACEBOOK.COM](http://WWW.FACEBOOK.COM)

САНХҮҮГИЙН  
ЗОХИЦУУЛАХ ХОРОО



[WWW.TWITTER.COM](http://WWW.TWITTER.COM)

САНХҮҮГИЙН  
ЗОХИЦУУЛАХ ХОРОО





